BADARCH NYAMAA

# THE COINS OF MONGOL EMPIRE AND CLAN TAMGHA OF KHANS (XIII-XIV)

ULAANBAATAR, MONGOLIA
2005

# CONTENT


Foreword 15

CHAPTER ONE: THE COINS OF MONGOL EMPIRE AND CLANS TAMGHAS OF GREAT KHANS

1. Clan tamghas on the coins of Great Khans 21
   - 1.1 Tamgha on coins of Genghis Khan 29
   - 1.2 Tamgha of Zuchi Khan 36
   - 1.3 Tamghas on coins of Ugedei Khagan 41
   - 1.4 Thamghas on coins of Chaghatay Khan 53
   - 1.5 About the coin of Duwa Khan 56
   - 1.6 Tului's tamgha 58
   - 1.7 The tamgha on coins of Munghe Khan 59
   - 1.8 The tamgha on coins of Ariq Buga 63
   - 1.9 The tamgha of Ilkhan Hulagu's coin 65
   - 1.10 Ugedie's Ulus or period of Qaidu Khan 73
   - 1.11 Undetermined tamghas on coins of Mongol Khans 77
   - 1.12 The tamghas of Genghis Khan's clan 84
   - 1.13 The clan tamghas on personal seals of Mongol Khans 85
   - 1.14 Shapes and figures on coins of Mongol Khans 95

2. The mongol writing on coins of Khans is a monument of ancient history and culture 100
   - 2.1 The coins of Great Mongol Khans 101
   - 2.2 In the Golden Horde 103
   - 2.3 In Chaghatayids 106
   - 2.4 In Ilkhanids 107
   - 2.5 Yuan Dynasty 114

3. The golden coin of Genghis Khan 115
4. The coins struck in "Great Horde" 121
5. Da Chao Tong Bao coin 124
6. The coin of Kara Khorum 128
7. By the Power of Heaven 135
8. Brief on coins of Ghazan Khan 137
9. Silver coated copper "Ke" coin of Bukhara 142
10. The coins of Jungar 144
11. The ornaments of coins of Mongol Empire 148

CHAPTER 2: MY COLLECTION (COINS OF MONGOL EMPIRE XIII-XIV CENTURY)

1. Great Mongol Khans 155
2. Chaghatayids 171
3. The Golden Horde 171
4. Ilkhanids 193
5. Yuan Dynasty 211
6. Jungar 246

References 250

# ACKNOWLEDGEMENT

I spent a lot of time to write this book. For the last five years I felt that it is not a very easy job to search for coins that relate to the period of 800 years ago and of which hardly anyone knows, to identify and to interpret inscriptions of coins, especially in ancient Turkish, Mongol, Arabic and Persian languages written by Kuphic, Sogd, Uighur, Phags-pa scripts and Chinese characters, to resolve and clarify every dot on these coins, which eroded and blurred as well as became rusty and deteriorated over the time.

The books and a computer, two gracious and invaluable friends helped me. However, the help and assistance of people was more precious and should be mentioned hereto.

I would like to extend my sincere gratitude to my wife D.Urtnasan who was next to me days and nights, covered me with my warm sweater and treasured me with her love, to Biligzaya and Nansal who carried me warm tea, to Undram, Nomundary who assisted me with my correspondence as well as with other works, to Amirdash who helped to get acquainted with computers and to my granddaughter Orkhon Udval who "created this book" with me while sitting on my lap and babbling.

I am much obliged to my brothers and sisters, relatives and elders who helped me with everything they could do and calmly waited "when the book will be ready?". Also thank you to my mother-in-law O.Norov and son H.Sonom-Ochir.

I am thankful from the bottom of my heart to my father-in-law D.Dondog who used to tell me his wise words and advise on many things when he was alive.

I am grateful to Chuluun Chinbat, Sanjmyatav Narantsetseg, Dechin Ganbat, Dugarsuren Tungalag, Luvsanbaldan Enkhtuya, Luvsanbaldan Enkhsaikhan, Tsend Batsaikhan, Chinbat Tulga, Garidjav Ganbold, Amarmend Puntsag, Chuluundorj Enkhbat, Gonchig Bold, Ganbat Ariunbold, Batsaikhan Altansukh, Sainbuyan Selenge, Navaansuren Ayush, Dansran Bulgan, Namsrai Ganchimeg, Myagmar Boroldoi for their precious help that can not be forgotten.

I would like to express my gratitude to the Association of Mongolian Numismatists.

My sincere gratitude to following people who shared with their knowledge and gave me valuable advice.

D.Tserensodnom, academician (Center for Studies of the Secret History of Mongols); D.Bayar, Dr. (Institute of Archeology, Academy of Science of Mongolia), D.Erdenebaatar, Dr. (Institute of History, Academy of Science of Mongolia); Ts.Shagdarsuren, Dr. (Center for Mongol Studies, National University of Mongolia); N.Dorjgotov (National University of Mongolia); L.Altanzaya, Dr.(Mongolian State University of Education); T.Jamyansuren (National University of Mongolia); R.Otgonbaatar (Institute of Linguistics of Mongolia); A.Ochir (Director of National Museum of Mongolian History); Ts.Ayush (National Museum of Mongolian History); M.Enkhpurev ("Chinggis Khan" University); Haroon Tareen (Pakistan), Dr.John E.Woods (Director of Center for Middle Eastern Studies, University of Chicago, USA), Stephen Album, Dr.(USA), P.N.Petrov, Dr. (Russia), V.N.Nastich, Dr. (Russia), V.A.Belyaev, Dr. (Russia), Ding Wei (China), T.Yih (Netherlands) and other.

I would like to express my sincere gratitude and wish all the best to the team of "**Admon**" company, its Director R.Enkhbat, employees J.Amgalan, A.Tabigat and T.Dairiimaa, and Director of Printing House N.Ganbold for diligently publishing my book.

*AUTHOR*

Монголын Тулгар Төр
байгуулагдсаны 800 жилийн ой.
2006 он

800 years of Establishment
of the Mongolian Statehood.
2006

## ЭНЭ НОМЫГ АШИГЛАХТАЙ ХОЛБОГДСОН ЗАРИМ ТАЙЛБАР:

1. А. 1 - Стефан Албумын каталогийн дараалал
2. N. 1 - номын хоёрдугаар бүлэгт буй миний зоосны цуглуулгын дараалал;
3. М. 1 - Энэ номонд ороогүй боловч миний цуглуулгад буй зоосны бүртгэлийн дугаар
4. S. 1 - А.З.Сингатуллинагийн цомгоос авсан зураг
5. Z. 1 - оросын www.zeno.ru сайтад буй зоосны зургийн дугаар.
6. Уншигчдад тод харуулах зорилгоор номонд орсон бүх зоосны зургийг ижил хэмжээгээр тавьсан. Зоосны бодит хэмжээг хоёрдугаар бүлэгт буй зоосны тайлбараас үзнэ үү.
7. Монголын болон дэлхийн зоос судлагч, цуглуулагчид зоосны ар ба өвөр талыг янз бүрээр тодорхойлдог. Монголын зоосон дээрх тамга ба хааны нэр байгаа талыг би нүүрэн тал гэж тооцон тэр дагуу зургуудыг байрлуулсан болохыг анхаарна уу.

## SOME EXPLANATIONS WITH REGARD TO USE OF THIS BOOK:

1. A. 1 - a number of the coins recorded in catalog of Stephan Album (USA)
2. N. 1- a number of the coin recorded in my collection in Chapter II of the book.
3. M. 1 - a number of the coins from my private collection that not recorded in this book.
4. S. 1 - Registration number of pictures from album of Singatullina A.Z.
5. Z. 1- a number of the photograph of the coin recorded in Russian www.zeno.ru web-site.
6. For the purposes of improved readability, all photographs of coins were adjusted into one size. Please refer to the Chapter II to find out the real size of the coin.
7. The Mongolian and world's numismatics and writers identify the obverse and reverse of coins in different ways. Please note that a side of a coin with tamgha, name of a khan is considered as an obverse and that photographs are arranged accordingly.

---

## EXPLANATIONS TO TAMGHAS:

**Alkh** - means "axe" in Mongolian. A tamgha with a shape of an "axe";
**Bundan** – means "hearts" of cards in Mongolia. A tamgha with a shape of "hearts" turned downwards;
**Degree or zuuzai** – means "bit of bridle" in Mongolian. A tamgha with a shape of a "bit of bridle",
**Khas** - means "swastika" in Mongolian. A tamgha with a shape of a "swastika";
**Nar or naran** – means "sun" in Mongolian. A tamgha with a shape of sun or round tamgha.
**Num or numan** - means "bow" in Mongolian. A tamgha with a shape of a "bow";
**Ongi or ongin** – a tamgha with round shape, looks like "sun";
**Sar** - means "moon" in Mongolian. A tamgha with shape of a "moon";
**Seree** - means "trident" in Mongolian. A tamgha with a shape of a "trident";
**"Ulzii" pattern** - in Mongolian. A pattern symbolizing happiness.
**Zurkhen** – means "heart" in Mongolian.
**Suultei ongin tamgha** (in Mongolian) – An ongin tamgha "with a tail". A tamgha with a line drawn from a circle.
**Shireetei ongi** (in Mongolian) – An ongin tamgha with a stand.

# FOREWORD

In the world of ancient numismatics, the coins of Mongol Empire of XIII-XIV century are considered unique and interesting in terms of design, circulation, shape, used materials, weight and script . Therefore, the study and interest in coins of Mongol Empire are expanding in scale in recent years. The first information on Mongol coins was sourced from the historical travelogues of Franciscans Giovanni da Pian del Carpini, William of Rubruk and Marco Polo's journey to Mongolia. However, the detailed research by numismatists on coins, the state of striking and using coins of Mongols has commenced as early as approximately 200 years ago.

It should be highlighted that Mongolian numismatics was originated from works of Russian scientists and the majority of researches in this field are undertaken by Russian scientists.

The research on coins, which started at the beginning of XIX century has been continuing until these days in Russia and it is still a major subject for studies as my colleague P. N. Petrov, Russian famous researcher, said "The subject on coins of Mongols is endless and its scope spreads without limits, and further, it appears it will continue toward decades".

As a result of research works on ancient states, and tremendous efforts of Mongolian numismatists as well as historians, almost complete and accurate materials on history of coins of Mongol Khans of XIII-XIV century have been accumulated. Especially, it can be concluded that Mongolian research works on coins have reached a new stage in recent 5-6 years. This progress is related with the "Ancient Asian and Eastern coins" an international internet project, initiated by Russian researchers[1].

Since the launch of this project, not only many rare coins of XIII-XIV centuries, which were unknown earlier, were found, but also it has a great significance that researchers and collectors of coins from many countries have been sending interesting news and information about coins to the project database presenting comments, conclusions, evidences and hypothesis as well as having debates and discussions.

The initiators of this project are Russian researchers, V. A. Belyaev, P. N. Petrov, and V. N. Nastich, and moreover, I am pleased to mention that many researchers from various countries who have deep knowledge of Mongol coins such as Stephen Album and James Farr from USA, Haroon Tareen from Pakistan, Ding Wei from China, Martin Ko from Singapore, V.Sachi from Czecho Slovakia and T.Yih from Netherlands are also involved in the project.

Our researchers have put great efforts on restoring and studying the historical and cultural heritage of our ancestors. Amongst, significant amount of research works have been undertaken on coins and banknotes. Many interesting articles on ancient Mongol coins can be found from works of well-known Mongolian researchers such as B.Rinchin, Kh. Perlee, Ch. Dalai, G.Tserendorj, Ts. Shagdarsuren and A. Damdinsuren.

However, within the last decade a few Mongolian numismatists have collected novel and interesting information on Mongol coins by combining their joint efforts, found a few unusual coins, which unknown earlier, and published several research and reference booklets. The works by Ts.Batsaikhan, A.Puntsag, Ch.Enkhbat and G.Ganbold can be mentioned hereto. It is worthwhile to note that in 2002 the book "The Coins and Banknotes of Mongolia" was published by the Association of Mongolian Numismatists and series of articles were published in "The Study of History" academic journal and in popular newspapers. The book "The Coins and Banknotes of Mongolia"[2] has greatly attracted interest of many people, contributed to promotion of Mongolian history and culture, and has also impacted on increased of number of numismatists and people interested in coins. It was observed that some Mongolian commercial banks and companies have quoted in their newspapers and journals from the above-mentioned book. From time to time radios, TVs and press often present information, discussions and interviews

[1] www.charm.ru

[2] Ч.Энхбат, Б.Нямаа, Ц.Батсайхан, "The Mongolian coins and banknotes". УБ, 2002

about Mongol coins. The Museum of the Central Bank's Treasury and National History Museum are disclosing several ancient Mongol coins to general public. Moreover, some individuals started a good collection of ancient coins.

There is a tendency that comparing to earlier years, promotion and awareness on coins of Mongol Khans of XIII-XIV centuries, which are valuable monuments of Mongolian history, are increasing.

In my opinion, it is the exact time to bring up this issue from the information and promotion stage into the step of more in-depth scientific research. This progress will most probably meet the core interest of the national history and its studies.

The coins of every nation and of every period contain the specific information concerning the historical time and the country. A lot of information can be revealed from coins as they are specific and carry the date and where the coin was struck. For example, from ancient historical sources we clarify and learn about historic events of our country, whereas from writings of Mongol coins we can clearly learn when the Mongol Empire reached what territories and who was ruling the state at that time.

Therefore, there is no doubt that coins have no less value than the books and are precious historical and cultural source. In other words, the coins of Mongol Empire are valuable source of Mongolian history.

I believe that we can enter into the new doors of the Mongolian ancient history through exploring these historical sources.

No doubt that, behind this door, not just only a few coins, which passed their generation, but also there are complex of issues related to the economic policy and monetary system of Mongol Empire, which have not been studied fully and wait for their researchers.

In this book, I tried to include the issues related to coins that were struck by Khans of Mongol Empire, especially those issues that have not been studied yet or being partly studied by both international and local researchers.

Moreover, I tried to interpret the tamghas on coins of Mongol Khans and some unresolved words in the parts of Uighur and Phags-pa writings. Consequently, I attempted to present some hypothesis and conclusions in this regard.

In addition, my purpose was to present to readers pieces of my collection that I have diligently collected during the last five years.

*AUTHOR*

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

# МОНГОЛЫН ЭЗЭНТ ГҮРНИЙ ЗООСОН МӨНГӨ БА ХААДЫН ОВГИЙН ТАМГА

## CHAPTER ONE

# THE COINS OF MONGOL EMPIRE AND CLANS' TAMGHAS OF KHANS

## 1. МОНГОЛ ХААДЫН ЗООСОН ДЭЭРХ ОВГИЙН ТАМГА

Бидний овог, угсааны гэж нэрлээд байгаа тамга маань бүр хүй нэгдэл, овгийн байгууллын үеэс үүдэлтэй ажээ. Эртний хүмүүс, тэр дотор монгол угсаатнууд уг ураг, удам гарал, овог ястан болж хөгжих үеэс л овгийн сүлд, овгийн шүтлэг үүсэж, төрөл угсаагаа ялгах, элгэн саднаа ялгах ёс тогтсон байдаг. Улмаар овгийн дотоод хөдөлмөрийн хуваарь үүсч аж ахуй эрхлэх болсноос хөдөлмөрийн багаж, сав суулганд таних тэмдэг тавих, адгуусан амьтан гаршуулахад янз бүрийн тамга зурлага, тэмдэглэгээ, им тамга хэрэглэх болжээ.

Овгууд "яс хагалж" шинээр салбарлах тутам үүсгэмэл тамга нэмэгдсээр нэгэн овгийн нийтлэг тамганаас өч төчнөөн салбарлаж тэр нь амины, өрхийн, удмын, хааны, улсын тамга болтлоо хөгжсөн түүхтэй юм байна. Доктор Ц.Шагдарсүрэн гуайн бичсэнлэн "нэгэн овгоос салбарлаж шинэ овог гарах тохиолдолд уламжлалаа хадгалж хуучин овгийнхоо тамгад ямар нэгэн зохистой тэмдэг нэмэн хэрэглэдэг ёсон ч гарсан..." гэнэ[3].

Хүн үүссэн цагаасаа л түүнийг шүтлэг дагаж ирсэн түүхтэй. Овог аймгийн байгуулалт гарч ирэх үед шүтлэг улам бүр хэлбэржиж, уул, ус, мод чулуу, элдэв адгуус амьтан, шувуу, ямар нэгэн эд зүйлийг шүтэх явдал түгээмэл болж, улмаар түүнээсээ аврал даатгал эрж аргадаж гуйдаг, айж сүрддэг байдал нь яваандаа бөө мөргөлийг буй болгожээ. Эртний монголын овог аймгуудад өөрсдийн эзэмшил газар нутаг, уул усаа бусдынхаас ялгаж зааглах, тодотгож бататгах, хаагуур хэний овог угсаа нутаглаж байгааг илэрхийлэх зэрэг олон шалтгаанаас үүдэн хад чулуу, уул модонд өөрсдийн удам овгийн тамга тэмдгээ үлдээсэн баримт олон байдаг.

[3] Ц.Шагдарсүрэн. "Монголчуудын утга соёлын товчоон" УБ, 2001. 162-тал

## 1. THE CLAN TAMGHAS ON COINS OF KHANS

The tamghas, which we claim belong to clans or to our ancestry, are originated from the clan structure and primitive society. Since the time when the ancients, including Mongol nations, have developed into relative groups, origins and ethnic groups, the symbol and belief of a clan have emerged, and the custom to distinguish their origins and relatives have been established. Consequently, when labor distributions within clans began to develop and people started manage an economy, various tamghas, drawings, notes and earmarks have been used as an identification sign for labor instruments and utilities as well as in domestication of animals.

Every time the clan branched off due to internal clashes, the number of derivative tamghas, which branched off from common tamgha has increased, and thus tamghas been gradually developed into personal, family, lineage, khans and state tamghas. As Dr. Ts. Shagdarsuren wrote "if a new clan separates from another, the clan would conserve old tradition and use the tamgha of previous clan through adding its own markings on the tamgha"[3].

Since its creation, the human was always attached with belief. By the time clans and tribes were established, the belief assumed took a certain form and people began to worship mountains, water, trees, stones, various animals, birds and so on. Consequently, worshiping has become a common phenomenon among humans and by looking for a salvation, soothing it and being afraid of, it has been gradually advanced into the shamanism. In order to distinguish, demarcate and fortify own territory from others and to identify who's clan settled on which territory, the ancient clans engraved tamghas

[3] Shagdarsuren Ts. Summary of Mongolian culture. Ulaanbaatar. 2001. p162

Энэ тухай академич Б.Ринчин[4], манай нэрт эрдэмтэн Х.Пэрлээ[5], Зөвлөлтийн эрдэмтэн В.В.Волков[6], эрдэмтэн Л.Болд[7] нарын зэрэг олон эрдэмтдийн бүтээлүүдээс тодорхой үзэж болно.

Овгийн тамга үүсэх үед уг тамгыг өвлүүлэх эрхийг овгийн тэргүүлэгч л эдэлдэг байсан бололтой. Иймээс овгийн тамгыг өвлөх уламжлал тогтож улмаар язгуур сурвалжит хүмүүс, ихэс дээдэс, хаад ноёдод л хамаатай зүйл болон хувирч ирсэн байна. Харин тухайн язгууртан, хаад ноёдын харъяат албат, хамжлагат ард иргэд, нутаг нугын нь жирийн хүмүүс тэр тамган дор овог угсаагаа баримтлан заншсан бөгөөд мөн өөрсдийн газар нутаг, мал ахуйгаа тамгалах болсон нь сүүлдээ үндэстний тамгалах ёс[8] болон уламжлагджээ.

XIV зуунд МЭГ задарч эхэлсэн цагаас хойш, ялангуяа Монгол улс Манжийн эрхшээлд орсны дараа монголчуудын угсааны тамга хэрэглэх уламжлал ихэд хумигдсан бололтой. Хятадын Мин улсын үеэс ялангуяа Манжийн үед монголчуудын соёл түүхийн дурсгалуудыг олон жилийн турш устгасаар ирснийг түүхэнд тэмдэглэсэн байдаг. Ялангуяа монголчуудын угсаа гарлыг тэмдэглэсэн өдий төдий ном судар, айл өрх болгонд шахуу уламжлагдсан хөтөлж ирсэн угийн бичиг, тамга сэлтийг зориудаар устгасан буюу Хятад руу аваачсан бол үлдсэн жаахан нь өнгөрсөн зуунд "харгис феодализмийн бурангуй үзэлтэй тэмцэх" явцад нэрвэгдсэн байна. Энэ бүхний зорилго бол Монголчуудын угсаа гарлын түүхийг будлиантуулах, хувиргах, мартагдуулах, өвлөх уламжлах ёс заншлыг тасалдуулж, улмаар монголчуудыг үндсэний хувьд уусган устгахад чиглэж байв. Энэ нь зарим талаараа хэрэгжсэн тал бий байх. Гэвч түүхийг бүр мөсөн үгүйсгэн устгаж болдоггүй ажээ.

Монголчууд өвөг дээдэс, язгуур угсаа, нутаг усаа шүтдэг, хүндэтгэдэг уламжлалтай, энэ нь бүр мах цусанд нь шингэсэн

[4] B.Rintchin. "Les signes de propreite chez Mongols". "Archiv orientalni", XXII, Praha, 1954, No. 2-3
[5] Х.Пэрлээ. "Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь". УБ. 1976
[6] В.В.Волков. "Оленные камни Монголии". Улан-Батор 1981
[7] Л.Болд. "БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс" УБ. 1990
[8] Д.Чойсамба. "Малын им тамга, түүний хууль цаазны ач холбогдол". УБ, 1974



on crags, mountains and trees, many imprints of which can be found today.

We can find this subject in works of academician B.Rinchin[4], our famous scientist Kh.Perlee[5], Soviet scientist V.V.Volkov[6], scientist L.Bold[7] and from works of many others.

It is most likely that by the time a clan tamgha was created, only the chief of a clan was entitled to hand it down. Thus, a tradition to hand the clan tamgha down was established, and consequently it has turned into an object related only to aristocrats, noblemen, khans and lords. However, subjects and serfs of aristocrats and khans as well as local inhabitants continued to record their lineage under the clan tamgha, and further it was used as a seal to mark their territory and livestock, and later was passed on as a national sealing custom[8].

Since the collapse of Mongol Empire in XIV century and after Mongolia went under Manchu occupation, the Mongolian tradition of using a clan tamgha was perhaps significantly suppressed. It is written in historical sources that since the Chinese Ming Dynasty, especially during the Manchu ruling, the cultural and historical monuments of Mongols had been destroyed for many years. Many books and sutras, particularly those that reflect origin of Mongols, genealogies and tamghas of almost every family, and which were strictly recorded and passed down were forcefully destroyed, or were taken to China, while the few remaining were scattered in the last century during the period of "fighting against ideology of cruel feudalism". The purpose was to confuse, transform and make forget the origins of Mongolians, to cut off the tradition of inheritance as well as to exterminate the Mongolians as a nation. At certain point this goal was achieved. However, history can not be denied and exterminated.

Mongolians have a tradition to respect and worship their ancestors, origins and homeland, and these are absorbed into their flesh and

[4] B.Rintchin. "Les signes de propreite chez Mongols". "Archiv orientalni", XXII, Praha, 1954, No. 2-3
[5] Perlee Kh. Studying the origins of Mongols according to tamghas. Ulaanbaatar. 1976
[6] Volkov V.V. Deertomb stones of Mongolia. Ulaanbaatar. 1981
[7] Bold L. The rock writings on the territory of the People's Republic of Mongolia. Ulaanbaatar. 1990
[8] Choisamba D.Earmarks of livestock and their legal significance. Ulaanbaatar. 1974

байдаг. Монголчуудын гарал үүслийг төөрүүлэх гэсэн олон зууны хавчлагад энэ ард түмэн багагүй зовлон үзсэн ч эртний уламжлалт бэлгэ тэмдэг, ёс заншлаа гээсэнгүй нуух цагтаа нууж, мандуулах цагтаа мандуулж явсаар өнөөдрийн өдөртэй золгожээ. Монголчуудын овгийн дүрс тамганы археологийн олдвор дурсгалууд олон байна. Эдгээрийг олж судлах, тайлахад манай үе үеийн эрдэмтэд их зүйл хийсэн, одоо ч энэ ажил үргэлжилсээр байна. Монголчуудын овог удмыг тодруулан сэргээх, хаадын түүх гарлыг судлах, нүүдэлчдийн соёл, угсаатны зүй, бэлэгдэл, хэл бичгийг шинжлэх, бичиг номын соёлыг сэргээхэд маш их ажил хийсэн бөгөөд эртний булш бунхан, хөшөө дурсгал өч төчнөөнийг илрүүлж, түүхийн үнэт эд олдворын шинэ шинэ зүйлсээр манай түүхийн дурсгалыг улам баяжуулсан байна.

Эндээс монголчуудын улс үндэсээрээ бахархах үзэл улам сэргэн Эх орныхоо түүхийг судлах их ажилд эгэл жирийн хүмүүс хүртэл чадах хэрээр хүч өргөхийг хичээж, түүнийг нь манай эрдэмтэн мэргэд тал бүрээр дэмжин туслаж байгааг энд тэмдэглэхэд баяртай сайхан байна.

Монголчуудын овгийн тамгыг судлахад манай нэрт эрдэмтэн Х.Пэрлээ гуай үнэхээр их зүйл хийжээ. Рашаан хадан дээрх 270 гаруй тамгын дүрсийг нэг бүрчлэн уйгагүй буулган авч, Монгол орны олон газраас олдсон дүрс тамга, ард түмний хэрэглэж ирсэн уламжлалт тамгадыг цуглуулан авсны дээр гадаадын улс үндэстний дүрс тамга, бичиг сэлттэй харьцуулан "Монгол түмний гарлыг тамгаар судлах нь" (УБ, 1976) гэдэг гайхамшигтай ном бичсэн нь судлаач эрдэмтэд, сонирхогчдод чухал хэрэгцээтэй гарын авлага болсон юм.

Х.Пэрлээ гуай XIII-XIV зууны Монгол хаадын зоосон мөнгөн дээрхи тамгыг Монгол хаадын овгийн тамга мөн[9] гэж анх удаа туйлын оновчтой таньж энэ номондоо тэмдэглэсэн байна.

Зоосон мөнгө нь айл гэрийн эд агуурс,



Академич, доктор, профессор Хөдөөгийн Пэрлээ (Дамдины Пэрэнлэй) (1911-1982)

Academician, Dr. Prof Perlee Khodoogiin (Perenlei Damdiny)

[9] Х.Пэрлээ. х. 199

blood. Even though, this nation suffered from misfortune of oppression aimed at mingling its origin, people rescued their ancient symbols and customs having them hidden when needed and rasing when it was right time until present time. There are many archeological findings, which contain figures and forms of clan tamghas of Mongols. Scientists from different generations have significantly contributed and continue in this respect to researching and solving these archeological findings. A lot of research work was undertaken to recover clans and lineages of Mongols, to study history and origins of khans, to restore nomadic culture, ethnography, symbols, linguistics and literacy. Furthermore, many ancient tombs, graves and monuments have been discovered that enriched our historical heritage with new valuable findings.

I am pleased to mention hereto that the pride to their motherland among Mongolians is being restored, and even ordinary people, who are supported by scholars and researchers, make efforts to contribute to the study of history of their country.

Our famous scientist Kh.Perlee has made a significant contribution in studying the clan tamghas of Mongols. He has diligently copied one by one about 270 tamghas, which were carved on "Rashaan" rock, collected figure tamghas found from different parts of Mongolia as well as traditional tamghas used by people. Moreover, he wrote a wonderful book "Studying the Origins of Mongols by the Tamghas" (Ulaanbaatar, 1976), where he made comparative study of various foreign tamghas and writings. This book has become an important guidebook for researchers and for people who are interested in the subject.

Kh.Perlee has highlighted in his book that tamghas on coins of Mongol Khans of XIII-XIV century are interpreted for the first time as a clan tamghas of Mongol Khans[9].

As coins have wider meaning than any ware and livestock

[9] Perlee Kh. p.199

морь мал зэргээс хавигүй өргөн утга агуулгатай зүйл учраас тэдгээр зоосон дээрхи тамга нь малын им тамга төдийхөн байх учиргүй юм.

Хааны зоосон мөнгө нь юуны өмнө хаан төрийн өмч, түүний улс төр, эдийн засгийн бодлогын онцгой чухал хэрэгсэл юм. Зоосыг зөвхөн хааны зарлигаар, түүний нэрийн өмнөөс гаргах тул энэ нь хааны суу алдарыг мөнхжүүлэх, түүний төр хэдийд, хаана тогтнож байгааг илтгэн харуулах нэг ёсны нэрийн хуудас болно.

Монголын зарим хаад өөрийн шууд угсааны хаан, хан нарын нэрийг өөрийн нэрийн хамт зоосон дээрээ бичиж байсан нь удам угсаагаа тэмдэглэн үлдээж байгаа бас нэгэн хэлбэр юм. Тухайлбал, Иран дахь Монголын хант улсыг үндэслэгч Хүлүг хан (1256-1265) гаргасан зоосон дээрээ өөрийн нэрний дээд талд Монголын Их Хаан Мөнхийн нэрийг тавьсан байдаг[10] нь хаан ахаа өргөмжилснөөс гадна өөрийгөө их хаантай угсаа нэг болохоо харуулж буй хэрэг юм. Ийм маягаар хаан аав, ах, дүү, хүүгийнхээ нэрийг хамт бичихээс гадна, зөвхөн "Их Хаан" гэж бичих явдал цөнгүй байсан ажээ. Зоос ийнхүү хааны өмч, төрийн өмч, хааны нэр төрийн бэлэгдэл болох тул түүн дээр байгаа тамга нь чухамхуу хаантай холбоотой, тодруулж хэлбэл түүний овог, удам угсааных байх нь эргэлзээгүй юм. Ийм ч учраас Х.Пэрлээ гуай зоосон дэрх тамгыг Монгол хаадын овгийн тамга гэж нэрлэсэн бизээ.

Овог овгийн тамгыг хэрэглэж ирсэн байдлаар нь хоёр үндсэн хэсэгт хувааж ойлгож болно.

1. овгийн сүлд, бэлгэ тэмдэг болгон үе удам залгуулсан тамга
2. овог угсаатнууд өөрсдийн мал ахуй, эд хөрөнгө, газар нутгийг бусдаас ялгахад хэрэглэж ирсэн им тамга.

Энэ хоёр янзын тамга хоорондоо уялдаатай, дүрслэл болон гаралын хувьд нэгдмэл шинжтэй боловч зориулалт, хэрэглэж ирсэн байдлаараа хоорондоо ялгаатай юм.

Монголчуудын тамганы талаар судалсан эрдэмтэд дээрхи хоёр төрөл тамганы аль алийг нь судалж байсан боловч, овгийн сүлд тамганы судалгаа нь арай хомс мэт

[10] N.123, 124



of the household, tamghas on the coins should not be appreciated at the same level as earmarks.

The khan's coins were the property of the Khaganat and a distinguishing tool for managing its politics and economy. Since coins were issued only by the decree of khan and on behalf of khan, they played a role of a name card, which perpetuated honor of khan and recorded where and when his state existed.

Some Mongol khans and khaans inscribed the names of khans and khaans of their direct lineage together with their own names, which was one of ways to record next lineage. For example, Hulagu Khan, the founder of the Mongol Khaganat in Iran (1256-1265), has inscribed the name of Munghe, Great Khan of Mongol, above his own name[10], which in addition to bestowing the honor of his royal brother, showed his relation to the lineage of the Great Khan. Besides inscribing names of their Khan fathers, brothers and sons, they also often inscribed words "Great Khan". Undoubtedly, since the coins were the property of a khan and of the state as well as the symbol of khan's honor, tamghas on coins were related to a Khan and particularly to his clan and lineage. Therefore, Kh. Perlee named tamghas on coins as the clan tamghas of khans.

The clan tamghas can be divided into two main groups according to their usage.

1. Tamghas inherited from generation to generation as an emblem, a symbol of the clan.
2. Earmarks, which were used to distinguish their livestock, property and a land from others.

These two types of tamghas are different from each other by their purpose and usage, even though they are interrelated and have the same shape and origin.

Although researchers have studied both types of tamghas, in my opinion the research on clan arm tamghas are insufficient. Perhaps it was difficult to undertake a research on this subject since the arm tamghas were used only by a khan and for his state purpose, therefore historical materials and documents are rare, the lineage to inherit an arm tamgha as a symbol of a clan was limited, and it has not been used

[10] N.123, 124

санагдана. Энэ нь сүлд тамгыг хааны болон төрийн чанартай зүйлд ихэвчлэн хэрэглэж байсан тул түүнтэй холбоотой биет баримт материал ховор, овгийн тэмдэг болгон уламжлах хүрээ явцуу, хэрэглэгдэхээ болиод удсанаас мартагдаж гээгдсэн зэргээс үүдэн судлахад төвөгтэй байсан болов уу. Монголчууд дүрс тамгыг им тамга байдлаар ашиглаж ирсэн, одоо ч ашигласаар байгаа нь тодорхой, энэ талаар нилээдгүй судласан байна. Харин энэхүү дүрс тамгыг хэрхэн язгуур овгийн тамга болгон залж ирсэн, тэр нь хэрхэн яаж үе дамжиж, өөрчлөгдөн хувирч ирснийг ямар нэгэн бодит баримт дээр тулгуурлан судлаж үзсэн судалгаа өнөө хэр гараагүй юм байна. Баримт байх аваас ийм судалгаа хийхэд ихэд сонирхолтой байх болно гэж бодож байна. Монголчууд бидний хувьд түүхийн үнэ цэнэтэй, маргашгүй, няцаашгүй үнэн бодитой тийм баримтыг Монголын эзэнт гүрний хаад өвөг маань хойч үеийн бидэндээ үлдээжээ. Энэ бол XIII-XIV зууны Монголын Эзэнт Гүрний хаадын зоосон мөнгө юм.

МЭГ-ний хаадын зоос дэлхийн эртний олон улс орны зоосон мөнгөнөөс ялгагдах хоёр төрлийн гайхамшигтай онцлогтой. Энэ нь:

1. Монгол бичгээр бичигдсэн
2. Монголчуудын овог угсааны сүлд тамгатай байдаг явдал юм,

Монгол хаадын зоосон дээрхи монгол бичээсийн тухай жич бичсэн тул энд давхардуулах нь илүүц юм.

Харин МЭГ-ний хаадын зоосон дээрхи тамга, түүний гарал үүсэл, харъяалалын тухай үзэж харсан баримт материал, уншиж судалсан ном зохиол, мөн өөрийн хувийн цуглуулга дээрээ түшиглэн судлахыг оролдсоноо дор сийрүүлэв.

Овог угсааны тамга нь төрийн тамгатай төдийлөн холбоогүй, хэлбэр дүрсийн хувьд ч, хэрэглэгдэх байдлын хувьд ч тусдаа бие даасан шинж чанартай зүйл юм. Энэ тамгадын гарал үүсэл маш эртнийх бөгөөд өдгөө манай оронд байгаа эртний олон хад чулууны бичээс, зурлагууд дотор яг адилхан буюу ижил төстэй дүрс тамга олон тохиолдож байна. Хэнтий аймгийн Биндэр сумын Рашаан хад, Говь-Алтай аймгийн Цагаан голын хад, Төв аймгийн Бүрэн сумын Бичигт Улаан хад, Дундговь аймгийн Баянжаргал сумын Мөртийн хад, Өмнөговь ай-

for long time and became forgotten. Considerable studies have been undertaken proving that Mongols used figure tamgha as an earmark and still use them even today. However, I have not yet encountered any research work based on realistic facts on how the figure tamghas were transformed into the tamgha of aristocratic clan, how they were inherited or modified. If there were facts, it would be very interesting to undertake this kind of research. For Mongolians and to its future generation, our ancestors, the Great Khans of Mongol Empire, have left valuable facts in terms of historical science, which are indisputable, non-argumentative and truthful. These are the coins of Great Khans of Mongol Empire of XIII-XIV century.

There are two unique features to distinguish the coins of Khans of Mongol Empire from those of other ancient nations of the world.

The coins contain:

1. inscription in Mongol script
2. clan arm tamghas of Mongols.

Since the subject of Mongol writings on coins of Mongol Khans will be explained furthermore, it is unnecessary to reiterate here.

I attempted to undertake a research concerning the tamghas on coins of Khans of Mongol Empire, their origin and jurisdiction, based on facts that I have examined, books and research works that I have read as well as based on my own collection and the outline of this study is given below.

The clan tamghas are not strictly linked with state seals or stamps, and in terms of their shape and usage they have independent characteristics. These tamghas of are of a very ancient origination, and exactly the same or similar figure tamghas can be found nowadays on inscriptions and drawings of ancient rocks and cliffs of Mongolia. There are many figure tamghas of Mongol lineage carved on large rocks[11] such as **Rashaan rock** in **Binder** soum of **Khentii** province, **Tsagaan goliin rock** in **Gobi-Altai** province, **Bichigt Ulaan rock** in **Buren soum** of **Tuv** province, **Murtiin rock** in **Bayanjargal** soum of **Dundgobi** province and **Ikh bichigt** in **Dalan** mountain of **Umnugobi** province. Moreover, researchers have discovered that many ongi (tamgha that has the round shape or looks like "sun"), sar (means "moon" in Mongolian, and tamgha has

маг дахь Далан уулын Их бичигт зэрэг олон арван хад чулуунд эртний монгол угсаатнуудын тамга дүрс олноороо бий[11]. Мөн манай орны ихэнх нутгаас олдсон буган чулуун хөшөөнүүдэд онги, сар, нум, дэгээ, сэрээ, хас тамгад олноороо байдгийг эрдэмтэд олж тогтоожээ.[12]



Рашаан хад.
*Хэнтий аймгийн Биндэр сум*

Rashaan rock.
*Binder soum, Khentii province*

Эртний монголчуудын ахуйн эд зүйлс, мал ахуйгаа тамгалах ёс их эртнээс улбаатай юм. Малын им тамга, түүний тархац, хэрэглэж ирсэн уламжлалын талаар доктор С.Дулам[13], Г.Сүхбаатар[14], Д.Чойсамба[15] нарын зохиол бүтээлүүдэд тодорхой сайхан өгүүлжээ.

Үүнээс гадна гэр ахуйн хэрэгсэл болох хутга[16], дөрөө, сав суулга[17], шагай зэргийг ч бас тамгалдаг байв. Шагай тамгалсан байдал ихэд сонин тул бага зэрэг тодруулъя. 1948 онд С.В.Киселевын удирдсан шинжилгээний анги Хар Хорумын туурийн малтлага хийх үед нилээд олон төрлийн тоглоомын зүйлс олсны дотор хоёр шагай гарсан ажээ [18]. Энэ хоёр шагайн дээр тамга маягийн зураас хэрчлээс байсан бөгөөд үүнийг тухайн үедээ тодорхой тайлбарлаж чадаагүй бололтой.

Үүний нэг дээр монголчуудын дунд нилээд тархмал үзэгддэг "сэрээ" тамга[19] байгаа бөгөөд Хар Хорум орчмоос олдсон тул бүр ч сонин байгаа юм. Учир нь энэ тамга Мөнх хааны зоосон дээр байдаг түүний овог угсааны тамга мөн бөгөөд Мөнх

the shape of a "moon"), num (means "bow" in Mongolian, and tamgha has the shape of a "bow"), degree (tamgha has the shape of a "bit of bridle"), seree (means "trident" in Mongolian and tamgha has the shape of a "trident") and khas (means "swastika" in Mongolian and tamgha has the shape of a "swastika") tamghas can be found on deer tombstones in many different parts of Mongolia[12].

An old Mongolian tradition of stamping wares and livestock has been originated from ancient times. The works of Dr.S.Dulam[13], G.Sukhbaatar[14] and D.Choisamba[15] clearly describe livestock earmarks, their distribution and tradition of usage.

Moreover, the household utilities such as knives[16], stirrups, utensils[17] and anklebones were also stamped. Since stamping of anklebones is a very interesting activity, I will describe more about it. In 1948, during the diggings in Kara-Khorum city led by S.V.Kiselyov, the research group has found various types of toys, including two anklebones[18]. There were two incisions on anklebones similar to tamghas, although the researchers could not explain their meaning at that time.

On one of the anklebones there is a carving of "seree" tamgha[19], which frequently comes across in the livelihood of Mongolians, and it attracts interest even more as it was found nearby Kara-Khorum city. It was the clan

[11] Х.Пэрлээ. х 169-185
[12] В.В.Волков. "Оленные камни Монголии.", Уланбатор 1981. стр. 123-240, иллюстрации
[13] С.Дулам. "Монгол бэлэгдэл зүй". УБ, 2001
[14] Г.Сүхбаатар. "О тамгах и имах табулов Дариганги". УБ, 1960
[15] Д.Чойсамба. "Малын им тамга, түүний хууль цаазны ач холбогдол". УБ, 1974
[16] Х.Пэрлээ. х.174
[17] Д.Эрдэнэбаатар "Хүннүгийн археологийн судлагаа", Археологийн судлал, Tomus XX, УБ 2002, х 61-93
[18] С.В.Киселев. стр. 294
[19] Мөн тэнд, уг номонд орсон зургаас хуулбарлав

[11] Perlee Kh. p.169-185
[12] Volkov V.V. Deertomb stones of Mongolia. Ulaanbaatar. 1981
[13] Dulam S. The Mongol Symbol Study. Volume III (Sign Symbol and Gesture Study). Ulaanbaatar. 2001
[14] Sukhbaatar G. About tamghas and earmarks of Dariganga. Ulaanbaatar. 1960
[15] Choisamba D.Earmarks of livestock and their legal significance. Ulaanbaatar. 1974
[16] Perlee Kh. p.174
[17] Erdenebaatar "Hunnu's archeological research", Archeologycal study, Tomus XX, UB 2002, p.61-93
[18] Kiselev S.V. p. 294
[19] Kiselev S.V. p. 294



хаан Хар Хорумд нийслэллэж байсан тул хаан овгийн энэ тамга Хар Хорумын айл өрхүүдэд тархмал байсан байж ч болох юм.

2001 онд Монгол-Америкийн хамтарсан шинжилгээний анги Архангай аймгийн Өндөр-Улаан сумын нутгаас Хүннү булшны малтлага хийхэд дээр нь янз бүрийн тамга дүрс сийлсэн богийн шагай олон тоогоор олдсоныг судлаачид "Хүннү нарын угсаа гарлын бэлэгдэл овгийн тамга тэмдэг байх магадлалтай" гэж үзжээ.[20] Энэ дундаас нэгэн шагай ихээхэн онцлогтой байна.

Нэгдүгээр шагай[21] гэж тэмдэглэгдсэн шагайны нэг талд нар (онги), алх, сэрээ, дэгрээ тамгадыг нийлүүлэн зохиомжилсон нийлмэл тамга их тод үлджээ.

Нийлмэл тамганы төв дунд байх онгин тамганаас гурван тийш салбарлуулсан алх, дэгрээ, сэрээ тамга зурсан байх ба харин дөрөв дэх талд чухам юу байсан нь мэдэгдэхгүй байна. Тэнд байсан тамганы дүрс баларч үрэгдсэн байж болох боловч шагайг доош эргүүлж харвал тэр нь сүүлтэй онгин[22] тамга ч байж болох тал бас харагдаж байна. Ямар боловч Хүннүгийн булшнаас олдсон энэ шагайн дээрхи тамганууд нь тэдгээрийн эртний гарал үүслийг нотолж байгаагаараа чухал ач холбогдолтой юм.

Хаадын зоосон дээр тамга тавьдагийн учрыг хэд хэдэн талаас нь тайлбарлаж болмоор санагдана.

1. Хааны зоосон мөнгөн дээр хааны нэр алдар, хэргэм зэрэг, он цагийг дурдаж түүний овгийн тамгыг тавих нь уг хааны овог угсааг харуулахын зэрэгцээ язгуур гарвал, өвгөд дээдсээ хүндлэх монголчуудын зан төлөвийн илэрхийлэл болно.
2. Тамгатай зоосыг юуны өмнө хааны эзэмшил газар нутагт гүйлгэдэг тул энэ нь тухайн хааны эзэмшил нутгийн хүрээ хязгаарыг харуулна. Товчоор хэлбэл энэ зоос гүйж буй

tamgha of Munghe Khagan inscribed on his coins and since Munghe Khagan had established his capital in Kara-Khorum city, possibly this tamgha was spread in households of that time.

In 2001 when Mongolian-American joint expedition carried out diggings of Hunnu grave on the territory of Undur-Ulaan soum of Arkhangai province, many anklebones of goats and sheep with different types of carved tamghas and figures were found. The researchers interpreted that it could be clan tamghas symbolizing Hunnu's origin[20]. Among these anklebones there was one peculiar feature.

One side of the anklebone #1[21] is clearly marked with the combined tamgha comprised of ongi, alkh (means "axe" in Mongolian and tamgha has the shape of an "axe"), seree and degree tamghas.

In the center of combined tamgha, there is a ongin (same as "ongi") tamgha, which branches off alkh, degree and seree tamghas into 3 directions. However, it is unknown what kind of tamgha actually was inscribed in the part of fourth direction. Although it is possible that an image of tamgha has been blurred; however if we turn the anklebone upside down we can find out that it could also be a "suultei" ongin tamgha[22]. Anyway, it is significant that tamghas on these anklebones found from Hunnu graves prove their ancient origin.

I consider that it is possible to explain in several ways the reason of inscribing tamghas on coins of Khans.

1. Inscribing Khan's fame, title and date as well as his clan tamgha on the coins, demonstrated not only the lineage of a khan, but it is also an expression of nature of Mongols to respect their ancestors and their origins.
2. The coins with tamghas were primarily circulated on a territory ruled by the Khan and thus it showed the boundary of a territory ruled by a

[20] С.Эрдэнэбаатар, F.Allard, Н.Батболд, В.Миллер "Хүннү булшнаас олдсон тамгатай шагай, Түүхийн судлал. Tomus. XXXIII, УБ 2002, х176-189

[21] С.Эрдэнэбаатар, F.Allard, Н.Батболд, В.Миллер ... х.186, 1-р шагай

[22] Х.Пэрлээ гуай ийн нэрлэсэн байдаг. Х.Пэрлээ, х. 226

[20] Erdenebaatar D., Allard F., Batbold N., Miller V. Knuckle bones with tamghas found from Hunnu tombs. Historical Studies. Studia Historica. Tomus XXXIII. Fasc.17, p.176-189.

[21] Erdenebaatar D., Allard F., Batbold N., Miller V. ... Fasc.17, p.186

[22] Perlee Kh. p.226

газар нутаг нь хаан төрийн харьяанд байгаа гэсэн үг юм.

3. Хааны эзэмшил нутаг дээрх худалдаа арилжаа, алба татварын бодлого нь хаан төрөөс явуулж буй бодлого гэдгийг илтгэнэ.

Г.Сүхбаатар гуайн "О тамгах и имах табунов Дариганги" гэдэг номонд нэгэн сонин ишлэл байдаг юм. Тэрээр энэ ишлэлийг Осман Акчокралы гэдэг хүний 1927 онд бичсэн "Татарские тамги в Крыму" гэдэг номноос олсон аж. Харамсалтай нь миний бие энэ номыг олж үзэж чадаагүй тул Г.Сүхбаатар гуайн номноос дам ишлэл авлаа. Тэрээр бичихдээ "Чингис хаан Монголын олон овог аймгийг өөрийн захиргаан дор нэгтгэхдээ эдгээр олон овог аймгийг хооронд нь холилдуулахгүйн тул тус тусад нь тамга оноож өгсөн гэсэн яриа Крымын тал нутгийн татарчуудын дунд байдаг"[23] гэжээ.

Энэ мэтээс харахад овгийн тамга нь монголчуудын хувьд эртний улбаатай, одоо хүртэл тодорхой хэлбэрээр хэрэглэгдсээр буй ихээхэн утга учиртай зүйл болох нь харагдаж байна.

МЭГ-ний хаадын зоос, ялангуяа тэдгээр дээрх тамганууд нь дэлхийн эртний улсуудын зоос цуглуулагч, судлаачдын анхаарлыг маш их татдаг, тамгадын утга агуулга нь бүрэн тайлагдаагүй, төгс судлагдаагүй байгаа төдийгүй одоо ч урьд хожид үзэгдээгүй шинэ шинэ зоос, тамга олдсоор байгаа билээ. Монгол зоос судлаачид болон миний бие олж мэдсэнээр МЭГ-ний хаадын зоосны тамга нь үндсэн зургаа долоон тамгадаас улбаатай бөгөөд тэдгээрээс дам үүссэн тамганы тоо 100 гаруй болж байгаа юм.

МЭГ-ний хаадын овгийн тамгыг зоосоор судлахын тулд юуны өмнө Чингис хаан, түүний дөрвөн их хөвгүүдийн зоосон дээрх тамгадыг судлахаас эхлэх нь зүйтэй бөгөөд цаашид тэдгээрээс салбарлан гарсан бусад хаад, хан нарын дам үүсгэсэн тамгадыг зоосоор нь баримтлан тодотговол хялбар болоод ойлгомжтой байх болов уу гэж бодож байна.

[23] Г.Сүхбаатар. х.5



particular Khan. In brief, it means that a territory where the coin was circulated belonged to the khaganate.

3. It expresses that the trade and tax policy applied on the territory ruled by a Khan is the policy pursued from the khaganate.

There is an interesting quotation in the book of G. Sukhbaatar **"About Tamghas and Earmarkings of Herders of Darigangi"**. He quoted it from the book called "Tatars' Tamghas in Qrim" written by Osman Akchokraly in 1927. Unfortunately, I did not have a chance to see this book, so I took this quote indirectly from G.Sukhbaatar's book. He wrote that "there is a talk, which goes among the tatars of Qrim's steppe[23], that when Genghis Khan united different tribes under his rule he imposed on each of these tribes a particular tamgha to avoid blending among the tribes."

Statements above demonstrate that although originated from ancient times, for the Mongols the clan tamghas carry significant meaning and importance and are being used in certain ways until present.

The coins of Khans of Mongol Empire, especially tamghas on them attract a lot of attention of numismatists and researchers deal with coins of ancient states of the world, and now when the meaning and content of tamghas have not been completely revealed and perfectly studied, many new coins and tamghas, which have not been seen before, are still being found and discovered. Mongolian coin researchers, including myself, have learned that the coins of Khans of Mongol Empire contain 6-7 basic tamghas, from which over 100 tamghas were derived.

In order to study the clan tamghas of khans of Mongol Empire through the coins, it would be appropriate to start with tamghas inscribed on coins of Genghis Khan and his four sons. Thus, it would be easy and comprehensible to use coins to track down and identify the tamghas that branched off by other khans and khaans.

[23] Sukhbaatar G. p.5

## 1.1 ЧИНГИС ХААНЫ ЗООСОН ДЭЭРХ ТАМГА (603-624 АН/1206-1227 AD)

Чингис хааны зоос нилээд олон янз байна. Үүнд зарим нь Эзэн хааны аугаа их алдар нэрийг тодорхой бичсэн алт, мөнгө, зэс зоос байхад зарим нь Чингис хааны нэрийг бичээгүй боловч он цагийн хувьд Их хааны үед шууд хамаарах зооснууд ч бий.

Чингис хааны зооснууд дотор овгийн тамгатай хоёр төрлийн зоос байдаг бөгөөд судлаач цуглуулагч бидний ойлгож байгаагаар энэ хоёр зоос нэг нэг хувь л мэдэгдэж байгаа, цаашид олдох магадлал бараг байхгүй гэгддэг онцгой ховор зооснууд юм.

Чингис хааны зооснууд дотроос чухам яагаад энэ хоёр зоос тамгатай бусад зооснууд тамгагүй байна вэ гэдэг асуулт судлаачдын хувьд оньсого мэт тайлагдаагүй үлдсэн асуулт юм. Гэвч энэ хоёр зоос Их хааны зооснуудаас хамгийн түрүүнд гарсан ба мөн хоюуланг нь нэг газар буюу Самаркандад цутгасан байгаа нь дээрх асуултад ямар нэг хэмжээгээр хариулт болж өгөх талтай юм.

Энэ зоосны талаар хамгийн сайн дэлгэрэнгүй тайлбарыг Оросын нэрт эрдэмтэн Е.А.Давыдович хийж нийтэлжээ.[24]



## 1.1 TAMGHAS ON COINS OF GENGHIS KHAN (603-624 AH/1206-1227 AD)

There are many different types of coins of Genghis Khan. Some of them have the inscription of the Emperor's great fame and are made of gold, silver and copper, whereas there are other coins which, although do not hold the name of Genghis Khan, but are directly referred to the period of Great Khans in terms of its chronology.

Among Genghis Khan's coins, there are two different kinds of coins with clan tamghas. It is comprehended by us, the researchers and numismatists, that these coins are extremely rare, and the only one copy of each have been found so far leaving us with almost no chance of finding more in the future.

The question "why among coins of Genghis Khan just these two have tamghas inscripted on them" remains an unresolved riddle for the researchers. However, the fact that these two coins were issued earlier than other coins of Great Khan and both were minted in one place or in Samarqand, in certain extent might give an answer to this question.

The best and the most comprehensive explanation to these coins was given and published by famous Russian scientist E.A.Davidovich[24].

[24] Е.А.Давыдович. "Денежное хозяйство Средней Азии после монгольского завоевания и реформа Масуд-бека XIIIв" Москва, 1972, стр. 14.

[24] Davidovich E.A.Monetary economy in Central Asia after Mongol invasion and reforms of Masud- beck in XIII century. Moskow. 1972, p.14

## Зоос 1. Чингис хааны мөнгөлсөн зэс зоос

## Coin 1. Silver coated copper coin of Genghis Khan

Энэ зоосны нүүрэн тал дахь жижиг дугуй дотор "Самарканд, Самарканд ба түүний эргэн тойронд гүйх зоос" гэж бичсэн. Ар талд нь уг зоосыг хийсэн он цагийг дурдсан (622AH/1225AD).



On observe of the coin, in the small circle it is inscribed "Samarqand. To be circulated in Samarqand and its surroundings". On the reverse: the date when the coin was minted (622AH/1225AD).

Зоосны ар тал дахь дөрвөлжин хүрээнд 2 тамга нүднээ тод тусч байна. Доошоо бага зэрэг шувтан маягтай боловч энэ нь ширээтэй онгин (наран) тамга юм[25].

On the reverse two tamghas can be clearly seen in the square frame. Although the tamgha slightly narrows at bottom, it is "shireetei" ongin tamgha[25].

Хоёр дахь тамга нь Монголын уламжлалт өлзий хээнээс бүтээсэн хэвтээ таван нүдэн тамга.[26] Энэ зоос одоо Узбекистаны түүхийн музейд хадгалагдаж байна.[27]



Second tamgha is a horizontal five-eyed tamgha originated from Mongolian traditional "ulzii" pattern[26]. This coin is kept now at the History Museum of Uzbekistan[27].

## Зоос 2. Чингис хааны мөнгөлсөн зэс зоос[28]

## Coin 2. Silver coated copper coin of Genghis Khan[28]

**Нүүрэн талд:** Төв дунд хоёр тамгатай. Тамгадын хоёр талаар "Самаркандад гүйх зоос" гэж бичсэн ба гадна хүрээгээр нь уг зоосыг цутгасан он цагийг тэмдэглэжээ (624AH/1227AD).[29]



**On observe:** Two tamghas in the center with inscription "To be circulated in Samarqand" on sides. The date of coinage is inscribed on the margin (624AH/1227AD)[29].

**Зоосны ар талд:** Төв дунд гурван мөр бичээс байна. Энэ нь: *"Чингисийн мөнгө, Чингис хаан"* гэсэн үг болно.

منكو
جنكزى
جنكزخان

**On reverse:** There are three lines of writing in the center: *"The Coin of Genghis, Genghis Khan"*

[25] Х.Пэрлээ. х. 187
[26] Д.Чойсамба. х. 63
[27] Е.А.Давыдович. стр. 14
[28] Зургийг Ц.Батсайханы "Монголын эртний улсуудын зоос", УБ, 1998 номноос авав, х. -65. Уг зоосны фото зураг Е.А.Давыдовичийн номны 1-р таблицийн 4-т буй
[29] Е.А.Давыдович. стр. 16.

[25] Perlee Kh. p.187
[26] Choisamba D. p.63
[27] Davidovich E.A. p.14
[28] Batsaikhan Ts. The coins of ancient Mongol states. Ulaanbaatar. 1998
[29] Davidovich E.A. p.16.

## Тамганы байдал

Ширээтэй онгин тамга

Нуман тамга[30]

Зоосны байдлыг дүгнэж үзэхүл, нүүрэн талдаа ширээтэй онгин (наран) тамга ба эвшээлгэсэн сумтай нуман тамгатай, ар талдаа *"Чингисийн мөнгө, Чингис хаан"* гэсэн араб хэлээр бичсэн энэ зоосыг 1226/1227 онд Самарканд хотод цутгажээ.

Дээр дурдсан хоёр зоосон дээрхи тамгадыг үзвэл:



Дээрх дөрвөн тамганаас онгин тамга хоёр зоосон дээр аль алинд нь байгаа бол нум, өлзий тамгануудавтагдаагүй байна. Иймд ширээтэй онгин тамга анхаарал татна. Ялангуяа "*Чингисийн мөнгө, Чингис хаан*" гэж бичээд дэргэд нь тамга тавьсан нь онцгой сонин зүйл юм.

Энэ хоёр тамгын үндэс нь наран тамга юм.



Наран тамга

[30] С.Дулам. х. 100

## The state of tamgha

"Shireetei" ongin tamgha

Numan tamgha[30]

By examining this coin, on obverse - "shireetei" ongin (naran) tamgha and the tamgha with a slightly bent arrow. On reverse, an Arabic writing *"The Coin of Genghis, Genghis Khan"*. The coin was struck in Samarqand in 1226/1227.

The tamghas of the above mentioned two coins:



From above four tamghas, there is an ongin tamgha on both coins, whereas arrow shaped and "ulzii" tamghas are not repeated. Therefore, the "shireetei" ongin tamga attracts the attention. Especially, because it has the inscription "The Coin of Genghis, Genghis Khan" and tamgha next to it.

The origin of these two tamghas is the "naran" tamgha.

"Naran" tamgha

[30] Dulam S. p.100

Өөрөөр хэлбэл Чингис хааны хоёр зоос хоюулаа онгин (наран) тамгатай байгаа юм.

Монголчуудын шүтээн дотор нар тэнгэр хоёр онцгой хүндтэй байр эзэлдэг.

Эртний хүннү нар наран, сарны шүтлэгтэй байсан тул онгин буюу наран тамгатай байх бүрэн үндэстэй[31] гэж зарим эрдэмтэд бичсэн байна. Ер нь боржигин овгийхонд наран буюу онгин тамга нь их түгээмэл байдаг ажээ. Ялангуяа Сэцэн хан аймгийн Боржигин Сэцэн вангийн хошууныхан наран тамгатай байв.[32] Бүр эртний сурвалжид бичсэнээр "...Чингис хаан, түүний өвөг дээдэс, ах дүү нар ...хиад аймагт харъяалагддаг боловч Чингис хааны эцэг байсан Есүхэй баатрын хүүхдүүд Хиад Боржигин нэртэй болов. Тэд хиад ч мөн, боржигин ч мөн"[33] гэсэн ажээ.

Монголчууд гал, нар хоёрын хамтатган үздэг уламжлал бий. Монголчууд "гал, агаар, тэнгэрийн тахидаг" тухай Гильом де Рубрук үзэж харснаа тэмдэглэжээ.[34] Гал агаар тэнгэрийн тухай ойлголтод нар ч бас хамаарна. Ер нь эртний монголчуудын үлдээсэн хад чулууны бичиг, дүрс тамга зурлагуудын дотор наран буюу онгин тамганы дүрс нэн элбэг тохиолдож байгаа. Академич Ш.Бира гуай " Чингис хаан дээд тэнгэрээс заяатай төрснийг МНТ-д өгүүлсэн ба...монгол хаадыг тэнгэрээс гаралтай гэдэг үзэл баримтлалыг дэвшүүлсэн юм. Ерөөс тэнгэрийг шүтэх ёсон нь бөө мөргөлд уламжлан ирсэн бөгөөд Монгол хаадын хуучин үзэл баримтлалын тулгуур болсоор ирсэн..."– гэж бичсэн байна[35].

Энэ бүхнээс үзэхэд, Чингис хааны зоосон дээрхи наран тамга монголчуудын нар, тэнгэрийг шүтэж, дээдлэн үздэгтэй холбоотой байж болох юм.

Чингис хааны аугаа нэр алдар, энэхүү наран тамга хоёр нэг зоосон дээр байгаа нь яав ч санамсаргүй тохиолдол биш юм. Чингис хааны алтан ургийн олон хаадуудын зоосон дээр наран тамганаас үүсэлтэй

[31] С.Дулам. х. 57
[32] С.Дулам. х. 58
[33] Рашид Ад Дин Судрын чуулган, I боть. УБ, 2002, х. 113
[34] Гильом де Рубрук. Дорно этгээдэд зорьсон минь. УБ, 1988, х. 108
[35] Ш.Бира. "МЭГ- ний үеийн соёлын харилцааны түүхээс" (Түүхийн судлал. Tomus XXX. Fasc. 1)



In other words, both coins of Genghis Khan have the ongin (naran) tamgha.

Among the objects of worship by Mongols, the sun and heaven are specially honored.

Some researchers wrote that as the ancient Hunnu used to worship the sun and the moon, there is rationale they had used "ongin" or "naran" tamgha[31]. The "ongin" or "naran" tamgha was common among Borjigin clans. Especially, the people of Borjigin Setsen khoshun (administrative unit) of Setsen Khan province had used the "naran" tamghas[32]. In the ancient source it was written that "... although Genghis Khan, his ancestors and brothers ... were under the jurisdiction of khiad tribe, offsprings of Esukhei Bagatur, the father of Genghis Khan, were designated to be Khiad Borjigin. They are both the Khiads and the Borjigins"[33].

There is a tradition that Mongols consider the fire and the together. William of Rubruk noted as he had seen that Mongols worship "the fire, air and heaven"[34]. The meaning of the fire and air contains the sun as well. In fact, the image of "naran" or "ongin" tamgha is often found on the rock writings and figure tamgha drawings left by ancient Mongols.

The academician Sh.Bira wrote that "The Secret History of Mongols refers that Genghis Khan was born destined by the supreme heaven and ... presents a concept that Mongol Khans were descended from the heaven. The custom of worshipping the heaven was inherited from shamanism and had been the basis for old concepts of Mongol Khans"[35].

Based on above mentioned, the "naran" tamgha on Genghis Khan's coin could be associated with the worshipping of the sun and heaven, and regarding them as superior by Mongols.

The great honor of Genghis Khan and the "naran" tamgha are not inscribed on the same coin accidentally. Tamghas originated from the "naran" tamgha and inscribed on coins of many khans of Genghis Khan's golden

[31] Dulam S. p.57
[32] Dulam S. p.58
[33] Rashid-ad-Din. The Assembly of Sutras I. Ulaanbaatar. 2002
[34] Rubruk G. Jorney to the East. Ulaanbaatar, 1988, p.108
[35] Bira Sh. From the history of cultural relations during the period of ancient empire of Mongols. Historical Study. Tomus XXX, Fasc.10, Ulaanbaatar. 2000. p.10

тамгад байдаг нь алтан ураг угаас дээд тэнгэрээс заяатай гэдэг үзэл баримтлалын илэрхийлэл буйзаа.

generation could be an expression of a concept that the golden generation is destined from the supreme heaven.



Үүнээс үүдэн наран буюу онгин тамга, тэр дотроо ширээтэй онгин тамга Чингис хааны овгийн тамга байх үндэслэл байна гэх таамаглал төрж байна.

Therefore, the hypothesis is being formulated that there is basis for identifying the "naran" or "ongin" tamgha, including "shireetei ongin" tamgha, as a tamgha of Genghis Khan's clan.

Qunduz mint "Adl"

Чингисийн зоосон дээрхи нуман тамгатай төстэй тамгатай өөр нэгэн зэс зоос байдгийг Роберт Тай Чингис хааны зоос байж болзошгүй гэж тэмдэглэснийг[36] энд дурдая. Ер нь Монголын олон овог аймгууд нийлж нэгдэж байсан тул нэг удамд нь хэд хэдэн тамга байсан байж болох юм. Иймээс Чингисийн удамд ч 2-3 тамга байсныг үгүйсгэх аргагүй юм.

Цаашид миний бие эзэн Чингис хаан, түүний дөрвөн их хөвгүүд, тэднээс залгасан хаан, хан нар ямар тамгатай байсан болохыг тэдний нэр алдрыг мөнхлөн үлдээсэн зоосон дээрхи тамгадыг баримтлан тодруулахыг оролдлоо.

I would like to mention here that Robert Tye had noted an existence of a copper coin, which could be the one of Genghis Khan, as it has the tamgha, similar to "numan" tamgha on Genghis coin.[36] Since many Mongol tribes were uniting, there is a possibility that a lineage had several tamghas. Therefore, it can not be denied that Genghis' lineage had 2-3 tamghas.

Hereinafter, I made an attempts to identify tamghas of Genghis Khan, his four great sons and their successors by tracking down the tamghas on coins, which have perpetuated their honor.

*Перс зургийн цувралаас*

*From Persian miniature*

[36] Robert Tye. Jitals. p.141. #334.1, #334.2,

[36] Robert Tye. Jitals. p.141. #334.1, #334.2,

**“Тэмүжин хаан ширээнд заларч буй нь”**
(XIV зууны Перс зургийн цувралаас)

**“Temujin (Genghis khan) enthroned”**
“Persian miniature” XIV century



Чингис хаан Их Улсаа
хуваан гэрээслэж байгаа нь
(XV зууны Энэтхэг зургийн цувралаас)



Partition of the Empire to successors for inheritance (Genghis khan)
"Indian miniature" XV century

## 1.2. ЗҮЧИ ХААНЫ ТАМГА

Зүчи хааны ямар нэгэн зоос одоо хэр олдоогүй байгаагаас үндэслэн ерөөс Зүчи хааны зоос гараагүй байх гэж судлаачид таамагладаг.

Чингис хаан сэрүүн тунгалаг ахуйдаа Их гүрний бүх эзэмшил газраа дөрвөн хүүдээ хуваажөгсөн[37] ёсоор Зүчид хожмын Алтан Ордны Улсын нутаг бүхэлдээ ногдож тэр газрыг захиран суух эрхийг хаан эцгээсээ авсан хэдий ч тэрээр хаан сууж амжилгүй 1227 онд нас барсан[38] тул түүний нэр алдар, тамгатай зоос гараагүй гэж үзэж болох юм.

Гэвч Зүчи Чингис хааны ахмад хүүгийн хувьд эцгийн овгийн сүлд тамгыг мэддэг байсан, түүнийг нь залгаж авах боломжтой байсан хүн. Тэрээр эцгээс өрх тусгаарлаж, эцгээс өгсөн нутагт эзэн суух эрх олсон байсан тул өөрийн удам угсааг бий болгож, өөрийн сүлд тамгатай нэгэнт болсон байх үндэстэй юм. Алтан Ордны ихэнх хаадууд Чингис хааны наран тамгаас дам үүсгэсэн шинжтэй тамгатай байсан нь тэдний зоосон дээр үлдсэн байна.[39]

Иймээс Зүчи эцгийн наран тамгыг залгаж түүнээс цаашхи Зүчийн удмын хаадууд ч тус тусын төстэй тамгатай байжээ гэсэн дүгнэлт хийж болохуйц санагдаж байна.

Миний ажигласнаар овгийн тамга залгамжилсан хүн түрүү үеийнхээ тамгыг тэр хэвээр нь авдаггүй, харин уг тамганы үндсэн шинжийг хадгалсан дүрс оролцуулсан шинэ тамга үүсгэж өөрийн угсааны тамга болгож байсан бололтой. Энэ зарчмыг баримтлан Зүчийн тамга ямар байж болохыг төсөөлөх оролдлого хийж болмоор байна.



## 1.2. TAMGHA OF ZUCHI KHAN

Since no coins of Zuchi Khan have been found so far, therefore the researchers present a hypothesis that coins of Zuchi khan had never been minted.

When in his good health Genghis Khan divided the whole territory of Great Empire among his four sons[37], Zuchi had descended the whole territory of later Golden Horde as well as a right to rule and govern it. However, he passed away in 1227 with no time to rule it[38], and therefore it could be considered that no coins were issued with a fame and tamgha of Zuchi Khan.

However, as the eldest son of Genghis Khan, Zuchi knew his father's clan arm tamgha and had a cahnce to inherit it. He had all reasons to build up his own lineage and have his own arm tamgha as he was granted the right to set up a branch of lineage and to rule the land descended by his father. Most of Khans of the Golden Horde owned tamghas that had features indirectly derived from "naran" tamgha of Genghis Khan and these tamghas were engraved on their coins[39].

Therefore it seems possible to make a conclusion that Zuchi had inherited his father's "naran" tamgha and successor khans of Zuchi had their own similar tamghas.

According to my observations, a person inherited the clan tamgha would not take the tamgha of the earlier generation unchanged, but, by conserving its main features, would create a new one to use it as his own lineage tamgha. Guided by this principle, it seems possible to try to imagine the tamgha Zuchi could have had.

Монголын цэрэг Европт

Mongols invade Europe

[37] Монгол Улсын түүх. Дэд боть. х.267
[38] Монголын нууц товчоо, 242-р бүлэг, х. 159-160.
[39] Дараагийн хуудсуудыг үзнэ үү.

[37] History of Mongolia. Second book. p.267
[38] The Secret History of Mongols, Chapter 242, p.159-160.
[39] See next page.




*а.* Чингисийн зоосны тамга

*б.* Зүчийн хүү Батхааны зоосны тамга

*c.* ?

*a.* Tamgha of Genghis' coin

*b.* Tamgha of Batu Khan's (son of Zuchi) coin

*c.* ?

Энэ хоёр тамганд (а, б) хоёуланд нь давтагдсан ижил элемент нь сүүлтэй онги гэгдэх дүрс байгаа юм. Энэ бол Х.Пэрлээ гуайн оноосон нэр.[40] Энэ дүрсийг Монголын эртний хад чулуун дээрхи тамгын дүрсүүд дотор үзэж болно.

Both tamghas (a, b) have the same repeated element, which is a figure called "suultei (means "with tail" in Mongolian) ongi" The name to this figure was given by Kh.Perlee[40]. It can be found among the tamgha figures on ancient rocks of Mongolia.

Чингис хаан, Бат хааны хоёрын зоосны тамгуудад давтагдаж байгаа энэхүү дүрс Зүчийн овгийн тамга байх магадлал их санагдана. Тэгээд ч энэ тамга Алтан ордны төдийгүй МЭГ-ний аль ч үеийн зоосон дээр ерөөс давтагдаагүй байгаа нь энэ тамгыг Зүчийнх гэх итгэлийг төрүүлж байна.

There is a high probability that this figure, which has been repeated on coin tamghas of both Genghis Khan and Batu Khan, could be the Zuchi's clan tamgha. Moreover, the fact that this tamgha has not been repeated on coins of Golden Horde or of any other periods of Mongol Empire, makes us to believe that it could be the one of Zuchi.




[40] Х.Пэрлээ. 183-187

[40] Perlee Kh. 183-187

Алтан ордны тамгатай зооснуудын заримыг дор үзүүлэв.

Some coins with Golden Horde tamghas are shown below.

**Бат хааны үе**
Булгарт дэлдүүлсэн зоос
(603-624 AH/1206-1227 AD)

N. 76

temp. **Batu Khan**
Bulghar mint

**Бэрх хааны тамгатай зоос**
(654-665 AH/1256-1266 AD)

N. 80

**Coin with Berkhe Khan's clan tamgha**
(654-665 AH/1256-1266 AD)

**Мөнхтөмөр хаан. Тамга**
(665-679 AH/1267-1280 AD)

N. 82

**Monghe Timur Khan. Tamga**
(665-679AH/1267-1280AD)

**Мөнхтөмөр хаан. Тамга**
(665-679 AH/1267-1280 AD)

N. 81

**Coin with Monghe Timur Khan's clan tamgha**
(665-679 AH/1267-1280 AD)

**Тольбуга хаан.** Тамга
(686-689AH/1287-1290AD)

N. 85

**Tole Buqa Khan.** Tamgha
(686-689AH/1287-1290AD)

**Тодмөнх хаан.** Тамга
(679-686 AH/1267-1280 AD)

N. 84

**Toda Monghe Khan.** Tamgha
(679-686 AH/1267-1280 AD)

**Тогтох хаан.** Тамга
(689-712 AH/1290-1312 AD)

**Togtu Khan.** Tamgha
(689-712 AH/1290-1312 AD)

**Тогтох хаан.** Тамга
(689-712 AH/1290-1312 AD)

**Togtu Khan.** Tamgha
(689-712 AH/1290-1312 AD)

**Тогтох хаан.** Тамга
(689-712 AH/1290-1312 AD)

**Togtu Khan.** Tamgha
(689-712 AH/1290-1312 AD)

**Тогтох хаан.** Тамга
(689-712 AH/1290-1312 AD)

**Togtu Khan.** Tamgha
(689-712 AH/1290-1312 AD)

**Узбек хаан.** Тамга
(712-742 AH/1312-1341 AD)



**Uzbek Khan.** Tamgha
(712-742 AH/1312-1341 AD)

**Абдаллах хаан.** Тамга
(762-771 AH/1361-1370 AD)

**Abd Allah Khan.** Tamgha
(762-741 AH/1361-1370 AD)

**Үлүх Мухаммад.** Тамга
(840-871 AH/1435-1466 AD)

**Ulugh Muhammad Khan.**
Tamgha
(821-828 AH/1418-1425 AD)

**Күчүк Мухаммад.** Тамга
(840-871 AH/1435-1466 AD)




**Kuchuk Muhammad Khan.**
Tamgha
(840-871 AH/1435-1466 AD)

*Сур харваж байгаа монгол хүн* *Mongol bending a bow*

## 1.3 ӨГЭДЭЙ ХААНЫ ЗООСНЫ ТАМГА (624-639 АН/1227-1241 AD)

Чингис хааны зоосон дээрхи Наран тамганы доод талд залгуулан тавьсан эвшээлгэсэн нум сум бол Өгэдэйн тамга мөн. "Харвах намнахуяа бэлхэн"[41]-ийг илтгэсэн нуман тамга дайчин, баатарлагийн бэлэгдэл бас болдог. Дээр дурьдсан Чингис хааны зоосыг 1227 онд буюу Чингис хаан тэнгэрт хальсан жил гаргасан байдаг. Чингис хаан нас эцэслэхээсээ өмнө өөрийн 3-р хүү Өгэдэйгээр хаан ширээ залгамжлуулахаа зарласан[42] байсан тул Өгэдэй их хаан болох нь тодорхой болсон байв. Иймээс ч Чингис хааны зоосон дээр түүний наран тамгыг залгуулан Өгэдэйн нуман тамгыг тавьсан болов уу гэж бодогдоно.

Ер нь Өгэдэйн зоос нуман тамгатай байсныг дэлхийн томоохон судлаачид ном, каталогт дурьдсан байдаг. АНУ-ын нэрт зоос судлаач, доктор Стефен Албумын бүтээсэн "Исламын улсуудын зоосны жагсаалт"[43] каталог дэлхийн зоос судлаачдын гол баримтладаг каталог юм. Энэ каталогоос үзвэл Өгэдэй хааны нуман тамгатай зоос 1227-1242 оны хооронд гарч байжээ[44].

## 1.3 THE TAMGHAS ON COINS OF UGEDEI KHAGAN (624-639 AH/1227-1241 AD)

The slightly bent bow and arrow inscribed at the bottom of "naran" tamgha on the coin of Genghis Khan is the Ugedei's tamgha.

The "numan" tamgha also symbolizes warrior and heroism expressing "the readiness to shoot and hunt"[41]. The above-mentioned coin of Genghis Khan was issued in 1227 or in the year when Genghis Khan passed away. It was definite that Ugedei would become a Great Khan as before his death Genghis Khan declared to pass his throne on to his third son, Ugedei[42]. Possibly that is why Ugedei's numan tamgha is added to the "naran" tamgha on the coin of Genghis Khan.

The world well-known researchers refer in books and catalogues that Ugedei's coins contain "numan" tamgha. "A checklist of coins of Islamic countries"[43] by famous American numismatist Dr. Stephen Album is the main catalogue used by numismatists of the world. According to the catalogue the Ugedei Khagan's coin with "numan" tamgha was issued between 1227-1242[44].

qu-an
al A-dil
"Аугаа их хаан"[45]

qu-an
al A-dil
The Great Khan[45]

Өгэдэйн зоосон дээрх нуман тамга хэлбэрийн хувьд нилээд хэдэн янз байдаг бөгөөд энэ нь газар газрын хийц, зоосны хэв хийсэн дархчуудын зохиомжтой холбоотой юм.

With regard to a shape, there are number of types of numan tamgha on coins of Ugedei, and this variety is related to craftsmanship at various locations and with the design of a craftsman, who made a mold.

[41] С.Дулам, УБ, 2001. х 99
[42] Рашид Ад дин. Судрын чуулган, II дэвтэр. Х 4
[43] Стефан Албум. Исламын зооснуудын жагсаалт. Хоёр дахь хэвлэл. 1998
[44] Стефан Албум. Өгэдэйн зоосны нумтай хэлбэр. А-1973, А-1974. х. 98
[45] Монголбанкны цуглуулгаас

[41] Dulam S., p.99
[42] Rashid Ad Din. II, p.4
[43] Stephen Album. A checklist of Islamic coins. Second edition. 1998
[44] Stephen Album. p. 98, Ugedei Bow type. A-1973, A-1974
[45] From the collection of the Bank of Mongolia

*Өгэдэй хаан Д ргэнэ хатны хамт (XIV зууны Перс зургийн цувралаас)*
*Ugedei and Turakina khatun "Persian miniature" XIV century.*

*Өгэдэй хаан суусан нь*
*(XIV зууны Перс зургийн цувралаас)*

***Ugedei enthroned***
*"Persian miniature" XIV century.*

Sarai
Al-a'zam Qa-an

Сарай хот

Их хаан

N. 7

Sarai
Al-a'zam Qa-an

Sarai city

Great Khan

Sarai

Al-a'zam Qa-an

Сарай хот

Их хаан

N. 8

Sarai

Al-a'zam Qa-an

Sarai city

Great Khaan

Энэ зоосыг 1241 онд хийсэн бололтой. 1241 онд Бат хаан Алтан Ордны улсыг байгуулж Сарай хотод нийслэлээ үүсгэж байх үед Өгэдэй МЭГ-ний Их хаан байсан тул түүний тамга ийнхүү Алтан Ордны Сарайд цутгасан зоосон дээр мөнхөрчээ. Бат хаан Чингис хааны дэргэд өссөн, түүний хайртай ач хүү нь байсан тул хаан төрийн зарлигийг хатуу баримталдаг, Чингис хааны гэрээслэлд туйлын үнэнч, хан хөвгүүдийн дотор хамгийн ахмад, хамгийн их нэр хүндтэй нь байв. Тэрээр Өгэдэйн нуман тамгатай зоосыг харъяат улсдаа цутгасан нь эв эеийг сахих[46] тухай Чингис хааны гэрээслэлд үнэнчээ харуулж, бусад хан хөвгүүдэд үлгэр болохын зэрэгцээ түүний захирсан Алтан Ордны Улс нь МЭГ-ний Их хаан Өгэдэйн харъяанд байгааг нотолсон хэрэг гэж үзүүштэй. Ер нь Алтан Ордны Улсад МЭГ-ний Их хааны тамгатай зоос гарч байсан нь ганц энэ тохиолдол биш юм. Бат хааны үед Алтан Ордод Мөнх хааны тамгатай зоос гарч, хожим нь Батын залгамжлагчид Аригбөхийн тамгатай зоос гаргаж байжээ.

Өгэдэй хааныг нас эцэслэсний дараа түүний хоёрдугаар хатан[47] **Дөргэнэ** (Turakina Khatun, 639-644AH/1241-1246AD) таван жилийн турш Монголын төрийн

Possibly that this coin was struck in 1241. At the time when Batu Khan has established the Golden Horde in 1241 and set the capital city in Sarai, Ugedei was the Great Khan of Mongol Empire, thus his tamgha has been perpetuated on coins struck in Sarai of Golden Horde. Since Batu Khan was grown up next to Genghis Khan and was his beloved grandson, he strictly pursued a decree of Khan State, was extremely loyal to will of Genghis Khan and was the eldest as well as the most respectable among young princes. It should be considered that by striking the coin with "numan" tamgha of Ugedei in subjected countries he displayed his loyalty to the will of Genghis Khan to maintain the unity[46], and thus became a good example to other young princes, while at the same time he proved that the Golden Horde, governed by him, belongs to Ugedei, the Great Khan of Mongol Empire. It is not the only case when the coin with tamgha of Mongol Empire was issued in Golden Horde. During Batu Khan's reign, the coin with tamgha of Munghe Khagan was issued in Golden Horde, while later descendents of Batu Khan struck the coin Ariq Buga's tamgha.

After the death of Ugedei Khagan, his second queen Turakina Khatun[47] (1241-1246) run the Mongol state affairs for five years. The coin of queen Turakina had also

[47] Рашид Ад Дин. II дэвтэр. х.5
[46] Рашид Ад Дин, I дэвтэр, х.375

[47] Rashid Ad Din. II. p.5
[46] Rashid ad Din, I, p.375

хэргийг явуулж байв. Дөргэнэ хатны зоос бас нумтай байдаг нь мөн л Өгэдэй хааны овгийн тамгыг залгамжилсан шинжтэй байна.

an inscription of "num", thereby demonstrating inheritance of clan tamgha of Ugedei Khagan.

Морь нохой дагуулсан хүн эмээл дээрээ эргэн харж нум сумаар шувуу харваж буй байдлыг зоосны нүүрэн талд дүрсэлжээ. Зоосны дээд хэсэгт "Ulugh Mongul Ulus Beg" (Их Монгол Улсын Хан) гэж түрэг хэл дээр араб үсгээр бичжээ.

N. 11

On observe the coin has the image of a riding man, sitting backwards on his saddle and shooting a bird with bow and arrow, and followed by the dog. On the top of the coin it is written "Ulugh Mongul Ulus Beg" (Khan of Great Mongol Empire) in Turkish by Arabic letters.

Ulugh Mongul Ulus Beg[48] الغ منقدالوش بيک Khan of the Great Mongol Empire[48]

Дөргэнэ хатны зоосыг хэд хэдэн газар хийж байсан (Тифлис, Кожек, Армений Нахачеван) тул дүрсийн хувьд хоорондоо ялгаатай харагддаг боловч ерөнхий төрх нь ижил, одоо ихээхэн ховор зоосны нэг болсон.

As coins of queen Turakina were struck in number of different places (Tiflis, Kojek, Nakhachevan of Armenia), the images on them vary, although the same characteristic features are preserved. At present, this is one of the rarest coins.

49

50

51

52

Өгэдэй хааны нуман тамга Дөргэнэ хатнаас хойшхи хаадуудын зоосон дээр үзэгдэхгүй байгааг үзвэл Өгэдэйн удмын хаадууд цаашид нуман тамга залгамжлаагүй бололтой.

Since the "numan" tamgha of Ugedei Khagan had not been seen on coins of queen Turakina successors, one can assume that subsequent generations of Ugedei Khagan did not inherit the "numan" tamgha any further.

Өгэдэй хааны үед гарсан Монголын зарим зооснууд дээр дэгрээ тамга бас байдаг. Энэ нь түүний хоёр дахь тамга мөн.



The "degree" tamgha (or "S" tamgha) appeared on some Mongol coins, which were issued during the period of Ugedei Khagan. This is his second tamgha.

[48] Түрэг хэл дээр
[49] Стенлей Лейн Руул. Британы музей дэх монгол зоос. Ангилал XVIII-XXIII. Лондон 1881. х.5
[50] "Vente Publique". Аукцион 78. Жан Элсон & ses Fils s.a. Брюссел. 2004
[51] Монгол ба Илхан зоос (Mongol and Ilkhanid coins). Япи Креди банкны цуглуулга. Истамбул. 1992
[52] Mocarstwa swiata. Том 4 (Чингис хаан) Варшав. 1995

[48] In Turkish language
[49] Stanley Lane-Poole. The coins of the Mongols in the British Museum. Classes XVIII-XXII, p.5
[50] "Vente Publique". auction 78. Jean Elsen & ses Fils s.a. Bruxelles 2004
[51] Ak akche Mogol Ve Ilkhani Sikkeleri (Mongol and Ilkhanid coins). Yapi Credi Koleksiyolari. Istambul 1992
[52] Mocarstwa swiata. Tom 4 (Dzyngis Chan) Warszawa. 1995

"Самарканд болон тус хотын орчимд энэ зоосыг үл хэрэгссэн хүн гэмт хэрэгтэн болой"[53].

N. 10

"Whoever in Samarqand and in environs of this city does not accept this coin will be a criminal"[53]

Өгэдэй хааны тамгатай Самаркандад дэлдүүдсэн зоос[54]
A-A1974RRR

z. 10761

The coin with Ugedei Khan's tamgha struck in Samarqand[54]
A-A1974RRR

Энэ хоёр зоосыг 1227-1239 оны хооронд хийсэн нь Өгэдэйн хаан сууж байсан үе юм. Энэ хоёр зоосон дээр содон харагдах "S" дэгрээ тамга нь Өгэдэй хааных юм.

Дэгрээ "S" тамганы гарал үүслийг судлахад сонин байв.

Доктор Ц.Шагдарсүрэн гуай эртний аваруудын булшнаас олдсон зүүний хайрцаг дээрх тамга үгсийг Орхон, Енисейн бичигтэй харьцуулан судласнаас гадна Хүннүгийн дурсгалуудаас олдсон тамга үсгүүдийг харьцуулсан судалгаа хийжээ.[55] Эдгээр тамга үсгүүдийг Монголын зоосон дээрх тамгуудтай харьцуулан үзэхэд ихэд сонин байсныг хэлэх хэрэгтэй. Тухайлбал, "Рун үсгийг харьцуулсан хүснэгт"-ийн 1, "Хүн(нү)-ий тамга үсэгтэй харьцуулсан жагсаалт"-ын 4 ба 28 дугаарт  хэлбэртэй тамга үсгүүд оржээ. Эдгээрийг эртний рун бичгийн "а" дуудлагатай үсэг гэж тэмдэглэжээ.[56]. Эдгээр тамга үсэгнүүд нь Өгэдэйн үед 1228 онд Самаркандад гарсан мөнгөлсөн зэс зоосны нүүрэн талын дээд хэсэгт байгаа тамгатай нэн төстэй юм. Ийм тамга манай орны эртний хад чулууны дүрснүүд дотор цөөнгүй байна.

These two coins were issued between 1227-1239, which was the period of Ugedei Khagan's reign. The unique "S" tamgha on these coins belongs to Ugedei Khagan.

It was interesting to study the origin of "S" tamgha.

Besides undertaking a comparison of tamgha letters on the needle box found from ancient Avarian graves with scripts of Orkhon and Enisei river basins, Dr. Ts.Shagdarsuren had also conducted a comparative study of tamgha letters found on Hunnu monuments[55]. It should be mentioned that it was quite interesting to compare tamgha letters with tamghas on Mongol coins. For example, there are  shaped tamgha letters in No.1 of "Comparative table of Run letters" and No.4 and No.28 of "Comparative list of tamgha letters of Hunnu". These letters are marked as letters of ancient run script with "a" pronouncing[56]. These tamgha letters are very similar to "S" tamgha inscribed on the top of obverse of silver coated copper coins, which were issued in Samarqand in 1228 at the period of Ugedei Khagan reign. These tamghas can be often found among ancient rock figures of our country.

[53] Давыдович Е.А., стр 14
[54] Давыдович Е.А., стр 17
[55] Ц.Шагдарсүрэн "Монголчуудын үсэг бичгийн товчоон". УБ 2001. х 29
[56] мөн тэнд

[53] Davidovich E.A., p. 14
[54] Davidovich E.A., p. 17
[55] Shagdarsuren Ts. "Spiritual Culture of Mongols". UB 2001. p. 29
[56] same page

Үүнийг дэгрээ, бас зуузай тамга[57] гэнэ. Дээрх тамга Сэцэн хан аймгийн Боржигон Сэцэн ван, Чин ачит ван, Илдэн вангийн хошууд, Хар дэл жанжин гүний хошуу, Зоригт Бэйс, Эрх гүний хошууд зэрэгт ихэд тархсан байна. Тэгэхээр энэхүү дэгрээ тамга нь манай Монголын эртний уламжлалт түгээмэл тамганы нэг ажээ. Бэлгэдэл нь гай түйтгэрийг арилгах, олз омог оруулах гэх мэт.[58] Энэхүү дэгрээ тамгыг чухамхүү Өгэдэй хааных гэдгийг хэрхэн яаж таньсан бэ гэдэг нь сонин асуудал юм.

Оросын Эрмитажид МЭГ-ний нэгэн гайхамшигтай зоос хадгалагдаж байгаа бөгөөд[59] энэ зоос одоогоор цорын ганц хувь мэдэгдэж байгаа юм. Энэ зоосны зургийг 1930 онд ЗХУ-ын нэгэн сэтгүүлд анх нийтэлсэн[60] боловч уг зоосон дээрх бичээс, тамганы учрыг сайн тайлж чадаагүй байсныг Оросын эрдэмтэн П.Н.Петров тайлж тодотгон надад ирүүлсэн юм. Тэрээр энэ тухайгаа "Tamghas on the coins of Mongol State of 13-14th centuries as signs of Property" гэдэг илтгэл бичиж, Монгол зоос судлалын эрдэм шинжилгээний бага хуралд оролцуулсан нь ойрын үед хэвлэгдэх юм байна.

Зоосны нүүрэн талд бундан тамга, ар талд дэгрээ тамга байна. Нүүрэн талын гаднах хүрээгээр "yarly Ogty, yarly Chagty" гэж бичсэн нь утгачилбал "Өгэдэйн зарлиг Цагаадайн зарлиг" гэсэн үг юм.

Өөрөөр хэлбэл энэ зоосон дээр "*Өгэдэй, Цагаадайн зарлиг*" гэж бичээд энэ хоёр хааны тамга тавьсан байгаа хэрэг юм. Чингис хааны зоосон дээр "Чингис хааны зоос" гэж бичээд тамга тавьсантай нэгэн адилаар энэ зоосон дээр мөн Өгэдэй, Цагаадай хаадын нэр тамгыг тавьсан байна. Үүнээс илүү тодорхой баримт гэж бараг байхгүй бизээ. Чухам эндээс эхлэн Өгэдэйн овгийн тамгыг баттай танисан гэж үзэж болно.

Өгэдэйн удмынхны зоосон дээр

[57] Х.Пэрлээ, х 225, 229
[58] С.Дулам. х 80-86
[59] State Hermitage Museum Collection. Inventory. #30350
[60] Likhachev N.P. Materialy dlya istorii visantiiskoi I russkoi sfagistiki. In: Trudy Museia Paleografii. AN SSSR. T.2. Leningrad. 1930. PP96-97, 105-106, 147-148



They are called "degree" and "zuuzai" tamghas[57]. This tamgha is widely spread in Borjigin Setsen Van, Chin Achit Van and Ilden Van khoshuns, Khar Del General Gun's khoshun, Zorigt Beis and Erkh Gun's khoshuns of Setsen khan province. Thus this degree tamgha is one of the ancient as well as widespread tamghas of Mongolia. It symbolizes elimination of misfortune, bringing profit, etc.[58] It is interesting to learn how the degree tamgha was identified to belong to Ugedei Khagan.

There is a unique coin of Mongol Empire preserved in Hermitage of Russia[59] and it is the only copy known at the present. The photograph of this coin was published for the first time in a magazine[60] of the Soviet Union in 1930, however writings and tamghas on the coin that could not be clearly explained then were interpreted by Russian scientist P.N.Petrov and were sent to me. He wrote a presentation "Tamghas on the coins of Mongol State of XIII-XIV centuries as Signs of Property", which will be presented at the scientific conference on Mongolian numismatics and will be published soon.

There is a "bundan" tamgha on obverse and a "degree" tamgha on reverse of the coin. On the margin of the obverse it is written "yarly Ogty, yagty Chagty" meaning "Decree of Ugedei, Decree of Chaghatay".

In other words, on this coin words "By Decree of Ugedei and Chaghatay" are written and tamghas of these two khans are inscribed. Similar to the coins of Genghis Khan containing the tamgha and writing "The Coin of Genghis Khan", this coin also has names and tamghas of Ugedei and Chaghatay inscribed on it. It is hard to find more definite fact than this coin. It can be considered that starting from this fact and on the tamgha of Ugedei's clan was undoubtedly identified.

[57] Perlee Kh, p. 225, 229
[58] Dulam S. p. 80-86
[59] State Hermitage Museum Collection. Inventory. #30350
[60] Likhachev N.P. Materialy dlya istorii visantiiskoi I russkoi sfagistiki. In: Trudy Museia Paleografii. AN SSSR. T.2. Leningrad. 1930. PP96-97, 105-106, 147-148

хамгийн элбэг тохиолдож байгаа нь дэгрээ тамга юм.

Өгэдэйн ач хүү **Хайду (668-701AH/ 1269-1302 AD)** "эцэг өвгөдийн уламжлалт ёсыг эвдэж хаан ширээ эзлэн Хятадын нөлөөнд орсон хэмээн Хубилайг буруутгаж"[61] олон жилийн турш түүнтэй тэрсэлдэн тэмцэж Дундад Ази, Цагаадайн улсын өргөн уудам нутгийг эзэлсэн өөрийн улсыг байгуулж явахдаа өвөг эцгийнхээ овог угсааны дэгрээ тамгатай зоосыг олноор нь гаргаж байв. Гэхдээ энэхүү дэгрээ тамга нь олон янзын хэлбэр хувилбартай үүсгэмэл тамгад болсон байна.

The "degree" tamgha is the most common tamgha found on coins of Ugedei's lineage.

The grandson of Ugedei, Qaidu **(668-701AH/1269-1302 AD)** had opposed and struggled with Khubilai Khagan for many years "accusing him for breaking the tradition of ancestors by taking over the throne and for falling under the influence of China."[61] While establishing his own state on vast territories of Chaghatayids and Middle Asia, he issued a large amount of coins with "degree" tamgha of his ancestors. However, the "degree" tamgha has been changed into a derived tamghas with various kinds of shape and type.



Дэгрээ (зуузай) тамганы ялгаа төрөл, тархсан байдал, оноосон нэрний талаар доктор С.Дулам гуайн номноос дэлгэрэнгүй үзэж болно.[62]

The differences and features of "degree" (or "zuuzai") tamgha, its distribution and designated names can be comprehensively referred from the book of Dr.S.Dulam.[62]

**Хайду Хааны үе**
Бухарт дэлдүүлсэн зоос

temp. **Qaidu Khan**
Struck in Bukhara

**Хайду Хааны үе**

temp. **Qaidu Khan**

**Хайду Хааны үе**

temp. **Qaidu Khan**

[61] Монгол Улсын түүх. Дэд боть. 199-р х
[62] С.Дулам, х 80-86

[61] History of Mongolia. Second book. p. 199
[62] Dulam S, p.80-86

**Хайду, Төг Төмөр, Дува, Чапар хаадын үе**
(668-701AH/1269-1302 AD)

**temp. Qaidu, Tuqa Timur, Duwa, Chapar**
(668-701AH/1269-1302AD)

**Хайду Хааны үе**
(668-701AH/1269-1302 AD)

**temp. Qaidu Khan**
(668-701AH/1269-1302AD)

**Адил Султан**
(765-771AH/1364-1370 AD)

z. 4242

**Adil Sultan**
(765-771AH/1364-1370AD)

Өгэдэйн удамд илэрсэн гуравдахь тамга бол холбоо онгин тамга юм.



Өгэдэйн удамд **Гүюг хааны (644-647 АН/1246-1249 AD)** зоос Чингис хааны зоосны адил наран (онгин) тамгатай болохыг судлаачид тогтоожээ.

Гүюг хааны зоосны тамгыг холбоо онги[63] гэх бөгөөд ийм тамга Монголын эртний хад чулуун дээр ч үзэгдэнэ. Үүний нэг жишээ нь Өвөрхангай аймгийн Баруун Баян Улаан сумын Хутагт ууланд буй түрэгийн бичээтэй хаданд ийм дүрс байдаг.[64] Мөн Төв, Өмнөговь, Говь-Алтай, Архангай (Тайхар чулуу) аймгуудад байдаг эртний чулууны тамгадын дотор ч энэ тамга тааралдана.[65]

Гүюг хааны үед гарсан холбоо онгин тамгатай зооснуудын зургийг дор үзүүлэв.

The third tamgha found in Ugedei's lineage is "kholboo ongi" tamgha. The researchers have identified that in Ugedei's lineage, coin of Guyuk Khagan (644-647 AH/1246-1249 AD) had "naran" (ongin) tamgha, similar to the coin of Genghis Khan.

The tamgha on the coin of Guyuk Khagan is called "kholboo ongi"[63] tamgha and it can be found on ancient rocks of Mongolia. One of its examples is a figure[64] on a rock with ancient Turkish script on Khutagt Mountain of Baruun Bayan Ulaan soum of Uvurkhangai province.

It also can be found among the tamghas on ancient stones in Tuv, Gobi-Altai and Arkhangai (Taikhar Rock) provinces. [65]

Below are the photographs of coins with "kholboo ongi" tamgha, which were issued during the period of Guyuk Khagan.

[63] Х.Пэрлээ. х.226
[64] Л.Болд. х.135
[65] Х.Пэрлээ. х.169, 171, 173, 177

[63] Perlee Kh. p.226
[64] Bold L. p.135
[65] Perlee Kh. p.169, 171, 173, 177

*Гүюг хаан.*
*(XIV зууны Перс зургийн цувралаас)*

*Guyuk Khagan.*
*(Persian miniature. XIVcentury)*

**Гүюг хааны** тамгатай зоос (Хорезмд)

The coin with **Guyuk Khan's** tamgha (Khwarizm)

**Гүюг хааны** тамгатай зоос (Хорезмд)

The coin with **Guyuk Khan's** tamgha (Khwarizm)

(Da Chao Tong Bao) **Хубилай хааны** үе, Юан улс байгуулагдахаас өмнөх үе




(Da Chao Tong Bao) **Khubilai Khan.** Pre-Yuan Dynasty

**Алуг хааны үе.**
Нүүрэн талд байгаа Аллах гэдэг араб үгний гол дунд Гүюг хааны тамга байна. Доод талд нь Монголоор "Орду" гэж бичсэн байна. Ар талд: "Их Орд" гэсэн үг байна.

temp. **Alugh Khan.**
On obverse: There is a Guyuk Khan's tamgha in the center of the Arabic word "Allah". Below, it is written "Horde" in Mongolian.
On reverse: Struck in Great Horde (Al Ordu)

**Алуг хааны үе.**
Нүүрэн талд байгаа Аллах гэдэг араб үгний гол дунд Гүюг хааны тамга байна. Доод талд нь Монголоор "Орду" гэж бичсэн байна.
Ар талд: "Их Орд" гэсэн үг байна.

temp. **Alugh Khan.**
On obverse: There is a Guyuk Khan's tamgha in the center of the Arabic word "Allah". Below, it is written "Horde" in Mongolian.
On reverse: Struck in Great Horde (Al Ordu)

Чухам яагаад гагцхүү Гүюг хааны зоос холбоо онгин тамгатай гарах болов гэдэг нь одоогоор тайлагдаагүй байгаа юм. Гэвч Чингис хааны онгин (наран) тамга энэ зоосон дээр байгаа нь Гүюг хаан Алтан ургийн хаан гэдгийг нь харуулж буй хэрэг байж болох юм.

Өгэдэй хааны болон түүний удмын хаадуудын зоосны тамгыг дараах хүснэгтэд үзүүлэв.

It is not yet identified why the coin of only Guyuk Khagan had an inscription of "kholboo ongi" tamgha. However, the fact that "ongin" (naran) tamgha of Genghis khan is engraved on this coin could a way to show that Guyuk Khagan was a khan of the golden generation.

The tamghas on coins of Ugedei Khagan and his successor Khans of his lineage are shown in the following table.



## 1.4 ЦАГААДАЙ ХААНЫ ЗООСОН ДЭЭРХ ТАМГА (624-639 AH/1227-1241 AD)

Өгэдэйн зоосон дээрх тамганы тухай хэсэгт дурдсан "yarly Ogty, yarly Chagty" гэсэн бичээстэй зоосон дээр нүднээ тод тусах зүрхэн тамга байгаа нь "yarly Chagty" буюу Цагаадайн зарлигийг дагуулан тавьсан түүний овгийн тамга юм. Өөрөөр хэлбэл Цагаадайн зарлигийг баталж буй тамга мэт утга агуулж байна.

Яг ийм зүрхэн тамга МЭГ-ний бусад хаадын зоосон дээр байхгүй байгаа нь энэ тамга гагцхүү Цагаадайнх гэдгийг давхар нотлох юм.

يارلغ اوقطى يارلغ جغطى
"yarly Ogty, yarly Chagty"

Эртний монгол угсаатнуудын тамгыг шүүрдэж үзвэл мөнөөх Рашаан хад[66], Хэнтийн аймгийн Идэрмэг сумын "Дүнгэнэдэг" хад[67], Тайхар чулуу[68] зэрэгт энэ тамга байхын гадна сүүлд өвөрлөгчид болон Сэцэн хан аймгийн Боржигин Сэцэн вангийн хошуу, Сан бэйсийн хошуу, То вангийн хошуу, Түшээт хан аймгийн Мэргэн вангийн хошуу зэрэгт байсныг[69] доктор С.Дулам тэмдэглэжээ. Доктор С.Дулам энэ тамгыг зүрхэн тамга хэмээсэн байна[70]. Харин Х.Пэрлээ гуайн номонд ийм дүрсийг бундан тамга[71] гэсэн байх боловч дүрсийг үзэх үл арай босоо болоод шовх үзүүртэй байна. Иймд С.Дулам авгайн нэрлэснээр зүрхэн тамга гэвэл зохимжтой санагдав.

Цагаадайн удмын хаадууд энэхүү зүрхэн тамганы хэв шинжийг хадгалсан тус тус үүсгэмэл тамгатай зоос гаргажээ. Эдгээрийг жагсаавал:

[66] Х.Пэрлээ, х 112, 113
[67] Х.Пэрлээ, х 164
[68] Х.Пэрлээ, х 171
[69] С.Дулам. Бэлэгдэл зүй. х 109
[70] Мөн тэнд
[71] Х.Пэрлээ. х 225



## 1.4 TAMGHAS ON COINS OF CHAGHATAY KHAN (624-639 AH/1227-1241 AD)

On the coin with writing "yarly Ogty, Yarly Chagty" mentioned in the earlier section concerning tamghas on coins of Ugedei Khagan, there is an eye-catching figure of "zurkhen" tamgha, which is the Chaghatay's clan tamgha and is inscribed next to the writing "yarly Chagty" or the decree of Chaghatay. In other words it carries the meaning of tamgha ratifying a decree of Chaghatay.

The fact that there are no same "zurkhen" tamghas on coins of other khans of Mongol Empire proves again that this tamgha belongs only to Chaghatay.

By browsing the tamghas of ancient Mongol ethnic groups, this tamgha can be found on Rashaan Rock[66], "Dungenedeg" Rock[67] (Ider soum, Khentii province) and Taikhar Rock.[68] As Dr.S.Dulam noted, later this tamgha was also found in Inner Mongolia, Borjigin Setsen Van khoshun of Setsen khan province, San Beis khoshun, To Van khoshun and Mergen Van khoshun of Tusheet khan province[69]. Dr.S.Dulam named this tamgha as "zurkhen" tamgha[70]. Although this figure is called "bundan" tamgha in the book of Kh.Perlee, by examining the figure one can see that it is more vertical and has got cone-shaped tips[71]. Therefore, it seems appropriate to name it as "zurkhen" tamgha as designated by S.Dulam.

Khans of Chaghatay's lineage issued coins with different tamghas, while preserving characteristics of "zurkhen" tamgha. Following is the list:

[66] Perlee Kh, p.112, 113
[67] Perlee Kh, p.164
[68] Perlee Kh, p.171
[69] Dulam S. p.109
[70] Same page
[71] Perlee Kh, p.225

**Цагаадайн улсын эхэн үе**
(637-690 AH/1237-1291 AD)

**Early period of Chaghatayids**
(637-690 AH/1237-1291 AD)

**Дува хааны үе**
(668-701 AH/1269-1302 AD)

temp. **Duwa Khan.**
(668-701 AH/1269-1302 AD)

**Кебек** хааны нэртэй зоос.
(718-726 AH/1318-1326 AD)
Зоосны ар талд **Дува** хааны тамга байна.

Coin with name of **Kebek Khan** (718-726 AH/ 1318-1326 AD)
Reverse -Duwa Tamgha

**Кебек** хааны нэртэй зоос.
(718-726 AH/1318-1326 AD)

Coin with name of **Kebek Khan** (718-726 AH/ 1318-1326 AD)

**Дармаширин хаан**
(726-734 AH/1326-1333 AD)

**Tarmashirin Khan.**
(726-734 AH/1326-1333 AD)

**Жэнкши Хаан**
(734-737 AH/1333-1336 AD)




**Jenkshi Khan**
(734-737 AH/1333-1336 AD)

**Мухаммад хаан**
(741-742 AH/1340-1341 AD)

**Muhammad Khan**
(741-742AH/1340-1341AD)

**Халилаллах Хаан**
(742-744 AH/1341-1343 AD)

**Khallil Allah Khan**
(742-744AH/1341-1343AD)

**Хасан Төмөр Хаан**
(744-747 AH/1343-1346 AD)

**Ghazan Timur Khan**
(744-747AH/1343-1346AD)

**Хасан Төмөр Хаан**
(744-747 AH/1343-1346 AD)




**Chazan Timur Khan**
(744-747AH/1343-1346AD)

**Данишмэнд Хаан**
(747-749 AH/1346-1348 AD)

**Danishmandi Khan**
(747-749AH/1346-1348AD)



## 1.5 ДУВА ХААНЫ ЗООСНЫ ТУХАЙ

Дува хааны тамганы тухай хэдэн үг хэлэх нь зүйтэй болов уу.

Дува бол Чингис хааны гуч хүү, Цагаадайн улсын арав дахь хаан байлаа. Түүнээс хойш тус улсад дан ганц Дувагийн удмынхан хаан суусан тул Цагаадайн улсын зоосны тамгадыг нэгтгэн харахад Дувагийн тамга зонхилж байдаг нь аргагүй юм.

## 1.5 ABOUT THE COIN OF DUWA KHAN

It is appropriate to tell some words about the tamgha of Duwa Khan.

Duwa is a great-grandson of Genghis Khan and was a tenth Khan of Chaghatayids. Since Duwa Khan only his descendents reigned the Chaghatayids and thus it is logical that Duwa's tamghas dominate in the review of tamghas on coins of Chaghatayids.



Энэ тамгыг монголоор чухам юу гэж нэрлэдэгийг хэлэхэд ч хэцүү байна. Уг тамганы ерөнхий хэлбэрийг харахад хүний нүд, хамар, амыг дүрсэлсэн, өөрөөр хэлбэл хүний нүүрийг дүрсэлсэн байж болохуйц санагдана.

Дувагийн энэхүү тамга Цагаадайн зүрхэн буюу бундан тамганаас үүсэлтэй нь илэрхий мэдэгдэнэ.

Гэвч Дувагийн өмнөх үеийн Монголын эртний хад чулууны дүрс-тамгадын дотор ийм тамга тааралдаж байна. Тухайлбал: Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын Орон нутгийг судлах музейд хадгалагдаж буй нэгэн чулуун дээрхи түрэг бичээсний талаар эрдэмтэн Л.Болд гуай тодорхой өгүүлэл бичсэн байдаг.[72]

Чулуун дээрх бичээс нь Л.Болд гуайн уншсанаар монголчилбол "Бек (ноён)-дээ (зориулж) бичлээ би" гэсэн утгатай ажээ. "Бек" гэдэг үг нь хан, ноён, ханхүү, эзэн гэх мэт утгатай түрэг үг боловч эртний монгол хэлэнд өргөн хэрэглэгдэж байсан тухай бичгийн баримт олон бий. Ялангуяа хаадын зоосон мөнгөн дээр энэ үг олонтаа үлджээ. Дөргэнэ хатны зоосон дээрхи "Үлүг Монгол Үлүс Бек" гэхээс авахуулаад Науруз бек, Хагаан бек, Шадибек, Жанибек, Тулун Бек, Бирди Бек гэх мэтээр үргэлжилэнэ.

Уг бичээсийн хамт нэгэн сонин тамга байгаа нь төрх байдлын хувьд Дувагийн тамгатай ихэд төстэй юм.

It is difficult to name this tamgha in even in Mongolian. From the general shape of the tamgha, it can be considered that it illustrates an eye, nose, mouth of a human, in other words, a human face.

It is obvious that this tamgha of Duwa is originated from the Chaghatay's "zurkhen" or "bundan" tamgha.

However, this tamgha is also found among the figure tamghas on ancient rocks of Mongolia of pre-Duwa's period. For example, scientist L.Bold wrote an article concerning the Turkish writing on the rocks, which is currently preserved in the National museum of Arvaikheer city of Uvurkhangai province.[72]

According to L.Bold's interpretation, the writing on a rock can be read in Mongolian as "Bek (noyon)-dee (zoriulj) bichlee bi" or the meaning is "I wrote it for my Bek-lord". Although the word "Bek" is a Turkish word meaning khan, lord, prince and owner, there are many written evidences that this word was widely used in ancient Mongol language. Especially, this word is often inscribed on coins of Khans. Starting from the writing "Ulug Mongol Ulus Bek" on the coin of queen Turakina, there are other inscriptions containing this word such as Naurus Bek, Khagan Bek, Shadibek, Janibek, Tulup Bek and Birdi Bek.

Besides this writing, there are also an interesting tamghas, which are very similar to Duwa's tamgha in terms of their image.

[72] Л.Болд. х. 54-83

[72] L.Bold, p. 54-83

Хэн нэгэн ноён хүнд зориулсан бичигтэй энэ чулуу Дуватай огт хамаагүй боловч түүнээс олон зуун жилийн өмнө монгол нутагт байсан овог аймгуудын дотор ийм тамга хэрэглэгдэж байсан гэдгийн нотолгоо гэж үзүүштэй санагдсан тул энэ номондоо зориуд дурдлаа.

Энэ чулууны фото зургийг МУИС-ийн багш Т.Жамъянсүрэн надад найрсагаар өгснийг дор нийтлэв.

Though this rock, with the writing devoted to one of lords, does not have any relation with Duwa, it was purposely mentioned in this book to prove that this tamgha was used by clans and tribes existed on the territory of Mongolia.

The rock photo, cordially given me by T.Jamyansuren, the lecturer of National University of Mongolia, is shown below.

## 1.6 ТУЛУЙН ТАМГА

Чингис хааны дөтгөөр хүү Тулуйн зоосны тухай ямар нэгэн мэдээ баримт өнөө хэр олдоогүй байгаа нь түүний овгийн тамгыг зоосоор судлахад бэрхшээл учруулж байгаа юм. Тулуй эцгийн гэрээс ёсоор Их Монгол улсын хүйс болсон уугуул газар нутгаа өвлөн авч Чингис хаан нас барсны дараах 2 жил шахам хугацаанд (1227-1229 он) Их Төрийн хэргийг түр хамаарч[73] байсан эрдэм чадал төгс, эрэлхэг зоригтой, ухаалаг нэгэн байжээ.

Гэсэн ч тэрээр хэзээ ч Их хаан байсангүй. Иймд тэр ямар нэгэн зоос хийлгээгүй байж болох юм. Тулуйн амьдарч байсан үе нь Монгол хаадын зоос гарч эхэлсэн эхэн үетэй давхцах бөгөөд энэ үед Хорезмд, түүний дотор Бухар, Самарканд, Газни зэрэг хотуудад Чингис хааны зоос гарч байснаас бус бусад Монгол хаадын зоос төдийлөн гараагүй байсан үе юм.

1229 оны намар Тулуй Их хурилдайг даргалан хуралдуулж, Өгэдэйг Их хаан ор суулгасанаас хойш[74] тэрээр өөрийн эрх мэдэлд байсан их цэргээ хаан ахын мэдэлд өгч[75] "...мартсаныг сануулж, унтсаныг сэрүүлж явах үүргээ үнэнчээр биелүүлж Их Хаанд хүчин зүтгэж эцэст нь амиа өргөсөн"[76] гэдэг билээ.

Ийм учраас Тулуй зоос дэлдүүлээгүй гэж ойлгож болно. Гэвч ерөөс монголчуудын зан заншлыг бодсон ч, Тулуйн гурван хүү Монголын Их Гүрний хаан сууж, хүү Хүлүг нь Илхаант улсыг үндэслэсэн дайчин түүхийг үзсэн ч түүний удам угсаанд овгийн тамга байсан гэдэгт эргэлзэх аргагүй юм.

Хэдийгээр Тулуйн тамгатай зоос олдоогүй боловч түүний хөвгүүд Мөнх хаан, Аригбөх хаан болон Хүлүг ханы зоосны тамгаар Тулуйн тамгыг баримжаалах боломжтой санагдана. Тулуй болон түүний хаан хөвгүүдийг тамгадын хооронд ямар нэгэн уялдаа бий гэж үзэж байна.

[73] Монгол улсын түүх. Дэд боть. х.138
[74] Мөн тэнд. х.138
[75] Мөн тэнд. х.144
[76] Монголын нууц товчоо, 272-р бүлэг, х. 186



## 1.6 TULUI'S TAMGHA

The lack of information and evidence concerning coins of Tului, the Genghis Khan's fourth son, creates difficulties to investigate by coins his clan tamgha. By his father's will, Tului, a perfectly educated and capable, brave and intellegent, inherited the core land of Mongol Empire and after death of Genghis Khan, temporarily run [73] the Mongola State affiars for almost (1227-1229).

However, he had never been the Great Khan. Therefore, probably no coins were issued during his reign. Tului's dates of living coincide with the early period of issuance coinage of first coins of Mongol Khans and coins of Genghis Khan appeared in Khwarizm, including Bukhara, Samarqand and Ghazni, while coins of other Mongol Khans had not been struck yet.

In fall 1229 Tului chaired the Great Khurildai during which Ugedei took the reign of Great Khan[74]. Tului placed his own warriors at his brother's disposal [75] and "...faithfully fulfilled his obligations to remind the forgotten and to awake the sleeping, thus served to Great Khan and at the end sacrificed his own life"[76].

It could be understood that for these reasons it Tului did not strick his own coins. However, taking into account the Mongolian tradition as well as the fact that Tului's three sons were Great Khans of Mongol Empire and the valiant history of establishment of the Ilkhanids by his son Hulegu, there is no doubt that Tului had a clan tamgha descended by his offsprings.

Although the coin with Tului's tamgha had never been found it is possible to consider that the Tului's tamgha was somehow similar to tamghas of his sons Munghe Khagan, Ariq Buga Khagan and Hulagu Khan. I assume that there is an interrelation between tqamghas of Tului and his royal sons.

[73] History of Mongolia. Secon d book. p.138
[74] same page p.138
[75] same page p.144
[76] The Secret History of Mongolia. Chapter 272, p.186

## 1.7 МӨНХ ХААНЫ ЗООСОН ДЭЭРХ ТАМГА (649-658 АН/1251-1260 AD)

Тулуйн хоёрдугаар хүү **Мөнх хааны** зоосон дээрхи тамга



The tamgha on the coin of Tului's second son **Munghe Khagan.**

"...Хаан хүний билэг төгс"[77] чанараараа Их хаан болсон Мөнх хааны үед Монгол гүрний дэвсгэр нутаг асар их хэмжээнд хүрчээ.[78] Мөнх хааны үеэс эхлэн зоосон дээр хаадын нэрийг бичдэг болсон бөгөөд МЭГ-ний асар өргөн газар нутгийн хаа сайгүй Мөнх хааны тамгатай зоос гүйж байв.

During the reign of Munghe Khagan, enthroned the Great Khan for his outstanding "personality and qualities of a Khan"[77] the territory of Mongol Empire was extremely expanded.[78] Since Munghe Khagan's reign, the names of Khans were inscribed on coins, and coins of Munghe Khagan were circulated all over the vast territory of Mongol Empire.

Алтан Ордны Булгар хотод цутгасан Мөнх хааны зоос. ***"Аугаа Их Мөнх хаан. Булгарт дэлдүүлэв".*** Зоосны хоёр талд хааны сэрээ тамга байна.

N. 16



The coin of the Great Munghe Khagan was struck in Bulghar of the Golden Horde. "The Great Munghe Khagan. Struck in Bulghar." It has a "seree" tamgha on both sides of the coin.

"Аугаа Их Мөнх хаан. Булгарт дэлдүүлэв"

N. 17



"The Great Munghe Khagan.
Struck in Bulghar".

Гүржид дэлдүүлсэн зоос. ***"Аугаа Их Мөнх хаан"***[79]
Мөнх хааны тамга зоосны хоёр талд байгаа

N. 14

The coin struck in Georgia. "The Great Munghe Khagan".[79]
There is a tamgha of Mungke Khagan on both sides of the coin.

[77] Монголын түүх, II боть, х 174
[78] Монголын түүх, II боть, х 189
[79] Е.А.Пахомов. Монеты Грузии. Тбилиси, 1970, стр. 138

[77] History of Mongolia, Second book, p.174
[78] same page p.189
[79] Pakhomov E.A.Coins of Georgia. Tbilisi. 1970, p.138

*Мөнх хаан ба түүний эхнэрүүд (XIV зууны Перс зургийн цувралаас)*

*Munghe Khagan and his wives (Persian miniature, XIV century)*



*Мөнх хаан ба Хүлүг хаан (XIV зууны Перс зургийн цувралаас)*
*Munghe khagan and Hulagu khagan (Persian miniature, XIV century)*

***"Аугаа Их Мөнх хаан".*** Нүүрэн талд Мөнх хааны тамга ба ар талд зургаан хошуу тамга (Давидын од) дүрсэлжээ[80]



***"The Great Munghe Khagan".*** The coin has the tamgha of Munghe Khagan on obverse and the star of David (tamgha with six-pointed star) on reverse.[80]

**Цагаадайн** хант улсад гаргасан Мөнх хааны тамгатай зоос.

**Chagadayids.** Munghe Khagan's Tamgha

**Цагаадайн** хант улсад гаргасан Мөнх хааны тамгатай зоос. Алмалыкт дэлдүүлжээ. Сэрээ тамганы хэмжээ нилээд том байна.

The coin with Munghe Khagan tamgha, issued in Chaghatayids. Struck in Almaligh. Seree tamgha has quite bid dimensions.

1949 онд Хар Хорумоос олдсон **Мөнх хааны** тамгатай зоос. Муу чанартай фото зургаас зоосны бичээсийг унших боломжгүй тул орхилоо. Харин тамга тод сайн харагдана.

The coin with Munghe Khagan's tamgha was found in Kara Khorum in 1949. Due to the poor quality of the photo, no attempts were made to interpret the writing on the coin. However, the tamgha is clearly seen.

***Дээрх зооснуудаас үзвэл хоёр тийш харсан сэрээ тамга нь Мөнх хааны овгийнх гэдэг нь тодорхой байна.***

Ийм тамгыг монголчууд эрт үеэс хэрэглэж иржээ. Хиад Боржигон овгийхон болох Алтан Ургийнхан сэрээ тамгатай байсан гэж Х.Пэрлээ гуай дүгнэсэн байдаг.[81] Сэцэн хан аймгийн Боржигин сэцэн вангийн хошуунд ийм тамга хэрэглэж байв[82]. Сэрээ тамганы хэд хэдэн янзын хувилбаруудыг Крымын татарууд хэрэглэж байжээ.[83] 1949 онд Хар Хорумын малтлагаас олдсон зоосон дээрхи сэрээ тамга нь бусад газруудаас гарсан Мөнх хааны зоосны тамганаас том, хийц хэлбэрийн хувьд нилээд ялгаатай байна. Хар Хорумоос олдсон зоосны тухай жич өгүүлэх болно.

[80] N_ 15
[81] Х.Пэрлээ, х 258
[82] Х.Пэрлээ, х 209
[83] В.С.Драчук. Системы знаков северного причерноморья, Киев, 1975, таб.XXIV

***It is obvious from the coins above that "seree" tamgha pointed at two different directions belongs to the clan of Munghe Khagan.***

Mongols used this type of tamgha since ancient times. Kh. Perlee[81] concluded that the Golden Hordes, the offsprings of Khiad Borjigon clan had a "seree" tamgha. This tamgha was also used in Borjigon Setsen van khoshun of Setsen Khan province.[82] Qrim tatars used several versions of this tamgha.[83] The "seree" tamgha on coins discovered by diggings of Kara Khorum in 1949 were of a larger size and were considerably different in terms of their design than the coins of Munghe Khagan founds from other places. Coins found from Kara Khorum will be described separately.

[80] N_ 15
[81] Perlee Kh, p.258
[82] Perlee Kh, p.209
[83] Drachuk V. Systems of signs of North Prichernomorya. Kiev. 1975, table XXIV

## 1.8 АРИГБӨХИЙН ЗООСОН ДЭЭРХ ТАМГА (658-662 АН/1260-1264 AD)

***Аригбөх хааны*** тамгатай зоос гурван янз олдоод байна.

Зоос №1[84]
Нүүрэн талд:
*"Их Хаан Аригбөх"*
Ар талд:
*"Булгарт дэлдүүлэв"*
***(тамга)***

Аригбөхийг Их хаан хэмээн өргөмжилж, түүний овгийн тамгыг сийлсэн энэ зоос Алтан Ордны Улсад 1260-1264 оны үед гарчээ.[85] Энэ зоосны тухай Х.М.Френ "Зүчийн улс буюу Алтан ордны зоос" гэдэг номондоо анх бичсэн байдаг.[86] Бат хааны дүү Бэрх Алтан Ордны хаан сууж байх үедээ энэ зоосыг Булгар хотод дэлдүүлжээ. Тэрээр МЭГ-ний их хаан бол Хубилай бус харин Аригбөх мөн гэж үзэж байсан учраас түүнийг хүлээн зөвшөөрч дэмжиж байгаагийн илэрхийлэл болгож түүний нэр алдар, овгийн тамга бүхий энэ зоосыг Алтан Ордод дэлдүүлсэн байна. Энэ зоосыг Булгараас гадна Эмиль хотод мөн цутгаж байсан ажээ. Татарстаны нутгаас нилээд олон тоогоор олдсон, Татарстаны үндэсний музейд 800 ширхэг хадгалагдаж байгаа[87] зэргээс үзэхэд чамгүй олон тоогоор гаргасан бололтой. МЭГ-ний зарим зоосон дээрхи тамгыг чухам хэнийх болохыг нь тогтооход хэцүү байдаг бол Аригбөхийн зоосон дээрхи тамгыг түүний овгийг гэж тогтооход хамгийн хялбар байгаа юм. Зоосны ар талд сийлсэн хоёр үзүүртэй сэрээ маягийн тамга өөр хаана ч, хэзээ ч давтагдаагүйгээс гадна "Их хаан Аригбөх" гэж бичээстэй байгаа нь ийм дүгнэлтэд хүргэж байна. Тамга нь хэлбэрийн хувьд Мөнх хааны сэрээ тамгатай төстэй, түүнээс уламжлан үүсгэсэн шинжтэй байна.

[84] N. 23
[85] А.З.Сингатуллина. Джучидские монеты поволжских народов XIII в. Националный Музей Татарстана. Казань. 2003, стр. 29
[86] Х.М.Френ. "Монетын хановъ улуса Джучиева или Золотой Орды" Санктпетербург, 1832, стр. 2, таб.X (CCCXXXV)
[87] А.З.Сингатуллина, стр. 29

## 1.8 TAMGHAS ON COINS OF ARIQ BUGA (658-662 AH/1260-1264 AD)

Three different types of coins with tamghas of ***Ariq Buga Khagan*** were found.

Obverse: ***Great Khagan Ariq Buga***[84]
Reverse: ***Struck in Bulghar (tamgha)***

This coin bestowing Ariq Buga as a Great Khan and with an inscription of his clan tamgha, was issued in 1260-1264 in Golden Horde.[85] This coin was described for the first time by H.M.Fren in his book "Zuchi's Khaganate or the Coins of Golden Horde".[86] Batu Khan's younger brother Berke struck this coin in Bulghar, when he was ruling the Golden Horde. He considered that Ariq Buga was the Great Khan, but not Khubilai and as an expression of his support to and the acceptance of Ariq Buga he struck this coin in the Golden Horde inscribing his name, fame and his clan tamgha. In addition to Bulghar this coin was also mint in Emil. Considering the fact that many coins were found from the territory of Tatarstan and the National Museum of Tatarstan owns 800 pieces of these coins, it seems that they were issued in great numbers.[87] It is difficult to identify tamghas of Khans of Mongol Empire on some coins, while the tamgha on coins of Ariq Buga could easily be defined. This conclusion is made by the unique "seree" tamgha with two ends on the reverse of the coin and by the writing "the Great Khagan Ariq Buga" inscribed on the coin. The tamgha has a certain similarities with "seree" tamgha of Munghe Khagan in terms of a shape and has characters of origination from Munghe Khagan's tamgha.

[84] N. 23
[85] Singatullina A.Z. Zuchi's coins (Povolj of cities of XIII century) Kazani. 2003, p.29
[86] Fren Kh.M. Zuchi's Khaganat or coins of Golden Horde. Sankt-Peterburg. 1932
[87] Singatullina A.Z. p.29

Зоос №2[88]

Coin No2[88]

Дээрхтэй адил зоос.[89]

Same as above[89]

Аригбөхийн тамгатай хоёр дахь хэлбэрийн энэ зоос Цагаадайн улсад гарчээ. Тамганы үзүүрийг угалзуулан гоёмсог хийсэн харагдана.

The second type of coin with Ariq Buga's tamgha was issued in Chaghatayids. The tip of tamgha is decorated with nicely inscripted pattern.

Зоос №3[90]

Хоёр талдаа ***Аригбөхийн*** овгийн тамгатай энэ зоосыг чухам хаана хийсэн гэдэг нь одоогоор сайн тогтоогдоогүй байна.

Coin No3[90]

The place of mintage of this coin with Ariq Buga's clan tamgha of on both sides has not been identified yet.

Зоос №4[91]

Цагаадайн улсад гарсан энэ зоосон дээр Аригбөхийн нэр болон овгийн тамга байхгүй боловч дэлдүүлсэн цаг хугацааны хувьд түүний хаан сууж байсан үетэй тохирч байгаа тул судлаачид энэ зоосыг Аригбөх хааны зоос гэж тодорхойлсон байгаа юм.

Coin No4[91]

Although this coin does not contain the name and clan tamgha of Ariq Buga, however, the date of coinage coincides with the period of his reign, therefore researchers identified it as a coin of Ariq Buga Khagan.

[88] N. 24
[89] Ц. Батсайхны цуглуулга
[90] К.М.Байпаков, В.Н.Настич, "Клад серебрянных вещей и момент XIIIв из Отрара. (Казахстан в эпохе феодализма). Алма-Ата 1981. стр. 45, рис 12/11
[91] Хароон Тареены цуглуулга (Пакистан)

[88] N. 24
[89] From collection of Ts.Batsaikhan
[90] Baipakov K.M., Nastich V.M. The treasure of silver objects and coins of XIII century from Otrar (Kazakhstan during the period of feudalism) Alma-Ata. 1981
[91] From collection of Haroon Tareen (Pakistan)

Дашрамд тэмдэглэхэд Мөнх хааны гэрээслэлийн дагуу хаан ширээ залгамжлах "хууль ёсны эрхтэй байсан"[92] Чингисийн алтан ураг Аригбөх нь МЭГ-ний хаан суух ухаан төгс, бие бялдар чийрэг, эцэг Тулуйн сургаалийг чанд сахидаг, эрдэм чадлын хувьд хамгийн тохиромжтой нь байсан тул 1260 оны Орхоны Их хурилдайгаар олонхи хан хөвгүүд, угсааны ноёд, нөлөө бүхий сайд, жанжин нар түүнийг дэмжиж Монголын Эзэнт Гүрний тав дахь Их хаанд өргөмжилсөн билээ. Үүнийхээ нотолгоо болгож Алтан Орд, Цагаадайн хаадууд Аригбөхийн овгийн тамгатай зоосыг гаргаж байсан байна. Гэтэл Аригбөх хааныг МЭГ-ний их хаадын тоонд оруулдаггүй нэгэн хачирхалтай зуршил манай түүх бичлэгт байсаар байгааг эргэж хармаар зүйл гэж бодогддогийг энд тэмдэглэн хэлмээр байна.

It should be noted here, that the descendent of the Genghis Khan's Golden Lineage Ariq Buga, entitled to inherit the reign by Munghe Khagan's will, was found to be the most suitable person for the khan's throne by his intelligence and capability, robust health and by a strict adherence to teh teachings of his father Tului[92]. Therefore, the majority of princes, noblemen, influential ministers and generals supported and proclaimed him as the fifth Great Khan at Orkhon Khurildai in 1260. As a notification of this event the Khans of Golden Horde and Chagatayids issued coins with clan tamgha of Ariq Buga. However, it has to be noted specifically that in my point of view an odd practice in our historical documents to exclude Ariq Buga Khagan from the list of Great Khans of Mongol Empire needs a reconsideration.

## 1.9 ИЛХАН ХҮЛҮГИЙН ЗООСНЫ ТАМГА (654-663 AH/1256-1265 AD)

Мөнх хаан "...бодож суугаад Хүлүг ханыг Иран орны баруун мужууд, Сири, Миср (Египет), Рум (багаАзи), Армени тийш мордуулж"[93] улсын хязгаараар байдаг улс орноо захируулахаар зарлиг болов. Тэр зарлиг ёсоор Хүлүг хан 1253-1254 онд баруун тийш аян дайн хийж Перс, Ирак, Азербайджан, Армени, Туркестан, Гүржийн нутаг дэвсгэрийг хамарсан өргөн уудам газартай Илхаант улсыг байгуулжээ.[94]

Хүлүг хан есөн жил хаан суухдаа өөрийн болон Мөнх хааны нэр алдрыг мөнхжүүлсэн зоос гаргасан ба түүний зоосон дээр Тулуйн удамд зонхилсон сэрээ тамга сийлсэн байдаг байв.

## 1.9 TAMGHA COINS OF ILKHAN HULAGU (654-663 AH/1256-1265 AD)

The Munghe Khagan "...thought and sent Hulagu Khan to western provinces of Iran, Syria, Merv (Egypt), Rum (Little Asia) and Armenia"[93] by ordering him to govern the suburbs of the State. According to this decree Hulagu Khan went for the war to the west in 1253-1254 and established the Ilkhanids, which covered the vast territories of Persia, Iraq, Azerbaijan, Armenia, Turkistan and Georgia.[94]

During his reign for nine years Hulagu Khan issued coins immortalizing his own and Munghe Khagan's fame. The coins have inscription of "seree" tamgha, which dominate amongst Tului's descendents.

Нүүрэн талд:
*"Аугаа Их хаан,*
*Мөнх хаан,*
*Хүлүг Илхан"*
(654-663 AH/1256-1265 AD)
A-2122

N. 124

On obverse:
*"The Great Khan, Munghe Khagan, Ilkhan Hulagu"*
(654-663 AH/1256-1265 AD)
A-2122

[92] Монгол улсын түүх. Дэд боть, х 192
[93] Судрын чуулган, III дэвтэр, х 10
[94] Монгол улсын түүх. Дэд боть, х 269

[92] History of Mongolia. Second book, p.192
[93] Rashid Ad Din, p.10
[94] History of Mongolia. Second book, p.269



*Хүлүг Илхан (XIV зууны Перс зургийн цувралаас)*
*Hulagu Ilkhan (Persian miniature, XIV century)*

Хүлүг хааны тамгатай олон зоосыг хооронд нь харьцуулан тамганы байдлыг дор үзүүлэв.

Many coins with Hulagu Khan's tamgha were compared as follows:

"Их хаан,
Хүлүг Илхаан"

"Great Khan,
Hulagu Ilkhan"

"Их хаан,
Хүлүг Илхаан"

"Great Khan
Hulagu Ilkhan"

“Их хаан,
Хүлүг Илхаан”

“Great Khan,
Hulagu Ilkhan”

“Их хаан,
Хүлүг Илхаан”

“Great Khan,
Hulagu Ilkhan”

“Их хаан,
Хүлүг Илхаан”

“Great Khan,
Hulagu Ilkhan”

“Их хаан,
Хүлүг Илхаан”

“Great Khan,
Hulagu Ilkhan”

Эндээс харахад Хүлүг хааны зоосны тамга нь Мөнх, Аригбөх нарын зоосон дээрхитэй адил сэрээ тамга байна.

Тулуйн удмыханд байгаа тамгыг нэгтгэн харвал.

It can be seen that similar to coins of Munghe Khagan and Ariq BugaKhagan, the coins of Hulagu Khan have an inscription of “seree” tamgha.

A combined collection of tamghas belonged to Tului's clan.



*Абага хаан улсын эзэнд өргөмжлөгдсөн нь (Перс зургийн цувралаас)*
*Abaqa Khan enthroned (from Persian miniature)*




*Абага хааны оршуулга (Перс зургийн цувралаас)*
*Abaqa Khan's funeral (from Persian miniature)*

Тулуйн хөвгүүд Мөнх, Аригбөх, Хүлүг хаадын зоосон дээрхи овгийн тамгад сэрээтэй байгаа нь Чингис хааны отгон хүү Тулуйн өөрийнх нь овгийн тамга сэрээтэй байжээ гэсэн таамаглалыг дэвшүүлэх үндэслэл болох юм.

Тулуйд Чингис хаанаас гэрээслэн захисан уугуул Монгол нутагт үеийн үед мандсаар ирсэн Их төрийн есөн хөхөлт цагаан тугны оройд дээш цоролзон заларч байдаг гурван үзүүрт алтан сэрээ Тулуйн тамга биш үү?

Чингис хаан төрсөн өссөн уугуул нутагтаа Их төрийг байгуулж, дэлхийн талыг дөрвөн Их хөвгүүндээ хуваажөгч байхдаа "гурван цагт дайн дайснаа ялах"[95], үеийн үед мандан бадарч байхын билэгдэл болсон гурван үзүүрт сэрээ тамгыг Эх Монгол нутаг, Тулуй хөвгүүндээ оноосон байж магад.

Ямар боловч Тулуй хааны хөвгүүдийн зоосон дээр байгаа биетэй бодитой сэрээ тамгадад тулгуурлан Чингис хааны дөрөвдүгээр хөвгүүн Тулуйн овгийн тамга гурван үзүүрт сэрээ байсан гэдэг таамаглал дэвшүүлж байна.

Монголын эртний аймгуудаас Хиад, Жалайр овгийнхонд сэрээ тамга байв. Мөн Халхын Сэцэн хан аймаг, Түшээт хан аймаг, Сайн ноён хан аймгийн олон хошууд, Заяийн шавь нар, Их хүрээ хавийн халх хошууныхан, барга, дарьганга, өвөрлөгч нарт[96] сэрээ тамга тархмал байжээ.

Хүлүг хаанаас хойшхи илхаадууд зоосон дээрээ ямар нэг овгийн тамга тавиагүй нь бас л тайлбарлаваас зохих асуудал юм. Илхаадын улс оршин тогтносон 100 гаруй (1256-1365) жилийн түүхэнд Тулуйн удмын 17 хаан ээлжлэн төр барьжээ. Гэвч Хүлүгээс бусад хаадууд зоосон дээрээ овог овгийн ямар нэгэн тамга тавиагүй нь сонирхол татна. Үүнийг тайлбарлах тодорхой нөхцөл шалтгаан бий.

Хүлүг хааны хүү Абага хаан ор суусан цагаас эхэлж Илхаант улсын 11 хаан зоосон дээрхи бичээсийг бүхэлд нь, эсвэл хэсэгчилэн монгол хэл, монгол бичгээрээ бичсэн түүхтэй. Энэ нь уг чанартаа тэдний хувьд овгийн тамгаа монгол хэл бичгээрээ орлуулж, монгол угсаа, хэл соёлоо мөнхжүүлэх гэсэн хаадын ухаан байжээ.

[95] С.Дулам. Гутгаар дэвтэр, х. 96
[96] Мөн тэнд



The "seree" tamgha inscribed on coins of Tului's sons Munghe, Ariq Buga and Hulagu can be a basis to offer a hypothesis that Tului, the youngest son of Genghis Khan, had a clan tamgha with "seree".

The triple tip on golden seree (trident) rectified on top of the Great State nine foot white standard, which raised for generations on the core territory of Mongolia and descended to Tului by the will of Genghis Khan. This triple tipped seree could be a Tului's clan tamgha, could not it be?

It is possible that when Genghis Khan was founding the Great State on core territory of his motherland and was dividing the half of the world to his four sons "to conquer the enemies in past, present and future"[95], he allotted to Mongol Motherland and his son Tului a triple tipped "seree" tamgha, the symbol of eternal prosperity and flourishing.

What ever the case on the basis of the existence of "seree" tamgha on coins of Tului Khan's sons, the hypothesis is being developed that the clan tamgha of Tului, the Genghis Khan's fourth son, had a triple tipped "seree" tamgha.

Among the ancient Mongol provinces, Kiad and Jalair clans also had a "seree" tamgha. Moreover, in many khoshuns of Khalkha Setsen Khan province, Tusheet Khan province, Sain Noyon Khan province, Zayaiin Shabi, Khalkha khoshuns near Ikh Khuree as well as Mongol nationalities such as Barga, Dariganga and Inner Mongolians[96] widely used a "seree" tamgha.

It should be explained why Ilkhans, successors of Hulagu Khan, did not inscribe any clan tamgha on their coins. Over 100 years of existence of Ilkhanids (1256-1365), seventeen Khans of Tului's clan ruled the state by turn. However, it attracts attention that no clan tamghas were inscribed on coins of successor Khans, except for Hulagu Khan. There are definite reasons explianing this fact.

Since Abaqa Khan, son of Hulagu Khan, took the reign, eleven Khans of Ilkhanids made full or half inscription of their coins in Mongol language and script. This was the wise vision of Khans to eternalize the Mongol nationality, its language and culture through replacing the clan tamgha with inscriptions in Mongol script.

[95] Dulam S. p. 96
[96] same page

Түүхийн түмэн ээдрээ нугачаан дунд төрөлх нутгаасаа тасран хоцорч, алс тэртээ хүний нутагт харийн шашин шүтлэг, ёс заншилд автан суухдаа МЭГ-ний нэгээхэн хэсгийг захиран суугаа монгол цустай Монголын хаад гэдгээ ямагт санаж зуу гаруй жилийн турш монгол бичгээ төрийн зоосондоо алдаршуулсан нь тэдний аугаа их гавъяа юм.

Иймд Илхаадын зоосон дээрх Монгол бичиг нь тамга лугаа адил болсон түүхийн үнэт нандин дурсгал мөн.



While being cut off and left behind their homelands in crossroads of history, while being overwhelmed by foreign religion and tradition, while ruling a small part of Great Mongol Empire, they had always remembered that they are Mongol Khans with Mongol blood running in the veins and it is their great deed that for more than hundred years the Mongol script was honored to be inscribed on the state coin.

Therefore, the Mongol script inscribed on coins of Ilkhanids is considered as a valuable historical monument, as tamghas.

## 1.10. ӨГЭДЭЙН УЛС БУЮУ ХАЙДУ ХААНЫ ҮЕ

Монголын хаадын зооснууд дотор Өгэдэй, Цагаадайн тамгадыг хослуулан тавьсан зоос нилээд олон байдаг. Энэ талаар зарим зүйлийг тодруулж хэлэх шаардлагатай болов уу.

Хубилай хаан Аригбөхөөс хан ширээ булаан Их Монголын Их хаан болсоныхоо дараа улсын нийслэлийг Бээжин (Ханбалиг)-д төвлөрүүлж улсын нэрийг Юан улс болгож хятад заншлаар он тооллоо эхлүүлэв. Ийнхүү Хятад орноор төвлөсөн Юан улс байгуулсан явдал нийт монголчуудын хүчтэй эсэргүүцэлтэй удаа дараа тулгарч байв. Энэ эсэргүүцэл тэмцлийг Аригбөхийг тууштай дэмжиж, Өгэдэйн удмаас хаан суулгах бодлого баримталсан Хайду ноён[97] (1262-1301) толгойлжээ. Хайду бол Өгэдэйн хөвгүүн Хашийн ганц хүү, Чингис хааны дэргэд өссөн, сэргэлэн ухаалаг хүн байв[98]. Тэрээр 1264-1301 онд Хубилайн эсрэг хатуу ширүүн тэмцэл явуулж Их Монгол улсыг дахин байгуулж, улсын нийслэлийг Бээжингээс буцааж нүүлгэхийг шаардаж байжээ.[99]

Ер нь Аригбөх-Хубилай, Хубилай-Хайду нарын өрсөлдөөн тэмцлийн тухай сурвалж бичгүүдэд дэлгэрэнгүй өгүүлж, Улсын түүх бичлэгт ч тодорхой гардаг билээ. Гэвч Хайду хааны зоосон мөнгө түүний түүхийг өгүүлэх бас нэгэн сурвалж болно.

Хайду өвөг эцэг Өгэдэйд Чингис хаанаас олгосон уугуул нутгийг эзэгнэн сууж 1264 оноос Эмил голын их цэрэг бөөгнүүлж[100], өөрийн улс байгуулан Өгэдэйн улс хэмээн нэрийдэх болов.

1263 онд Алмалыкт (Цагаадайн нийслэл, одооогийн Баруун Шинжаан) Алаг хаан (Alugh) нас барснаас хойш Цагаадайн улсын хаан ширээ эзгүйрч, Хайду тэр нутгийг эзэлж захиран суув. Хубилай Борог (Borak)-ийг Алагийн оронд томилсон хэдий ч Цагаадайн улсын эзэн хэрэг дээрээ Хайду байсан юм.

[97] Монгол улсын түүх. Дэд боть, х.197
[98] С.Товуудорж. Хайду хаан. УБ, 2001, х 11
[99] Монгол улсын түүх. Дэд боть, х.197
[100] Мөн тэнд, х. 201



## 1.10. UGEDEI ULUS OR PERIOD OF QAIDU KHAN

Among the coins of Mongol Khans, there are many of those, which combine the tamghas of Ugedei and Chaghatay. It may be required to give some explanations with this regard.

When Khubilai Khagan by force took the throne over Ariq Buga Khagan, he moved the capital of the Mongol Empire to Beijing (Khanbileg), renamed the country to Yuan Dynasty and commenced a new chronology according to Chinese tradition. The establishment of Yuan Dynasty centralized in China met with a strong resistance of Mongols for several times. This opposition struggle was continuously supported by Ariq Buga and was headed by lord Qaidu[97], who pursued a policy that the descendent of Ugedei Khagan should be enthroned. Qaidu was the only son of Ugedei's son Khash. He was brought up next to Genghis Khan and was a very intelligent person.[98] He has engaged in fierce fight against Khubilai in the course of 1264-1301, requiring the reestablishment of Mongol Empire and moving the capital back from Beijing.[99]

The struggle and competition between Ariq Buga and Khubilai as well as Khubilai and Qaidu are mentioned in detail in many sources and historical documents. Coins of Qaidu Khan are one of the sources that imply his own history.

Qaidu took a reign over a territory inherited by his grandfather Ugedei from Genghis Khan and started to concentrate his soldiers around the Emil river basin since 1264.[100] Then he established his own state and named it Ugedei ulus.

After the death of Alugh Khan in Almaligh (a capital of Chagatayids, present western Xinjiang) in 1263, the Chaghatay's throne became unoccupied and thus Qaidu conquered this territory and ruled it. Though Khubilai appointed Borak to replace Ariq Buga, in reality Qaidu reigned over the Chaghatayids.

[97] History of Mongolia. Second book, p.197
[98] Tovuudorj S. Qaidu khan. Ulaanbaatar, 2001, p. 11
[99] History of Mongolia. Second book, p.197
[100] same page, p.201

Алаг хааны үе буюу 659-664АН/1261-1266[101] онд Цагаадайн улсад гарсан зоос ⊙ тамгатай байсан бол 1266-1301 оны хооронд гарсан зооснууд бүгд Өгэдэйн дэгрээ ʃ тамгатай байгаа нь чухам энэ 30 гаруй жилд энэ нутагт Хайду эзэн сууж байсныг гэрчилнэ.

During the period of Alugh Khan' reign or 659-664 AH/1261-1266[101]coins issued in Chaghatayids had ⊙ tamgha, whereas all coins issued in 1266-1301 have ʃ "degree" tamghas, which is an proof that Qaidu reigned for over 30 years in this territory

Цагаадайн улсын эхэн үед тамгагүй зоос зонхилж байв.
Алмаликт дэлдсэн зоос

N. 48

Coins without tamghas were dominating in the Chagatayids. Struck in Almaligh

Алуг хааны үед Күчад дэлдсэн онгин тамгатай зоос

N. 35

A coin with "ongin" tamgha struck in Kucha during the period of Alugh Khan

Борог хаанаас хойш буюу 1666 -1301 он хүртэл хугацаанд Өгэдэйн ач хүү Хайду Цагаадайн улсыг хэрэг дээрээ захирч байсан тул энэ үеийн зоосон дээр Цагаадайн овгийн тамга үзэгдэхээ больж харин Өгэдэйн овгийн дэгрээ тамгатай зоос гарах болсон юм.

In reality Qaidu, the grandson of Ugedei, ruled Chagatayids since Borog Kha or from 1666 to 1301. Since then the tamgha of Chagatay's clan disappeared from coins, whereas Ugedei's "degree" tamgha started to be inscribed on coin.

Кашкар
**Хайду хааны үе**

N. 40

Kashkar
Temp. **Qaidu Khan**

Бухара
Хайду хааны үе

N. 43

Bukhara
Temp. **Qaidu Khan**

[101] Стефан Албум, х.99

[101] Stephen Album, page 99

Энэ үед Өгэдэйн S дэгрээ тамга нилээд олон хувилбартай байсныг дээр жич дурдсан тул энд давтан оруулсангүй.

Энэ үед Цагаадай, Өгөөдэйн тамгыг янз бүрээр хослуулан тавьсан зоос гарч байсан нь Цагаадай, Өгэдэйн улс хэрэг дээрээ нэг хүний гарт, өөрөөр хэлбэл Хайдугийн зохиргоонд байсныг харуулж байна.

During this period Ugedei's "degree" tamgha had several different versions, as it was mentioned earlier.

Coins with different combination of Chaghaday and Ugedei's tamghas, which were minted during that period, demonstrate that Chaghadayids and Ugedeids are ruled by one person, in other words were governed by Qaidu.

Таразд дэлдүүлжээ

Struck in Taraz

Таразд дэлдүүлжээ

Struck in Taraz

Таразд дэлдүүлжээ

Struck in Taraz

Таразд дэлдүүлжээ

Struck in Taraz

Таразд дэлдүүлжээ

Struck in Taraz

Хайду, түүний удмынхны тамга



Tamgha of Qaidu and his descendents

Хайду, түүний удмынхны тамга

Tamgha of Qaidu and his descendents

Туг төмөр (Tuqa Timur) хааны үе (670-690AH/1272-1291AD) нь мөн Хайдугийн мэдэлд өнгөрсөн тул түүний зоос ч Хайдугийн тамга дор гарчээ.

The period of Tuqa Timur Khan (670-690AH/1272-1291AD) had also passed under the reigns of Qaidu and his coins were also issued with an inscription of Qaidu's tamgha.

Тугтөмөрийн үе

Temp. TuqaTimur

Хайдуг нас барсны дараа (1301) түүний ахмад хүү Чапар эцгийн ор суусан ба өмнөхөөс онц ялгарах тамга энэ үед гарсан талаар нотолгоо баримт одоогоор байхгүй байна. Иймд түүний үеийн зоосыг Хайдугийн тамгатай байсан гэж таамаглаж байна. Харин Чапарын дараа хаан суусан Дува хаан (690-706AH/1291-1306AD)[102] хаанчлалынхаа эхэн үедээ Цагаадай, Өгэдэйн тамга хосолсон зоос гаргаж байгаад Хайдуг нас барснаас хойш Цагаадайн тамга дагнасан зоосыг гаргаж эхэлсэн байна. Ер нь Хайдугийн үеийн зоосны тамга дотроо олон янз байсныг нарийн тайлбарлах боломжгүй юм. Энэ нь зоосыг гаргаж байсан газар газрын ноёд Хайдугийн нэрээр зоос хийхдээ бас өөрсдийн дүрс тэмдэглэгээгээ нэмж, зарим үед зоосны хэв хийж байсан урчууд ч зарим өөрчлөлтүүдийг оруулсан байж болох талтай.

After the death of Qaidu (1301), his eldest son Chapar descended his throne. There is no evidence found that completely different tamghas were issued during the time when Chapar took the reign. Consequently, the hypothesis was made that the Chapar's coins had Qaidu's tamgha. However, Duwa Khan (690-706AH/1291-1306AD)[102], a successor of Chapar, at the beginning of his reign issued coins with combination tamghas of Chaghatay and Ugedei, but after the death of Qaidu he issued coins only with Chaghatay's tamgha. In general, it is impossible to explain in detail the variety of types of tamgha on coins minted during the Qaidu's period. It might have happened that the noblemen while striking the coins on behalf of Qaidu added their own forms and markings, or sometimes craftsmen made some changes while preparing the mold.

[102] Стефан Албум, х.99

[102] Stephen Album. page 99

Ютай ч Алаг хаанаас Дува хааны үе дуусах хүртлэх 40-өөд жилийн хугацааг Хайдугийн үе гэж үзэх бөгөөд энэ хугацаанд Өгэдэйн овгийн дэгрээ тамгатай зоос гарч байсан нь тодорхой. Хайду хэдийгээр хууль ёсны хаан байгаагүй ч МЭГ-ний зоосон мөнгөний түүхэнд том байр эзлэх гавъяатай хүн юм. Хайдугаас хойш Өгэдэйн удмаас ингэж тодорсон хүн бараг гараагүй бөгөөд зоосон дээр ч Өгэдэйн овгийн тамга дахиж үзэгдээгүй бөлгөө.

Nevertheless, the period of 40 years covering reign of Alugh Khan and Duwa Khan is considered as a Qaidu's era, and it is definite that coins with "degree" tamgha of Ugedei's clan were struck during this time. Although Qaidu had never been officially enthroned, he is a prominent figure in the history of coins of Mongol Empire. After Qaidu, there were no prominent personalities among Ugedei's descendents, and the coins with Ugedei's tamgha were not seen again since that time.

## 1.11. МОНГОЛ ХААДЫН ЗООСОН ДЭЭРХ ТОДОРХОЙГҮЙ ТАМГАД

МЭГ-ний зоосон дээр Чингис хаан, түүний дөрвөн хөвгүүд, тэдгээрийн удмын хаадуудын тамга зонхилж байгаа боловч тодруулахад бэрхшээлтэй, цаашид судлаачдаа хүлээж байгаа нилээд олон тамга бий.

## 1.11. UNDETERMINED TAMGHAS ON COINS OF MONGOL KHANS

Though the tamghas of Genghis Khan, his four sons and their descendents prevail on coins of Mongol Empire, there are many coins, which are difficult to interpret and which are awaiting for their researchers.

1. Энэ тамга **Цагаадайн Илжигдэй (Ilchigiday) (727-727AN/1326-1327AD) Дармаширин (Tarmashirin 726-74AN/1326-1333AD)** хаадын зоосон дээр байдаг.



1. This tamgha was found on the coin of **Ilchigiday (727-727AN/1326-1327AD) Tarmashirin 726-74AN/1326-1333AD).**

Илжигдэй хааны үе

N. 57



Temp. Ilchigiday

Дармаширин хааны үе

N. 60



Temp. Tarmashirin

Дармаширин хааны үе

N. 59



Temp. Tarmashirin

Энэ тамгыг салгаж харвал уг тамганы үндэс нь (нар, онги) үзүүрийг нь хумисан сэрээ бололтой.

By the review of separate parts of this tamgha, the consulsion could be made that its basis are the (sun and ongi) and "seree" with folded ends.

2. Энэ тамгыг Давидын од, зургаан хошуут гэх мэт нэрлэдэг. Монголд заяын шавь нарт ийм тамга байжээ.[103]

МЭГ-ний зоосон дээр энэхүү зургаан хошуу нь цөөнгүй тааралдаж байгаа ба ихэвчлэн зоосны чимэглэл байдалтай боловч зарим тохиолдолд яах аргагүй тамга байдалтай байна.

2. This tamgha is called the star of David or the six-pointed star. In Mongolia this tamgha belonged to Zayaiin Shabi[103].

The six-pointed star was inscribed on coins of Mongol Empire and often comes across and is inscribed as a decoration, however, in some cases it is definite that this star was used in a form of a tamgha.

"Их хаан Мөнх"
Гүржид дэлдүүлжээ.



"Great Khan Munghe"
Struck in Georgia

Цагаадайн улс.
**"Мухаммад Султан"**[104]

A-2001. RR

Chaghatayids
Muhammad Sultan

A-2001. RR

Илхант улс.
"Хүлүг Илхан"
Зоосны хүрээг зургаан хошуутаар хийжээ.

Ilkhanids
"Hulagu Ilkhan"
The coin is inscribed with six-pointed star.

Илхант улс.
"Их хаан"
**Абага хааны үе**
Хижрийн 674 он
Тифлист дэлдүүлжээ.
Зоосны хүрээг зургаан хошуутаар хийжээ.

Ilkhanids
type Kaanika
temp. Abaga Khan
674AH Tiflis
The coin is inscribed with six-pointed star.

[103] Х.Пэрлээ. х 221
[104] Стефен Албум. А 2001, х 100

[103] Perlee Kh. p. 221
[104] Stephen Album. A 2001, p. 100

3. Буйван[105] тамгатай зоос. Үүнийг зүрхэн тамга ч гэж нэрлэнэ.[106]

3. "Buiwan' tamgha[105] which is also called the "Zurkhen" tamgha[106]

Алтан ордны улс
Тогтох хаан

Togtogu Khan of the Golden Horde

Цагаадайн улс
Дармаширин

Chaghatayids, Tarmashirin

Цагаадайн улс
Дармаширин

Chaghatayids, Tarmashirin

4. Энэхүү гурвалжин тамгыг монголчууд гурвалжин, дормон, чойнжин[107] гэдэг.

4. The Mongols call triangle-shaped tamgha as a triangle, "dormon" or "choijin" (in Mongolian.) [107]

Цагаадайн улс
Дармаширин

Chaghatayids, Tarmashirin

[105] С.Дулам х109
[106] Д.Чойсамба. х63
[107] С.Дулам . х39-43

[105] Dulam S. p. 109
[106] Choisamba D. p. 63
[107] Dulam S. p. 39-43

**5. Загас хэлбэртэй тамга**



**5. Tamghas with a shape of a fish**

**Алтан Орд**
**Токтамыш хан**

**Togtamish Khan of the Golden Horde**



П.Н.Петров Шиньжанд байхдаа ийм зоос нүдээр үзсэнээ ийнхүү буулгасан байна. Цагаадайн тамганы хоёр талд нэгэн сонин дүрс харагдаж байна.

Тамгадын доод талд Монгол үсгээр ямар нэг үг бичээстэй байх боловч тодорхой унших боломжгүй байв.

P.N. Petrov made a drawing of this coin by recalling the one that he had seen in Xinjiang. An interesting figure is inscribed on both sides of the Chaghatay's Tamgha.

Unknown, unreadable word in Mongolian script is written on lower part of the tamgha.

**6. Өлзий хээтэй тамга**

1221 онд Бухарт гаргасан Чингис хааны зоосон дээр байдаг энэ тамга өөр бусад зоосон дээр ч бас үзэгддэг. Ийм тамгыг хэвтээ таван нүдэн тамга[108] гэнэ. Энэ тамга нь Монголын уламжлалт өлзий хээнээс гаралтай юм байна. Монголчууд өлзийг сайн сайхныг бэлэгдсэн хээ гэдэг боловч МЭГний зарим зоосон дээр хээ гэхээсээ тамга гэмээр харагддаг. Иймд үүнийг хээ юу, тамга уу гэдгийг хараахан тогтоох боломжгүй тул хээ угалз судлаачид, зураач урчууд эрдэмтэд нэгийг хэлэх байх гэж бодно.

Зоосны голд их том өлзий байгаа нь тамга гэмээр харагдана.

**6. Tamghas with "ulzii" pattern**

The tamgha on the coin of Genghis Khan issued in Bukhara in 1221 can be also seen on other coins. This tamgha is called the flat five-eyed tamgha [108]. This tamgha originated from the traditional "ulzii" pattern. Though Mongols regard "ulzii" as a pattern symbolizing prosperity, on some coins of Mongol Empire it can be seen more as a tamgha rather than a pattern. Since it is impossible to determine at this point whether it is a pattern or a tamgha, it is deemed that researchers, painters and historians will comment on this aspect.

Цагаадайн улс Есөн Төмөр хаан.
Алмалик 740 АН

Chaghatayids.
Yesun Timur Khan
Almaligh 740AH

[108] С.Дулам. х 39-44

[108] Dulam S. p. 39-44

Алтан орд
Абд Аллах хаан




The Golden Horde
Abd Allah Khan

Чингис хаан
Бухара 1221 он



Genghis KHan
Bukhara 1221

Илхант улс
Абу Саид хаан
1334 он

Ilkhans
Abu Said KHan
1134

7. Төвд цагаан толгойн "эхийн" Ма (МаМ) үсгэн тамга.[109]

7. The first letter of the Tibetian alphabet "Ma" (MaM) meaning "Mother"

**Цагаадайн хаант улс,**
(Их Ордод дэлдүүлжээ)
Төвдийн Ма тамга голд байна.



The **Chaghatayids** (Struck in Golden Horde), Tibetian "Ma" tamgha in the center.

**Цагаадайн хаант улс,**
(Их Ордод дэлдүүлжээ)
Төвдийн Ма тамга голд байна.

The **Chaghatayids** (Struck in Golden Horde), Tibetian "Ma" tamgha in the center

[109] Д.Чойсамба. х 58

[109] Choisamba D. p.58

Хайдугийн тамга,
Төвдийн Ма үсгэн тамга




**Qaidu**'s tamgha, Tibetian Ma letter tamgha.

8. **Хятадын "Бао" үсгээр хийсэн тамга.** Хятад хэлний "**Бао**" буюу үнэт зүйл, эрдэнэ гэсэн ханз үсгээр хийсэн тамгатай зоос Цагаадайн Улсад гарч байжээ.

8.The tamgha originated from Chinese "**Bao" character.** The Chinese word "Bao" meaning treasure and precious things is inscribed as a tamgha on coins of Chaghatayids.

**Хайду хааны үе**
Зоосны нүүрэн талд "Бао" тамга болон зэрэгцэн харагдана.

**Qaidu Khan**
Obverse: "Bao" tamgha and  can be seen.

**9. Хас тамгатай зоос.**



**9. A coin with Khas tamgha**

**Алтан Орд,**
Гулистанд дэлдүүлжээ

**The Golden Horde.**
Struck in Gulistan.

Цагаадайн улс.
Пулад хотод
хижрийн 660-аад
(1260-аад) онд
дэлдүүлжээ.

Chagatayids.
Struck in Pulad
on 660th (1260th)

**10. Ул мэдэгдэх тамгатай зоос.**

**10. Coin with unknown Tamgha.**

Алтан Орд,
Энэ зоосыг дэлдсэн газар он цаг тодорхойгүй. **Зоосны ар талд Бат хааны тамгатай.**

**Golden Horde**
The date and place the coin was struck is unknown.
Obverse: Batu Khans tamgha

**11. Чандман тамгатай зоос.**



**11. A Coin with a "Chandman" Tamgha.**

**Төмрийн хаант улс.**
Төмөр Хүргэн хааны үед гарсан зоос. Зоосны нүүрэн талд байгаа чандман тамга бол Төмөр хааны өөрийн нь овгийн тамга гэгддэг.



**Timurids.** The coin issued during period of Timur Kuragan Khan.
The "Chandman" tamgha on obverse is the tamgha of Timur Khan.

**Төмөр хааны үе.**



**Timurids.**

## 1.12. ЧИНГИС ХААНЫ ОВОГ УДМЫН ТАМГАД

Бид Чингис хаан, түүний дөрвөн хөвгүүд болох Зүчи, Цагаадай, Өгэдэй, Тулуй нарын тамганы байдлыг тус тусад нь тодруулж үзлээ. Одоо тэр бүгдийг нэгтгэн удам угсаагаар нь жагсааж үзье.

## 1.12. THE TAMGHAS OF GENGHIS KHAN'S CLAN

We separately identified the tamghas of Genghis Khan's four sons Zuchi, Chaghatay, Ugedei and Tului. Thus the following is the compiled set of tamghas according to the lineage of each person.

GENGHIS KHAN
ZUCHI
CHAGHATAY
UGEDEI
TULUI
Zuchi
Batu
Berkhe
Monghe Timur
Toda Mengu
Tole Buga
Togtu
Uzbek
Abd allah
Pulad
Unknown rulers
Ulug Muhammad
Kuchuk Muhammad
Mustafa Khan
Siyad Ahmad
Nogai, Shaibanids, Tatars
Giray Khans
Unknown rulers
Chaghatay
Alugh
Borak
Duwa
Kebek
Jankshi
Yusun Monkhe
Anonimous
Halil Allah
Danishmandi
Tughlug Timur
Unknown rulers
Period of Qaidu Khan
(668-701AH/1269-1302AD)
Borog, - Chaghatay
[Qaidu, Chapar] -Ugedei
Duwa - Chaghgtay
Ali Sultan
Ugedei
Turakina
Guyuk and his descendents
Munghe
Munghe's descendents
Ariq Buga
Hulagu Ilkhan

## 1.13 МОНГОЛ ХААДЫН МУТРЫН ТИЙЗ ДЭЭРХИ ОВГИЙН ТАМГА

МЭГ-ний хаадын зоосон дээр овгийн тамга байдагтай адил тэдний албан бичиг, захидал дээр дарсан мутрын тийз овгийн тамгатай байх ёстой гэж би итгэж явдагийн улмаас энэ талаар нилээд эрэл хийсэн билээ.

Гэтэл саяхан МУИС-ийн залуу багш Т.Жамьянсүрэн үзэж харсан номнууд дотроосоо гурван номыг надад чухалчлан үзүүлсэн нь чухам миний эрж хайж байсан зүйлүүд мөн байв. Энэ нь Бонны их сургуулиас эрхлэн герман хэл дээр гаргадаг "Төв Азийн судлал" (Zentral Asiatishce Studien) сэтгүүлийн №1 (1967), №9 (1975) дахь дугаарууд, мөн манай академич Д.Цэрэнсодном гуай германы эрдэмтэн Манфред Таубетэй хамтран бичсэн "Die Mongolica der Berliner Turfansammlung" номонд нийтлэгдсэн "Турфаны цуглуулга" хэмээн алдаршсан эртний монголын хаадын албан бичиг захидлууд юм. Би Турфанаас олдсон эртний монголын бичгийн дурсгалуудын тухай бусдаас сонсож байснаас биш ийнхүү өөрөө үзэж судлах шаардлагатай тулгарна гэж бодож явсангүй. Турфаны захидлууд дотор миний судлаж буй сэдэв буюу МЭГ-ний хаадын овгийн тамгатай холбоотой зүйл нилээд хэд байгааг дээрх номнуудаас үзэв. Улмаар би академич Д.Цэрэнсодном гуайтай уулзаж түүний үнэт үг зөвлөгөөг сонсож Турфаны цуглуулгын тухай Эрик Хейнишийн бичсэн эх зохиолыг ч олж үзлээ. Монголын хаадын овгийн тамгыг хаадын зоосоор судлахад чиглэсэн миний номын сэдэвтэй хамгийн ойрхон очих эх сурвалжуудын нэг нь хаадын гарын тийз юм. Олон зуун жилийн өмнөх бичгийн дурсгал нэн ховор байдгийн адилаар хаадын гарын тийз бүхий захидал зарлиг зэрэг эх сурвалжийн дурсгалууд ихэд ховор ажээ. Маш цөөн тоогоор олдсон дурсгалуудын нэг нь Турфаны цуглуулгад багтдаг бичгийн дурсгалууд билээ. Үүнээс номныхоо сэдэвт хамаарах зарим хэсгийг судалж үзэхийг оролдлоо.

Үүний тулд юуны өмнө:

1. Германы нэрт эрдэмтэн, монгол судлаач Эрик Хейнишийн "Mongolica der Berliner Turfan- Sammlung" (Eric Haenisch. Mongolische Texte der Berliner Turfan Sammlung in Facsimile, Akademie-Verlag, Berlin, 1959)



## 1.13 THE CLAN'S TAMGHAS ON PERSONAL SEALS OF MONGOL KHANS

Certain studies and researches were undertaken to verify my belief that if the coins of Khans of Mongol Empire are inscribed with their clan tamghas, then similarly, these tamghas should also form a part of their personal seals stamped on official letters and correspondence.

Recently, the young lecturer of the National University of Mongolia T.Jamyansuren shared specifically with three books, where I found documents I was looking for. These are the issues No.1 (1969) and no.9 (1975) of the "Central Asian Studies" journal, issued by the Bonn University in German language and the book "Die Mongolica der Berliner Turfansammlung" written jointly by the academician D.Tserensodnom and the German scientist Manfred Tawbe. These publications are related to official correspondence of ancient Mongol Khans widely known as the famous "Collection of Turfana". Although I have heard a lot about ancient monuments of Mongol script found from Turfana, I never thought that I will encounter a necessity to study this subject myself. According to above articles and book, there are adequate amount of facts relevant to the subject of my interest or to the clan tamghas of Khans of Mongol Empire. Consequently, I met with academician D.Tserensodnom, who gave me his valuable advice, and I studied the script of the publication by Erik Haenisch on Turfana collection. Personal seals of Khans are one of the most contiguous sources related to the aspect of this book on studying the clan tamghas of Mongol Khans by the coins. Similar to the written monuments created many hundreds years ago, the letters and decrees with khans' personal seals are extremely rare. Such rare specimens are the written monuments included in Turfana's collection. Therefore, attempts were made to review the components, which could be relevant to my book.

First of all, I studied the following books:

1. "Mongolica der Berliner turfan –Sammlung" by famous German scientist Mongolist. (Eric Haenisch. Mongolische Texte der Berliner Turfan Sammlung in Fascimile, Academie –Verlag, Berlin, 1959)

2. Монголын эрдэмтэн Д.Цэрэнсодном, германы эрдэмтэн монголч Манфред Таубе нарын "Die Mongolica der Berliner Turfansammlung" (Berliner Turfantexte XVI, Akademie-Verlag, Berlin, 1993)
3. Мөн Германы монголч эрдэмтэн Майкл Вейерсийн "Mongolische Reisebegleitschreiben aus Cagatai" (Zentral Asiatishce Studien seminars für Sprach-und Kultuwissenschaft Zentralasiens Universit·t, Bonn, №1, 1967, pp 246, 249, 251, 260, 261) номуудыг үзсэн юм.

Дээр дурдсан номуудад Цагаадайн удмын Кебек, Есөнтөмөр, Түглүгтөмөр болон бусад хаадын зарлиг, албан захидлуудын зургийг эхээр нь нийтэлсэн байна.

Миний бие захидал, зарлигуудын текст бичилгэ, үг хэллэгийг бус зөвхөн тэдгээрт дарсан мутрын тийз дээрхи овгийн тамганы тухай судалж үзэхийг оролдсоноо хэлэх нь зүйтэй байх. Өөрөөр хэлбэл Кебек, Есөнтөмөр, Түглүгтөмөр хаадын зоосон дээр байдаг овгийн тамга тэдний зарлиг, захидал дээрхи мутрын тийзнээ мөн дүрслэгдсэн байгааг тодруулах зорилготой юм. Чухам юуг үндэслэн энэ захидал хааных, мутрын тийз нь мөн хааных гэж үзэж байгаагаа эхлээд тайлбарлах хэрэгтэй болов уу.

1. Кебек, Есөнтөмөр, Түглүгтөмөр хаадын захидлуудад

***"Kebek üge manu..."***
***"Yesuntemur üge manu..."***
***"Tuγluγtemür üge manu..."***

(Кебек, Есөнтөмөр, Түглүгтөмөр) миний зарлиг, миний хэлэх үг гэж эхэлж байгаа нь уг захидлууд дээрхи хаадын өөрсдийнх нь болохыг гэрчилнэ.

2. Захидлуудын төгсгөлд "...**nistu bicig ögbei**" хэмээсэн байдаг.

Энэхүү "**nistu**" гэдэг үг нь Майкл Вейерсийн тайлбарласнаар "Handzeichen, Chieffre (des Khan)"[1] - (хаан) гарын тэмдэг, мутрын тийз, нууцалсан тэмдэг гэсэн үг бөгөөд "хааны мутрын тийз дарсан захидал" гэсэн утгатай болох ажээ.

Хааны мутрын тийз дарсан тухай мэдэгдсэн энэ захидал "Кебек (Есөнтөмөр, Түглүгтөмөр) миний үг, миний зарлиг..."

2. "Die Mongolica der Berliner Turfansammlung" by Mongolian scientist D.Tserensodnom and German scientist Mongolist Manfred Tawbe (Berliner Turfantexte XVI, Akademie-Verlag, Berlin, 1993)
3. "Mongolische Reisebegleitschreiben aus Cagadai" by German scientist Micheal Weirers (Zentral Asiatische Studien seminars für Sprach-und Kultuwissenschaft Zentralasiens Universitat, Bonn, N.1, 1967, pp.246, 249, 251, 260, 261.

The copies of original letters and decrees of Kebek, Yesuntemur and Tughlugtemur of Chaghatayids were published in above books. It should be noted here that I tried to study clan tamghas stamped on those letters and decrees, rather than to learn their content, writing and wording. In other words, my purpose was to study whether the clan tamghas on coins of Kebek, Yesuntemur and Tughlugtemur Khans are also engraved on personal seals, which are stamped on their letters and decrees. It is necessary to explain the basis on which a certain letter and a personal seal are considered to belong to a particular khan.

1. In the letters of Kebek, Yesuntemur and Tughlugtemur Khans, it is written as follows:

***"Kebek üge manu..."***
***"Yesuntemur üge manu..."***
***"Tuγluγtemür üge manu..."***

Letters start with the phrases "Kebek, Yesuntemur, Tughlugtemur, according my decree and my word", which proves that these letters belong to these Khans.

2. The letters end with words "...**nistu bicig ögbei**".

According to Micheal Weirer's explanation the word "nistu" means "Handzeichen, Chieffre (des Khan) – in German and (Khan) stamp, personal seal and secret stamp in Mongolian and implies the meaning that "the letter has the personal seal of Khan".

Since these letters with stamped personal seals of Khans commence with "Kebek, Yesuntemur, Tughlugtemur, according my

хэмээн эхэлж байгаагаас үзвэл дарсан тийз нь хааных байж бүрэн болохоор байгаа юм.

**3.** Захидал дээр дарсан гарын тамга тийзүүд Цагаадайн улсын Дува хааны (690-706AH/1291-1306AD) овгийн тамгатай байгаа бөгөөд энэ гурван хааны зоосон мөнгөн дээр мөн Дува хааны овгийн тамга сийлээстэй байдаг.

Кебек нь Дува хааны хоёрдугаар хүү, Есөнтөмөр, Түглүгтөмөр нар ач хөвгүүд нь юм. Кебек хаан 1381-1326 онд, Есөнтөмөр 1336-1340 онд, Түглүгтөмөр 1359-1364 онд тус тус Цагаадайн улсын хаан төрийг захирч байсан түүхт хүмүүс юм.

Монголын хаадууд овгийн тамга залгамжлахдаа их төлөв овгийн анхдагч тамган дээр нэмэлт оруулах замаар шинэ тамга үүсгэн авсан байдаг бол Дувагийн удам болох Кебек, Есөнтөмөр, Түглүгтөмөр нар эцэг, өвгөдийн овгийн тамгыг элдэв нэмэлтгүйгээр тэр чигээр нь залгаж авсан нь тэдний зоосон дээрхи тамгадаас харагддаг.

Энэ гурван нөхцлийг нэгтгэж үзээд хаадын захидал дээрхи мутрын тийз нь дээрхи хаадын өөрсдийнх нь тамга мөн гэж дүгнэж болохоор байгаа юм.

word and my decree", there is a high probability that the seal also belonged to Khans.

**3.** The personal tamgha seals stamped on letters belong to clan tamghas of Duwa Khan of Chaghatayids, and the Duwa Khan's tamgha is also engraved on coins of these three Khans.

Kebek is the second son of Duwa Khan, whereas Yesuntemur and Tughlugtemur are grandsons of Duwa Khan. The Chaghatayids were reigned by Kebek from 1381 to1326, by Yesuntemur in 1336-1340 and by Tughlugtemur from 1359 to 1364, who are appreciated as historical personalities.

Typically, Mongol Khans used to make changes in the inherited original tamgha to create their own one, whereas Kebek, Yesuntemur and Tughlugtemur, the descendants of Duwa Khan, had inherited the tamgha of their ancestors without any change and amendments. This fact can also be seen from tamghas on their coins.

By considering these three facts, it can be concluded that the personal seals on letters of Khans are the tamghas of these Khans.

Тодорхой баримтуудыг дор үзнэ үү.

**1. Кебек хаан**

**а.** Кебек хааны захидал дээрхи тийзний тамга (Э.Хейниш В.13, Д.Цэрэнсодном №76)

Kebek ûge manu



Refer to the following facts:

**1. Kebek Khan**

**a.** The tamgha of a seal on the letter of Kebek Khan (E.Haenisch B.13, D.Tserensodnom No.76)

Kebek ûge manu



**б.** Кебек хааны зоосон дээрхи тамга

**b** The tamgha on the coin of Kebek Khan

## 2. Есөнтөмөр хаан

а. Захидал дээрхи тийзний тамга (Э.Хейниш, Д.Цэрэнсодном №71)

## 2. Yesuntemur Khan

a. The tamgha on the seal of letter (E.Haenisch B.2, D.Tserensodnom no.71)




б. Зоосон дээрхи тамга

b. The tamgha on the coin

### 3. Түглүгтөмөр хаан

а. Захидал дээрхи тийзний тамга (Э.Хейниш В.8, Д.Цэрэнсодном №72)




### 3. Tughlugtemur Khan

a. The tamgha of the seal on the letter (E.Haenisch B.8, D.Tserensodnom no.72)




б. Зоосон дээрхи тамга

b. The tamgha on the coin

Дээрх баримтуудаас үзэхэд Кебек, Есөнтөмөр, Түглүгтөмөр нарын захидлын тийзний тамга тэдний зоосны тамгатай яг ижил байгаа нь харагдана.

Хаадын зоосон дээрхи тамга ба захидал дээрхи тийзний тамга нь уг тамга тухайн хааны овгийн тамга мөн гэдгийн харилцан нотолж байгаа сайн баримтууд гэж би үзэж байна.

From above facts, it can be seen that tamghas of seals on letters of Kebek, Yesutemur and Tughlugtemur are exactly the same as tamghas on their coins.

I think that tamghas both on coins of Khans and on letter seals are the sound facts proving that these are the clan tamghas of the Khans.

Зоосон мөнгө ба гарын тийз нь мал ахуй, эд хогшлийн зүйлтэй адилгүй тул ахуйн хэрэглэл, өмч хөрөнгө, малд тавьдаг им тамгатай зүйлрүүлж болохгүй илүү өргөн утга агуулгатай зөвхөн овог удмын гарал үүслийг харуулж буй ихээхэн онцлогтой зүйлүүд юм.

Дашрамд тэмдэглэхэд хаадууд захидлаа өөрсдөө бичдэггүй, харин хэн нэгэн итгэж болох язгууртан ноён юмуу эсвэл гарын бичээч нараараа бичүүлдэг байсан байж болох юм. Ингэж бичсэн захидлын бичээс, тамга тийз ялгаатай байгаа юм. Үүнийг нотлох хэд хэдэн баримтыг авч үзье.

Since coins and personal seals are different from livestock and household utilities and can not be compared to earmarks which are used to mark the property and to stamp the livestock; they are special items that carry wide meaning and present the clan's lineage.

It should be noted that probably letters were written not by Khans themselves, but by the trusted aristocrat or by a clerk (typist). The writing and tamgha seals on such letters are different. The following are the facts to prove this statement.

**Баримт 1.**
(Э.Хейниш В.1, Д.Цэрэнсодном №74)

**Fact 1:**
(E.Haenisch B.1, D.Tserensodnom no.74)




*"Есөнтөмөрийн зарлигаар Timur Сатилмус..."*

Энэ захиаг Есөнтөмөрийн зарлигаар Төмөр Сатилмус гэдэг хүн бичсэн бололтой. Захидлын баруун дээд талд Дувагийн тамгатай том тийз байх ба харин баруун

*"According to Yesumtemur's decree by Timur Satilmus..."*

This letter was probably written by the decree of Yesuntemur by the person Timur Satilmus. On the top right corner of the letter, there is a big seal with Duwa's tamgha and on

доод талд жижиг тийз бүдэг харагдана. Эхний тийз нь Есөнтөмөрийнх, харин хоёр дахь нь уг захидлыг бичсэн хүний тийз бололтой.

**Баримт 2.**
(Э.Хейниш В.014, Д.Цэрэнсодном №73)

the right bottom corner of the letter, there is a blur small seal. The first seal is a seal of Yesuntemur, whereas the second seal could belong to the person who wrote the letter.

**Fact 2:**
(E.Haenisch B.014, D.Tserensodnom no.73)

qan-u 5arliã-i [ya]
Bigtemur ûge manu…

qan-u 5arliã-i [ya]
Bigtemur ûge manu…



"Хааны зарлигаар Бигтөмөр үгэ мину..."

Энэ захидлыг хэн нэгэн хааны зарлигаар Бигтөмөр хэмээх хүн бичжээ. Энэ хүний тамга мөн Дувагийн овгийн тамгатай байхыг үзвэл тэрээр хааны ойрын томоохон язгуртан байсан бололтой.

"According to Khan's decree Bigtimur my word…"

This letter was written by a person Bigtimur by the decree of a Khan. Since this person had the Duwa's clan tamgha, he could be the aristocrat close to Khan's family.

**Баримт 3.**

"Төв Азийн судлал" сэтгүүлийн №9 (1975)-д[1] хэд хэдэн сонин баримт бий.

Илхаант улсын Абага, Аргун, Хасан, Өлзийт, Абусаид хаадын зарлигийг тэдний бичээч бололтой хүмүүс бичиж мутрын тамгаа дарцгаасан байна.

**Fact 3:**

There are a few interesting facts in the journal "Central Asian Studies", issue No.9 (1975).

The decrees of Abaqa, Argun, Ghazan, Ulziit and Abusaid Khans of Ilkhanids were written by others, most likely by their clerks, who stamped their personal seals.

**1. Аргун хааны захианы тийзний дардас**
(Weiers, Michael. A3-3, p.246) Чопан гэдэг хүний тамга (1287 он)

**1. The seals of Argun Khans letter**
(Weiers, Michael. A3-3, p.246) The tamgha of a person who is called Chopan (1287).



**2. Хасан хааны захианы төгсгөл дахь гарын үсэг "Taiqu"**
(Weiers, Michael. A4, p.249)

**2. The signature at the end Ghazan Khan's letter**
(Weiers, Michael. A4, p.249)

**3. Өлзийт хааны захианы төгсгөл дахь бичээч Ринчингийн гарын тийз**
(Weiers, Michael. A7, p.251)

**3. The personal seal of clerk Rinchin is stamped at the end of Ulziit Khan's letter**
(Weiers, Michael. A7, p.251)

Ринчину Гэрэгэ бэлгэ — Rinchino Gerege Belge

## 4. Абусаид хааны захидлын төгсгөл дахь бичээчийн гарын тийзний дардас
(Weiers, Michael. B3, p.281)

"Чопан" нэртэй энэ хүний тамга 1287 онд бичсэн Аргуны захидлын төгсгөлд бас байдаг. Иймээс энэ хүн 1287-1330-аад онд Илхант улсад хааны дэргэд алба хааж байсан байж болзошгүй гэж Вейерс бичсэн байдаг. Хамгийн сонирхолтой нь Чопаны тийзэн дээр чандмань тамга байдаг бөгөөд энэ тамга бүр хожим Төмөрийн хаант улсын (771-873AH/1370-1506AD) хаадын зоосон дээр гарч иржээ. Үүнээс үзэхэд энэхүү Чопан нь сурвалжит язгууртай, төрийн зүтгэлтэн хүн байсан бололтой.

## 4. The personal seal of the clerk at the end of Abusaid Khan's letter
(Weiers, Michael. B3, p.281)

The tamgha of a person named "Chopan" is stamped at the end of the letter of Arghun Khan written in 1287. M.Weiers wrote that it could be possible that he served a high-ranking position next to the Khan of Ilkhanids during 1287-1330. The most interesting point is that there was a "chandman" tamgha on his seal, which appeared later during the period of Timurid on coins of Khans. Consequently, Chopan was, probably, a person of a noble descent and an educated civil servant.

Эдгээр захидлууд дээрхи тийзнууд нь "Чопа", "Тайку Бэлгэ", "Күтлүг Са-ит Бэлгэ", "Иринчинну Гэрэгэ Бэлгэ" гэх мэт бичээч нарын бололтой үгтэй байгаа юм.

Энэ бүгдээс үзвэл МЭГ-ний хаадын гарын тийз их хаадын угсаа овгийн тамгатай байсан нь тодорхой байна.

Эцэст нь тэмдэглэхэд энэ асуудлыг судлахад туслалцаа үзүүлсэн академич Д.Цэрэнсодном, ШУА-ийн ажилтан Р.Отгонбаатар, МУИС-ийн багш Т.Жамъянсүрэн, герман хэлнээс хөрвүүлсэн Боожоо Лакшми нарт их баярлалаа.

**Жич:** Турфаны цуглуулга дотор Цагаадайн удмынхны овгийн тамгатай олон тийзний зураг байгааг дор үзүүлэв.

The seals stamped on above letters contain words "Chopa", "Taiku Belge", "Khutlug Ca-it Belge" and "Irinchinnu Gerege Belge", which probably belong to these clerks.

From above it is definite that personal seals of Khans of Mongol Empire carried the clan tamghas of Great Khans.

Finally, I would like to extend my sincerely gratitude to academician D.Tserensodnom, research scientist of Academy of Science P.Otgonbayar and lecturer of the National University of Mongolia T.Jamyansuren and to Boojoo Lakshmi, who assisted with translations from German, for their help in studying this subject.

**Note:** There are many seals with tamghas of Chaghatay's descendents in Turfan's collections. The following are their picture:

## 1.14 МОНГОЛ ХААДЫН ЗООСОН ДЭЭРХ ДҮРС ЗУРГУУД

XIII-XIV зууны Монгол хаадын зоосон дээр төрөл бүрийн дүрс элбэг тохиолдоно. Үүнд хээ угалз, нар сар, амьтан, хүн малын дүрс зонхилох ба ялангуяа Алтан Ордны зооснууд дээр ийм дүрс хамгийн олон байна. Үүнийг өөрийн цуглуулга болон бусад судлаачдын номноос авсныгаа заримыг нь төрөл-жүүлж үзүүлье.

## 1.14 SHAPES AND FIGURES ON COINS OF MONGOL KHANS

In the XIII-XIV century there were many different shapes and figure inscribed on coins of Mongol Khans. The patterns, shapes of sun, moon, animals and human beings prevail among them, and especially the coins of the Golden Horde had many of these figures. The following coins from my own collection and from books of other researchers are combined into groups for review.

**Алтан Орд. Тогтох хаан.** Цэцгэн хээ

N. 93

The **Golden Horde. Togtogu Khan.** Flower pattern

**Алтан Орд. Тогтох хаан.** Араб дахины зоосон дээр Нарыг хүний нүүртэйгээр дүрсэлдэг уламжлалтай байсан нь Монголчуудын зоосон дээр ч тусгалаа олсон байдаг.

N. 91

**Togtogu Khan**
Face of Sun
In Arab world, there was a tradition to draw a sun with a face of human, which reflected on coins of Mongols.

**Тогтох хааны үе.** Нар, Сар, Од

N. 92

**Togtogu Khan**
Sun, Moon, Star

Алтан Орд. **Жанибек хан** Нар, Арслан

N. 104

Janibek.
Lion, sun

**Алтан Орд.**
**Жанибек хан**
Цэцгэн хээтэй зоос.

N. 106

**The Golden Horde.** The coin with a pattern of a flower. Janibek Khan

**Алтан Орд.**
**Жанибек хан**
Цэцгэн хээтэй зоос.

N. 105

**The Golden Horde.**
The coin with a pattern of a flower. Janibek Khan

**Илхаант улс.**
**Аргун хаан**
Нарны наагуур нисэж буй
Шонхор шувуу

N. 143

**Ilkhanids**
Arghun Khan
Sun and Hawk

**Илхаант улс.**
**Аргун хаан**
Арслан

N. 142

**Ilkhanids**
Arghun.
**Lion**

**Илхаант улс.**
**Аргун хаан**
Үл мэдэгдэх амьтны дүрс

petrov_tab16_D61

**Ilkhanids**
Arghun Khan
Unknown animal

**Илхаант улс.**
**Аргун хаан**
Үхэр

petrov_tab26_D55

**Ilkhanids**
**Arghun**
Cow

**Илхаант улс.**
**Аргун хаан**
Туулай

petrov_tab19_D52

**Ilkhanids**
Arghun Khan
Rabbit

**Илхаант улс.**
**Аргун хаан**
Шонхор


petrov_tab13_D133

**Ilkhanids**
Arghun Khan
Hawk

**Илхаант улс.**
**Аргун хаан**
Хоёр арслан


petrov_tab26_D66

**Ilkhanids**
**Arghun Khan**
Two fighting lions

**Илхаант улс.**
"Их хаан Абага"
Зоосны ар талд эртний Оросын сүлд болох хоёр толгойтой бүргэд харагдана.

N. 131

**Ilkhanids**
"Great Khan Abaqa"
The ancient symbol of Russia, the double headed Eagle, is on reverse.

**Илхаант улс.**
"Абу Саид хаан"
Ар талд: Хоёр толгойтой бүргэд

z. 5494

**Ilkhanids**
Abu Said Khan
On reverse: Double headed Eagle

**Илхаант улс.**
"Газан хаан"
Нар дүрсэлсэн.

N. 172

**Ilkhanids**
"Ghazan Khan"
Sun

**Илхаант улс.**
Зоосны нүүрэн талд "Абу Саид" гэж хааны нэрийг Монгол бичгээр бичсэн ба зоосны ар талд гүйж яваа гөрөөс дүрсэлжээ.

N. 199

**Ilkhanids.**
The name of khan "Abu Said" is written in Mongol script on observe, an Antilope is engraved on reverse.

**Илхаант улс.**
Абу Саид хааны зоос.
Нар ба амьтны дүрстэй зэс зоос.

N. 200

**Ilkhanids**
Abu Said
Sun & Animal

**Илхаант улс.**
Ринчиндорж (Гайхат) хааны зоос.
Хааны нэр алдрыг Монгол ба Араб бичгээр бичиж арслангийн дүрс сийлжээ.

N. 728

**Ilkhanids.**
The coin of Gaykhatu Khan.
The fame and name of a Khan is inscribed in Mongol and Arabic script with a lion figure engraved.

**Алтан орд.**
**Ногай** ноёны хүү **Чакагийн** дэлдүүлсэн зоос.
Нүүрэн талдаа морьтой хүн дүрсэлсэн, ар талд нь сэрээ тамга ба Грек бичээстэй.

z. 3352

**Golden Horde**
Coin of Chaka, son of Nogai.
On obverse: Rider on horse.
Reverse: Greece legend & Trident tamgha.

**Юан улсын Да Юан Тонг Бао** зоосны ар талд сонгодог монгол бичгээр "Мөнх Тэнгэр" гэж бичжээ. Энэ зоосыг Дорноговь аймгийн Сүмбэр сумын нутгаас олсон бөгөөд одоо Ц.Батсайханы хувийн цуглуулгад бий.



The words "Eternal Sky" are written in the classical Mongolian scripts on reverse side of the Da Yuan Tong Bao of Yuan Dynasty. This coin was found on the territory of Sumber soum, Dornogobi province and at present is being preserved in Mr. Batsaikhan's private collection.

Нүүрэн тал: **Да Юан Тонг Бао**
Ар талд: Дөрвөн мэлхий дүрсэлсэн нь Их Юан улс дөрвөн зүг найман зовхист тэлнэ гэсэн утгыг билгэдсэн зоос бололтой.
Ц.Батсайханы хувийн цуглуулга.

Four fogs set sights on four parts of the world are depicted on the reverse of Da Yuan Tong Bao coin.
Ts.Batsaikhan's collection

*Тулалдаан. (XIV зууны Перс зургийн цувралаас)*
*Mounted Duel. (Persian miniature, XIV century)*

## 2. ХААДЫН ЗООСОН ДЭЭРХ МОНГОЛ БИЧЭЭС НЬ ЭРТНИЙ ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛ БОЛОХ НЬ

Доктор Ц.Шагдарсүрэн гуай "Монголчуудын үсэг бичгийн товчоон" номондоо монгол бичгийн бичилгэ, зурам хэлбэр дүрсийг шинэчлэн үзээд монгол бичгийг бичих байдлын хувьд:

1. Дундад эртний үеийн бичилгэ;
2. Шинэ үеийн бичилгэ

гэж хувааж болно[110] гээд олон баримт жишээ татжээ. Үнэхээр XVI-XVII зуунаас өмнөх үеийн монгол бичгийн дурсгалууд дээрхи бичилгэ нь түүнээс хожуу үеийнхээсээ өвөрмөц ялгаатай болох нь илэрхий юм байна. Үүнийг дурьдахын учир XIII-XIV зууны МЭГ-ний хаадын зоосон дээрхи монгол бичээсүүд нь доктор Ц.Шагдарсүрэн гуайн үечлэлийн эхний хэсэгт буюу "Дундад эртний үеийн бичилгэ"-д хамааралтай байгааг ажигласнаа бага сага тодруулах гэснийх билээ.

Монгол бичиг эртний согд, Уйгур нарын бичгээс эхтэй. "Чингис хаан ... Уйгур нарыг их цэргийн хүчээр дагуулж ... тэднээс бичиг үсгийг авсан бөгөөд тэр бичгийг Монгол бичиг хэмээмүй"[111] гэж XIII зууны Монголчуудын амьдрал байдлын талаар Плано Рубрук өөрийн тэмдэглэлдээ бичсэн нь монгол бичгийн талаарх анхны сурвалжуудын нэг юм. МЭГ байгуулагдсан цагаас хойш монгол бичгийн олон арван гайхамшигт дурсгалууд монголын соёлын түүхнээ тодорсныг энд бүгдийг нь дурдахын аргагүй юм. Харин МЭГ-ний хаадын зоосон дээр мөнхөрсөн монгол бичиг, монгол хэл, бичээсийн тухай товч өгүүлэхийг зорилоо.

Манай хэл соёлын чухал дурсгалуудын дотроос XIII-XIV зууны Монголын Эзэнт Гүрний хаадын зоос, тэр тусмаа монгол бичээстэй зооснууд нь нүдээр үзэж, гараар барьж болох биетэй, бодитой эд өлгийн зүйлсийн нэг яах аргагүй мөн юм. Чингис хаан Их Монгол улсыг байгуулж монгол бичгийг Их Төрийн бичиг болгосноос хойш МЭГ-нийг бүрдүүлж байсан Алтан Ордны улс, Цагаадайн хаант улс, Илхаант улс болон МЭГ-нд дагаар орсон зарим улсуудад монгол бичээстэй зоос үйлдэн гаргаж байсныг дор тус тусад нь дэлгэрүүлэн үзүүлэв.

[110] Ц.Шагдарсүрэн. ... УБ. 2001. х.29

[111] Жиованни Даль, Плано Рубрук "Монголчуудын түүх". УБ, 1988. х.28

## 2. THE MONGOL WRITINGS ON COINS OF KHANS ARE MONUMENTS OF ANCIENT HISTORY AND CULTURE

Dr. Ts. Shagdarsuren in his book "Studies of script of Mongols" reviewed the Mongol script and its forms and implied that it could be divided into the following two different types[110]:

1. The script of ancient and medieval period;
2. New script.

Moreover, he brought up many examples. It is clear that the Mongol script used before XVI-XVII century had specific distinctions compared to the latest period. The reason of mentioning is to clarify that, as it was observed, the Mongol writings on coins of Khans of Mongol Empire relate to the first period of chronology of Mongol writing developed by Dr. Ts Shagdarsurenor or to "Ancient and Medieval Script".

The Mongol script is originated from ancient Soghdian and Uighur scripts. According to notes of Plano Rubruck on the livelihood of Mongols in the XIII century, "Genghis Khan ... conquered Uighurs with a force of soldiers and ... took their script and decreed to name it as a Mongol script"[111]. Plano Rubruck's notes on living of Mongols are one of the first historical sources concerning Mongol script. Since the establishment of Mongol Empire many significant monuments of Mongol script have been identified and it is impossible to mention here all of them. However, I tried to state in brief about Mongol script, Mongol language and writings perpetuated on coins of Khans of Mongol Empire.

Among various monuments of Mongolian language and culture, the coins of Khans of Mongol Empire of XIII-XIV century, especially those with Mongol writings, are the real and physical monuments, which can be touched and seen. Since the establishment of Mongol Empire by Genghis Khan and proclamation of Mongol script as a state script, the coins with Mongol script were issued in different states of Mongol Empire including the Golden Horde, Chaghatayids, Ilkhans and in other surrendered states. These coins will be shown separately.

[110] Shagdarsuren Ts. p.29

[111] Giovanni da Pian del Carpini, The history of Mongols. Ulaanbaatar. 1988

## 2.1 МОНГОЛЫН ИХ ХААДЫН ЗООС

Их хаадын үед Монгол бичиг Төрийн бичиг болон хэрэглэгдэж байсан хэдий ч худалдаа арилжаа, мөнгөний эргэлтэд ашиг тустай байлгах үүднээс, мөн эзлэгдсэн газар нутгуудын уламжлалт зан заншил, хэл соёл, шашин шүтлэгт нийцүүлж араб, перс зэрэг бичээстэй зоос гаргаж байв. Ер нь Чингис, Өгэдэй, Гүюг, Мөнх, Аригбөх хаадын үед буюу 1206-1264 онуудад гарсан монгол бичээстэй зоос өнөө хэр олдоогүй буюу мэдэгдэхгүй байна. Гэвч Өгэйдэй, Гүюг, Мөнх хаадын орд байрлаж байсан Хар Хорум хот нь улсын нийслэл төдийгүй тэр үеийн Монголын бичиг соёл, худалдаа арилжаа, үйлдвэрлэлийн томоохон төв нь байсан. Иймээс ч Хар Хорумд энэ үед зоос гарсан бол чухамхүү монгол бичээстэй гарсан байх магадлал өндөр байна.

1948 онд С.В.Киселевийн удирдсан экспедицийн хийсэн Хар Хорумын туурийн малтлагаас олдсон хоёр зоос[119] араб бичээстэй байсан боловч энэ нь монгол бичээстэй зоос гараагүй гэх баталгаа биш юм. Хар Хорумд цаашид хийх түүх, археологийн судалгаанаас энэ асуудал тодорч болзошгүй юм.

Чингис хаан Хорезмыг эзлэх үеэр буюу 1219-1221 оны үед Бухар, Самарканд, Отрар, Газна хотын зоосны урчуудаар Их хааны алдар, нэр, овгийн тамгатай зоосыг араб бичээстэй хийлгэж байв. Энэ үеэс эхлэн монгол хэлний Хагаан (Khagaan) гэдэг үг араб хэлэнд хэрэглэгдэх болж, зоосонд дээр ч бичигдэх болсон юм. Гэвч энэ үгийг зөвхөн арабаар бичдэг байлаа.

Араб хэл дээр гарсан монголын хаадын зоосыг ажиглавал, "хаан" гэдэг үгийг бичихдээ хаадын зэрэг зиндаанд тааруулан өөр өөрөөр бичдэг байжээ. Тухайлбал, "хагаан" гэдэг нь зөвхөн Их хаадыг нэрлэсэн хэрэг юм.



## 2.1 THE COINS OF GREAT MONGOL KHANS

Although Mongol script was used as an official script during the period of Great Khans, the coins were issued with Arab and Persian inscriptions in order to promote trade, commerce and money circulation as well as to bring into confirmity the tradition, culture and religion of conquered nations. However, coins with Mongol inscription issued during the Genghis Khan, Ugedei Khagan, Guyuk Khagan, Munghe Khagan, Ariq Buga Khagan in 1206-1264 have not yet been found.

The Kara Khorum city where Ugedei, Guyuk and Munghe Khagans had established their capitals was not only just a capital city, but also it was a large center of the Mongol language, culture, trade and manufacturing of that time. Thus, if coins were struck during this period, there is a high probability that these coins had a Mongol inscription.

Although two coins, found by the diggings of Kara Khorum city during the expedition led by S.B. Kiselyov in 1948,[113] had Arab inscriptions, there is no evidence that no coins were issued with with the Mongol writing.

When Genghis Khan conquered Khwarizm in 1219-1221, the coins of the Great Khan with name, fame and clan tamgha were struck in Arabic script by craftsmen of Bukhara, Samarqand, Otrar and Ghazni. Since then the Mongol word "Khagan" was introduced into Arabic language and started to be inscribed on coins. However, this word was written only in Arabic.

By examining the coins of Mongol Khans with Arabic inscriptions, the word "Khagan" was written differently in accordance with the title and ranking of Khans. For example, the word "Khagan" in Arabic was related only to Great Khans.

**Чингис хаан**ы үед гарсан зэс зоос.
Нүүрэн талд: Хагаан
Ар талд: Аугаа Их

N. 4

temp. **Genghis Khan**.
AE fals.
Obv: Khagan
Rev: Great

◀ "Чингисийн чулууны бичиг"
Stone writings of Genghis Khan

▶ Мөнх хааны гэрэлт хөшөө
Monghe Khagan's monument

Түүнчилэн "khaan" эсвэл "qa-an" гэдэг үгийг Их хаадаас бусад хаадын зоосон дээр бичдэг байсан бол "khan" гэдгээр хан хөвгүүд, бага хаадыг хэлдэг байжээ.

Гэхдээ их хаадын нэрийг зоосон дээр бичихдээ "khagaan" бус харин "khan" гэдэг үгийг дагуулсан тохиолдлууд гарч байсан, тухайлбал Чингис хааны нэрийг "Chingiz khan" гэж бичсэн зоос байдаг.

## 2.2 АЛТАН ОРДНЫ УЛСАД

Монгол хаадын зоос 1236 оны орчмоос Алтан Ордны Улсад гарч эхэлсэн боловч монгол бичээстэй зоос нилээд хожуу гарч ирсэн байна.

### 1. "Сайн хаан" (Бат хаан) зоос. (1208-1256)

Бат хааныг "Сайн хаан" гэдэг байсан тухай Рашид Ад Дин тэмдэглэсэн байдаг. Тэрээр "Судрын Чуулган" -д бичихдээ "Зүч хааны хоёр дугаар хөвгүүн Бат. ...Түүнийг Сайн хан гэж нэрлэсэн... Тэрбээр Чингис хааны бүх ач нарынх нь ахмад болж, аугаа их нэр төр өргөгдөн дээдлэгдэж байлаа"[112] гэжээ.

Мөн " **... монголчууд түүнийг Сайн хан, сайн эзэн гэдэг байсан**"[113] тухай Английн судлаач Ж.Э. Бойл бичсэн байна.

www.zeno.ru вэбсайт дээр Бат хааны алдар цол, тамга бүхий нэгэн ховор зоос байхыг би олж үзсэн юм. Харин уг зоосын талаар ямар нэгэн тайлбар хийгдээгүй байв.

z. 8456

**Нүүрэн талд:** Зооснь төв дунд жижиг дугуй дотор нэгэн үл мэдэгдэх дүрс байна. Энэ нь ямар нэгэн тамга байж болзошгүй. Үүний зүүн талд монгол бичгээр "Сайн" гэж бичсэн нь маш тодорхой харагдана. Харин баруун талд монгол бичгийн ором харагдах бөгөөд сайтар ажиглавал Хаан гэдэг үг байж болзошгүй санагдана. Тэгвэл "Сайн хаан" гэдэг үг байж болох юм.

[112] Судрын Чуулган II боть 79-р тал

Moreover, the word "khaan" or "qa-an" was usually written on coins of other than Great Khans and the word "khan" was used for princes and smaller khans.

But in some cases the names of Great Khans on coins were written with "khan" instead of "khagaan", for example on the coins of Genghis the word was used as "Chingiz Khan".

## 2.2 IN THE GOLDEN HORDE

Although the coins of Mongol Khans appeared in Golden Horde approximately in 1236, the coins with Mongol inscriptions appeared much later.

### 1. Batu Khan's coin (1208-1256)

Rashid ad Din refers to Batu Khan as a "Good Khan". He mentioned about it in the Assembly of Sutras:"... He was called as Good Khan. He was born as an eldest grandson of Genghiz Khan and was honored and respected as Great."[112]

British researcher J.E.Boyle wrote that Mongols called him as a **Good Khan and Good Lord**[113].

I found a very rare coin with Batu Khan's name and tamgha from a web-site. However, there was no explanation to this coin.

**On obverse:** there is an obscure figure in the small circle in the middle of the coin. The figure could also be some kind of tamgha. On the left of the circle, the word "Good" is clearly seen, which is written in Mongol script. On the right of the circle, there is a trace, perhaps of an inscription in Mongol script, which is very difficult to read. If we examine an inscription carefully, it could be the word "Khan". These two words could be read together as "Good Khan".

**On reverse:** in the middle of the coin there

[112] Rashid ad Din. p. 79

**Ар талд:** Төв дунд толгойг нь нийлүүлэн тавьсан хоёр тамга байгаа нь Батын овгийн тамга юм. Тамганы хоёр талд Монгол бичигтэй байх боловч уншигдахгүй байлаа.

Зоосны байдлыг бүхэлд нь авч үзвэл "Сайн хаан" гэсэн Монгол бичигтэй, мөн Бат хааны хоёр тамгатай энэ зоосыг "Сайн хаан Батын" зоос гэдгийг таамаглахад төвөгтэй бус санагдана.Энэ зоосны талаар өөр ямар нэгэн мэдээлэл олдсонгүй. Мөн урд өмнө үзэгдэж байгаагүйг бодоход ихэд ховор зоос бололтой. Чухам яг Бат хааны үед гарсан гэх зоос тодорхой мэдэгдээгүй бөгөөд түүний амьд сэрүүн үед Булгарт гаргасан зооснуудыг Батын үеийнх гэж ангилдаг. Гэвч "Сайн хаан" гэсэн монгол бичигтэй Батын овгийн тамгатай энэ зоосыг түүний зоос гэж үзэх нь зүйтэй юм.

are two tamghas joined together with their top part, which are the clan tamghas of Batu Khan. On both sides of tamghas, there are inscriptions in Mongol script but they are unreadable.

By examining the overall condition of the coin, it can be easily assumed that it could be a coin of "Good Khan Batu" as it has an inscription "Good (Khan)" in Mongol script and two tamghas of Batu. No other information was found regarding this coin. Since the coin was never seen earlier, it is probably a very rare one. There are no coins, which were definitely issued during the period of Batu Khan, even though the coins struck in Bulghar, when Batu Khan was still in good health, are classified as coins of Batu Khan's period. Therefore, this coin with an inscription "Good Khan" in Mongol script and clan tamgha of Batu should be considered as a coin of Batu's period.

**2. 1280-аад онд гарсан зоос.** Нүүр талд: Бат хааны тамга байна. Хийсэн газар, он цагийг заагаагүй, гэвч хийц нь Булгарынх байгаа юм.

S. 133, 134

**2. A coin issued in 1280.** On obverse: This is the tamgha of Batu Khan. Place and date of struck are not indicated, however its design is of Bulghar.

Ар талд: "Хутлуг Булсун" (өлзий хутуг орштугай) Хутлуг гэдэг нь хутаг гэсэн түрэг үг бөгөөд Монгол бичгээр бичжээ.

On reverse: "Khutlug Bulsun"(Let the bliss be). Khutug means bliss in ancient Turkish and Uighur languages. The Turkish word was written in Uighur script.

**3. Бат хааны овгийн тамгатай зоос.** Ар талд монгол бичээстэй. Хийсэн газар: он цагийг заагаагүй.

Нэгэнт Бат хааны тамга байгаа болохоор Монгол хааны зоос гэдэг нь тодорхой. Энэ зоос Алтан Ордын ердийн нэр хаяггүй зоосны нэг боловч уйгаржин монгол үсэгтэй зоос Алтан Ордод гарсан анхны баримт болж байгаагаараа онцлог юм.


z. 6956

**3. The Coin with Batu Khan's tamgha.** On reverse: Mongol words. Since there is a tamgha of Batu Khan on the coin, it is definitely a coin of Mongol Khans. Though the coin is one of those common for Golden Horde to be without specific writings, this is one of the first facts that coin with Uighur Mongol script was struck in Golden Horde.

[113] Тюркологический сборник-2001. Ж.Э.Бойл. Посмертный титул Бату хана. стр 28-31. Москва 2002

[113] Digest of Turkish Studies-2001. J.E.Boyle. Posthumous title of Batu-Khan. p. 28-31. Moscow, 2002

**4. Тольбуга хааны зоос**

Нүүр талд: Тольбуга хааны овгийн тамга ба амьтаны дүрс байна. Ар талд: Монгол бичгээр "Тольбугын дэлдүүлсэн зоос".

Z. 10620

**4. The coin of Toli Buga Khan**

On obverse: the tamgha of Toli Buga's clan
On reverse: "Toli Buga struck" in Mongol script.

Энэ зоос нилээд хожуу мэдэгдсэн бололтой. Учир нь олонхи каталоги, товхимол, альбомд энэ зоосны тухай мэдээ байхгүй.



This coin was found much later. The reason is that there was no information in most of catalogues, publications and albums with regard to this coin.

**5. Тогтох хааны зоос**

Нүүрэн талд: Монгол бичгээр "Тогтоху"

N. 87

**5. The coin of Togtogu Khan**

On reverse: In Mongol script "Togtogu":

**6.** Нүүрэн талд: "Жани Бек" Жанибек хааны энэ зоосны тухай бүр 1837 онд Х.Френ номондоо дурьджээ[114]. Тэгэхдээ Жани Бек гэдэг нэрийг "Чимбек" гэж андуу бичсэн байдаг.

N. 100

**6. On obverse: "Janibek"**

H.Fren mentioned that the coin of Janibek Khan is included in his book[114] in 1837. However, he misspelled the name of Janibek as "Chimbek"

**7. Энэ зоосыг Укек хотод дэлдүүлжээ**[115]. Оросын Саратов хотын зоос цуглуулагч Ю.Е.Пырсов өөрийн цуглуулгадаа байгаа эдгээр зооснууд дээрхи бичээсийг тайлан уншихыг оролдсон байна.



**7. This coin was struck in Ukek city.**[115] Russian coin collector Yu.E.Pirsov from Saratov city tried to read the inscriptions on this coin.

### 8. Алтан орд

Токтамыш хааны монгол бичигтэй зоос.

Алтан Ордод гарсан Монгол зоосны дотор Тогтох хааны нэгэн гойд сонин зоос бий[116]. Монгол дөрвөлжин бичээстэй зоос Алтан Ордод үүнээс өөр гараагүй бололтой. Монголын зоосыг сайн судалсан хүний нэг болох Оросын эрдэмтэн В.Беляевын хэлснээр энэ зоос зөвхөн зургаан ширхэг мэдэгдэж байгаагийн нэг нь энэ номыг зохиогчийн цуглуулгад байгаа юм. Зоосны дөрвөлжин бичээсийг уншин тайлж тус болсон доктор Ц.Шагдарсүрэн, Р.Отгонбаатар нарт баярласнаа илэрхийлье.

### 8. Golden Horde

The coin on which the name of Toktamish Khan is inscribed in Mongol script.

Among the Mongol coins issued in Golden Horde there is one unusually interesting coin of Togtogu Khan[116]. It is possible that the coins with Phag's-pa inscription were never been struck in Golden Horde, except this coin. According to Russian scientist V. Belyaev who studied the Mongol coins very well, only six such coins are known, one of which belongs to the collection of the author of this book. I would like express my sincere gratitude to Dr. Ts.Shagdarsuren and R.Otgonbaatar for their help to read the Phag's-pa inscription on the coin.

**Нүүр тал.** Монгол дөрвөлжин үсгээр Тогтох хааны нэрийг бичсэн. (**ТУГДУНГ**)
**Ар талд:** Мажар хотод дэлдэв.
710 он (1310 он)

**On obverse:** The name of Togtogu Khan is inscribed in Phag's-pa script (**TUGDUNG**)
**On reverse:** Struck in Majyar. In 710 (the year 1310)

## 2.3 ЦАГААДАЙН УЛСАД

Цагаадайн улсад МЭГ-ний зоос олон гарсан боловч монгол бичээстэй нь хоёрхон хэлбэр мэдэгдэж байгаа юм.

1. Энэ зоосны зургийг Тюбенгений Их Сургуулийн цуглуулгын альбомоос авав[117].
**Нүүрэн талд: Цагаадайн тамга**
**Ар талд:** Монгол бичээсийн тайлбарыг уг каталог дээр алдаатай галигласан байгаа тул ойлгож унших боломжгүй байгаа юм.

## 2.3 IN CHAGHATAYIDS

Many coins of Mongol Empire were issued in Chaghatayids. However, only two types of coins with Mongol scripts are known.

1. This photograph of the coin is taken from the Album of collection of coins of the Tubengen University.[117]
**On obverse:** The tamgha of Chaghatay. **On reverse:** The transcription of the Mongol writing was wrong in this catalogue, thus it is impossible to read and understand the inscription

[114] Х.М.Френ, Монеты Хановъ Улуса Джучиева или Золотой Орды. Санктпетербург. 1932 #75, стр.. 11
[115] Древности. Нижегородского Поволжья. Нумизматический сборник. Нижний новгород 2000, выпуск III, стр. 71, 175
[116] Х.М.Френ, #26, tab. II, XVII

[114] Fren Kh.M. Coins of Khans of Zuchi's Khaganat and Golden Horde. Sankt-Peterburg. 1932
[115] Antiquities of Nijegorodskogo Povoljya. Numismatic collection. Issue III. Lower Novgorod. 2000. p. 71, 175
[116] Fren Kh.M. #26, tab. II, XVII

Дөрвөн мөр монгол бичээс байгаагийн доод хэсгүүд нь зоос дэлдэх үед хүрээний гадна талд үлдсэн, бас нилээд элэгдсэн байх тул үгийн төгсгөлүүдийг уншихад бэрхшээлтэй байна. Гэвч энэ дөрвөн мөр бичээсийн эхний хоёр мөрийг Монголын зоос судлаач, түүхийн хүрээлэнгийн ажилтан А.Пунцаг "Тэнгэрийн хүчү дор" гэж уншсан бөгөөд сүүлчийн хоёр мөрийн миний бие "Малик хан мэнгү" буюу "Малик (Мэлиг) хааны мөнгө" гэж уншсан болно. Энэ зоос Германы Тюбингений их сургуулийн цуглуулгад л ганц хувь байгаа бололтой.



The last lines of total four lines of Mongol writing were left out of margin of the coin while being struck and also because it has been worn out, it is difficult to read the endings of words. Nevertheless, the first two lines of the writing were read by A. Puntsag, a Mongolian numismatist and research scientist of the Institute of History, as follows: "under the power of heaven." I read the last two lines as "Malik Khan mungu" or "the coin of Malik Khan". It seems to be that the collection of Tubingen University in Germany has one copy of this coin.

2. Энэ зоосон дээрхи бичээсний дотор ганцхан "Орду" гэсэн үгийг монгол бичгээр бичсэн байдаг.
Уг зоосны талаар дэлгэрэнгүй өгүүлсэнийг энэ номын "Их ордод дэлдсэн зоос" хэсгээс үзнэ үү .

2. Only one Mongol word "Ordu" is inscribed on this coin.
His coin is described in the section "Coins struck in Golden Horde" of this book.

## 2.4 ИЛХААНТ УЛСАД

Илхаант улсын эрхшээлд тэр үедээ өндөр соёлтой, худалдаа, үйлдвэрлэл, гар урлал, зоосны гүйлгээ сайтар хөгжсөн Иран (Перс), Ирак, Гүрж, Армени, Азербайджан зэрэг орнууд орж байсан нь Илхаант улсад сорьц сайтай, гоёмсог сайн хийцтэй зоос үйлдвэрлэх нөхцлийг бүрдүүлж өгчээ. Иймээс Илхаант улсын зоосны бичээс, тэр тусмаа монгол бичгийн байдал нь үзүүштэй сонин, гоёмсог, тод сайхан харагддаг билээ.

Энэ улсын оршин тогтнож байсан 100 гаруй жилийн хугацаанд Монгол хааны нэр алдрыг монгол хэлээр, монгол бичгээр бичсэн алт, мөнгө, зэс зоос тус улсын нутаг

## 2.4 ILKHANIDS

Countries such as Iran (Persia), Iraq, Georgia, Armenia and Azerbaijan, which had a highly developed culture, trade, manufacturing, handcrafting and coin circulation were a part of Ilkhanids. This environment created a favorable condition for striking quality probe coins as well as for production of coins with beautiful design. Therefore, the writings and the condition of Mongol script can be clearly seen, they are beautiful as well as interesting.

The golden, silver and copper coins with an inscription of the name of Mongol Khans in Mongol language and script were in circulation everywhere in Ilkhanids in the course of over one

[117] Тобиас Майер. Тюбингений их сургуулийн Араб дахины зоосны цуглуулгын каталоги. Хойд ба Төв хэсэг. XVb Берлин. 1998. #92, х. 24-25

[117] Syllage Numorum Arabicorum Tûbingen. Nord und Ostzentrabsien. XVb Mittelasien II, Bearbeitet von Tobias Mayer. Berlin. 1998. #92, p. 24-25

дэвсгэрийн хаа сайгүй гарч үзсэн харсан болгонд МЭГ-г сануулж, Монгол хаадын суу алдар, монголчуудын бичиг соёлыг илтгэн харуулж байсан ажээ.

Илхаант улсын 17 хааны арваннэгийнх нь зоосон дээр монгол бичээстэй байна. Илхаадын зоосон дээрхи монгол бичээсийг галиглан тодорхой хэдэн төрөлд ангилж болно.

hundred years of its existence, and reminded to everyone who has seen it of Mongol Empire and demonstrated the greatness and fame of Mongol Khans as well as its language and culture.

Eleven Khans out of seventeen of the Ilkhanids struck coins with Mongol inscriptions. The Mongol writings on coins of Ilkhanids can transcribed and be classified into the following types:

## 1. Мөнгөн зоосон дээрхи бичээс

## 1. The writings on silver coins

Хагану нэрэбэр Абага ун дэлтгүлүг сэн

Khaganu nareber _____(in the blank space put the name of the Khan) deltgulug sen

Хагану нэрэбэр Ахмад ун дэлтгүлүг сэн

Struck by the Abaga in the name of Khagan

... Ahmad...

Хагану нэрэбэр Аргун ун дэлтгүлүг сэн

... Arghun ...

Хагану нэрэбэр Ринчиндорж дэлтгүлүг сэн

...Renchindorji..

Хагану нэрэбэр Байду ийн дэлтгүлүг сэн

...Baidu...

Абага (1265-1282), Ахмад (1282-1284), Аргун (1284-1291), Гайхат буюу Ринчиндорж (1291-1295), Байду (1295) хаадын зөвхөн мөнгөн зооснууд дээр ийм бичээстэй байгаа юм.

Алтан зоосон дээрх бичээс нь мөнгөн зоосны бичээстэйгээ үндсэндээ ижил боловч нэгэн онцлог ялгаа байгааг дор үзүүлье.

This writing is inscribed only on silver coins of Abaqa No.452 (1265-1282), Ahmad No.69 (1282-1284), Argun No.177 (1284-1291), Gaikhat or Rinchindorj No.341 (1291-1295) and Baidu Khagans No.527 (1295).

Although the writings in Mongol on golden coins are in general similar to writings on the silver coins, one specific difference is shown below.

## 2. Алтан зоосон дээрхи бичээс

## 2. The writing on golden coin

Хагану нэрэбэр Абага ийн дэлтгүлүг сэн аригу

Khaganu nereber _____(in the blank space put the name of the Khan) Deltgulug sen Arigu.

Treasure Struck by the Abaga in the name of Khagan

Хагану нэрэбэр Гайхату дэлтгүлүг сэн аригу

... Gayhatu ...

Хагану нэрэбэр Байду ийн дэлтгүлүг сэн аригу

... Baidu...

Энэ бичээсийн төгсгөлд байгаа Аригу (Ариху) гэдэг үгний тухай судлаачид урьд өмнө ерөөс тайлбарлаж байгаагүй бололтой. Энэ талаар холбогдох олон ном зохиол, каталог шүүрдэж үзсэн боловч чухамхүү энэ үгийн тайлбар огтоос үзэгдэхгүй байна. Монгол бичгээр бичсэн энэ үгийг галиглавал "аригу" гэж уншиж болох бөгөөд энэ нь монгол хэлний "**ариун**" гэдэг үгний язгуур байж болох юм.

Энэ үг Абага, Аргун, Ахмад, Ринчиндорж буюу Гайхат, Байду нарын зөвхөн алтан зоосон дээр байгаа нь алт бол бусад металыг бодвол илүү ариун, үнэтэй эрдэнэсийн зүйл гэдэг утга санааг

The word Arigu (Arihu) at the end of writing was never been explained before by researchers. In order to find explanation, the related books, publications and catalogues have been studied, however no explanation was found. The transcription of the word in Mongol is "**arigu**", which could be originated from the root of word "ariun" meaning "**pure**" in Mongol language.

As this word was only inscribed on golden coins of Abaga, Argun, Ahmad, Rinchindorj or Gaikhat, and Baidu, the Mongolian linguist specialized in ancient languages R. Otgonbaatar has presented a hypothesis that this word was inscribed on golden coins to

илэрхийлэх үүднээс энэ үг хэрэглэгдсэн байж магадгүй гэсэн таамаглалыг эртний монгол хэл судлаач Р.Отгонбаатар гуай дэвшүүлж, энэ үгийг цаашид сайтар нягтлан магадлаваас зохилтой гэсэн билээ.

express the meaning and context that the gold compared to other metals is more precious and has more value as a treasure, and suggested that this word should be further researched and studied.

### 3. Хасан (Хас хаан 1295-1304) хааны алт, мөнгөн зоосон дээрхи бичээс

### 3. The writings on golden and silver coins of Ghasan Khan (Khas khan 1295-1304)

Тэнгэрийн Хүчүндор Хасан ну дэлтгүлүг сэн

Under the power of heaven struck by Ghasan

Тэнгэрийн Хүчүндор Хасан ну дэлтгүлүг сэн

Under the power of heaven struck by Ghasan

Газан хааны энэ зоосны бичээсийг монгол уйгаржин, монгол дөрвөлжин, араб гурван өөр бичгээр үйлдсэн байдаг. Үүнд: Монгол бичгийн бичээсийг дээр үзүүлэв. Араб бичгээр "Газан Махмуд" гэж бичсэн ба дөрвөлжин бичгийн бичээсийн тухай энэ номын "Газан хааны зоосны тухай товчхон" гэсэн бүлэгт үзнэ үү.

The writing on coins of Ghazan Khan are inscribed in three scripts such as Uighur, Pags-pa and Arabic. The writings in Mongol script are shown above, and it is written "Ghazan Mahmud" in Arabic script. With respect to writings in Phags-pa you can refer to the part "In short about coins of Ghazan Khan" of this book.

### 4. Тагай Төмөр хааны зоосны бичээс

### 4. Writings on Tagai Khan's coins

**Эрхэм дээд Султан Тагай Төмөр хан** (Султан Адл-Эрхэм дээд Султан гэсэн араб үг)

Sultan adl (adl'-supreme in Arabic) Tagai Timur Khan

Дашрамд хэлэхэд би энэ зоосыг 2002 онд АНУ-ын нэрт судлаач Стефен Албумаас авсан бөгөөд Тагай Төмөрийн зоос олныг, тэр тусмаа монгол бичээстэй зоос нилээдийг үзсэн боловч энэ зоос шиг гоёмсог зоос ерөөс үзээгүй билээ. Хэдийгээр араб үгийг монгол бичгээр бичсэн боловч бичил-

Taking this opportunity, I would like mention that I received this coin from the famous American scientists Stephen Album in 2002. Though I have seen many of Tagai Timur's coins with Mongol writings, I have never seen such a beautiful coin. Even though the Arab word is written in Mongol script, the

гэ нь манай монгол бичгийн эртний сонгодог хэлбэртэй харьцуулбал Монголын Их Хааны тамга дээрхи бичилгэтэй яг ижил агаад уншихуйяа харагдахуйяа тод сонин, бас бахархамаар сайхан харагддаг билээ. Энэ зоос миний цуглуулгын бас нэгэн чимэг, манай монгол бичгийн гайхалтай сайхан дурсгал болох тул би ихэд нандигнан хадгалдаг юм.

writing compared to classic ancient Mongol script is same with the writings on tamghas of Great Khans and it looks very clear and beautiful as we see and read it. This coin is one of precious possessions of my collection and I cherish it as it represents the historic monument of Mongol script.

## 5. Зөвхөн хааны нэрийг монгол үсгээр бичсэн зоос

## 5. Coins only with an inscription of Khan's names in Mongol script

"Өлзийт Султан"

"Sultan Uljaitu"

"Бусаид"
(Абусаид хан)

"Busaid" (Abusaid Khan)

"Тагай Тэмүр"

"Taghai Temur"

"Сулейман"

"Suleiman"

"Нуширван"

"Nushirvan"

Орчин цагийн монгол хэлнээ "мөнгө" гэдэг үгийг үнэт метал, гүйлгээний мөнгө гэсэн аль ч утгаар нь адилхан бичиж унших ба монгол бичгээр [mung-gu] хэмээн бичнэ. Улсын мөнгөн тэмдэгт, шуудангийн марк сэлт дээр ч мөн ингэж бичдэг.

Гэвч XIII-XIV зууны монголчууд гүйлгээнд гаргасан зоосыг дээрхээс арай өөрөөр нэрлэдэг байсан бололтой. 1250-1260 оны орчимд Бухар, Самаркандад гарч байсан мөнгөлсөн зэс дирхэм зоосон[118] дээр байдаг араб منكو *мэнгу* гэдэг үг нь "Мөнх" үү, "мөнгө" үү гэдэг асуултад зоос судлаачид удтал хариу өгч чадахгүй андуурах явдал ч гарч байсан. Монгол хаадын зоосыг араб бичээстэй хийх нь зонхилж байсан тэр үед "Мөнх", "мөнгө" зэрэг хоёр өөр үгийг араб хэлнээ галиглан адилхан منكو [мэнгу] хэмээн зоосон дээр бичдэг байсан нь ийнхүү андуурагдах гол шалтгаан болсон байна. Тухайлбал, "Mengu khan" болон "Khani mengu" гэсэн үгтэй зооснууд гарч байсан бөгөөд аль алинд нь орж байсан "mengu" гэдэг үг зоосны бичээсийг өөр өөрөөр тайлахад хүргэж байв.

Гэвч үүний учрыг Оросын нэрт эрдэмтэн Е.А.Давыдович өөрийн алдарт бүтээлдээ "Mengu khan" гэвэл "Мөнх хаан", харин "Khani mengu" гэвэл "хааны мөнгө" болно гэж тайлбарласнаар[119] уг андуурлыг тайлжээ.

In modern Mongolian language the word "mungu" has the meaning of precious metal as well as of the money in circulation, and both meanings are read and written the same. It is written as [mung-gu] in Mongol script. The word is also written on banknotes and post stamps of Mongolia.

However, it seems that coins, which were in circulation, were called differently by Mongols in XIII-XIV century. For a long time the scholars could not answer to the question whether the Arabic writing منكو (mengu) on copper dirhams coated with silver[118] struck in 1250-1260 in Bukhara and Samarqand, meant "Munghe" or "mungu" and even there was a confusion in some cases. The main reason of this confusion is that when coins of Mongol Khans used to have Arabic inscription, the Mongol transcriptions of word "Munghe" and "mungu" in Arabic were written the same منكو "mengu". For instance, the word "mengu" inscribed on coins in phrases "Mengu Khan" and "Khani mengu", led to different interpretations of writings on coins.

However, the well-known Russian scholar E.A.Davidovich resolved the confusion in his famous publication by explaining that "Mengu Khan" means "Munghe Khagan" and if it is written "Khani Mengu" it would mean "Khan's coin"[119].

Ромын Пап ламд Гүюг хааны илгээсэн захидал дээрхи тамганаас үзвэл XIII зууны монголчууд Мөнх гэдэг үгийг [monghe] гэж бичдэг байжээ. Харин тэр үеийн монголчууд "мөнгө" гэдэг үгээ хэрхэн бичдэг байсан нь сонин юм.

XIII зууны монголчууд "мөнгө" гэдэг үгийг "Мөнгү", "мөнгөн" гэдэг байсан гэх боловч зоосон дээрхи бичээсээс өөр бичгийн тодорхой баримт олж үзэж чадсангүй.

2002 онд би Аргун хааны монгол бичээстэй нэг зоос олсон нь ердийн дөрвөн мөр бичээстэй бус харин таван мөр бичээстэй байв.

By examining the tamgha from the letter of Guyuk Khagan sent to the Roman Pope it can be seen that Mongols in XIII century used to write the word Munghe as [munghe]. Thus, it would be interesting to know how the Mongols wrote the word "mungu" or "coin".

It might be that the Mongols wrote the word "mungu" or "coin" as "mungu" and "mungun" in XIII century, but I could not find any other proof except the writings on coins.

In 2002 I found a coin of Argun Khan with Mongol writings and it had the five lines instead of usual four lines.

118 N.27
119 Е.А.Давыдович. "Денежное хозяйство Средней Азии..."

118 N.27
119 Davidovich E.A. Monetary economy in Central Asia

Хагану нэрэбэр Аргун ну дэлтгүлүг сэн мэнгү

The coin was struck under the name of Khagan Argun.

Тавдугаар мөрөнд байгаа үгийг яах аргагүй ***"мэ-нг-гу"*** гэж унших юм. Зоосны бичээс бүхэлдээ "Хааны нэрээр Аргуны дэлтгүүлсэн мөнгө" гэсэн байх тул энд "мөнгө" гэдэг үгийг ***мэ-нг-гу*** гэж бичсэн нь тодорхой байна. Үүнээс үзэхэд XIII зууны монголчууд "мөнгө" гэдэг үгийг ийнхүү **мэнг-гү** гэж хэлдэг, бичдэг ч байсан байж мэдэх юм. Ийм үгтэй өөр нэгэн зоосны зургийг дор үзүүлэв.

The fifth line should be read as "Me-ng-gu". The writing on the coin should be read as "The coin struck by Argun under name of the Khan" and it is clear that the word "mungu" was written as ***me-ng-gu.***

From above it could be possible that Mongols of XIII century used to say and write the word "mungu" as **meng-gu.** The photograph of the coin with the same inscription is given below.

## Хоёрдахь баримт[120].

Нуман тамгатай энэ зоосыг Мерв хотод дэлдүүлсэн бөгөөд монгол бичээсийн сүүлчийн мөрөнд "мэн-гу" гэдэг үг их тод сайн харагдана.




## Second document.[120]

This coin with a bow tamgha was struck in Merv and in the last line of Mongol writing the word "mengu" is seen clearly and well. Though it is not the same with writing "mung-gu"of the previous coin, but it is written "mun-gu".

Гэхдээ өмнө нь үзүүлсэн зоосон дээрхитэй адил "мэ-нг-гу" бус, харин "мэн-гу" гэж бичсэн байна.

Товчоор хэлбэл энэ зоосон дээр мөнгө" гэдэг үгийг "мэ-нг-гу" хэмээн их энхлэгтэй, "мэн-гу" хэмээн бага энхлэгтэй тус тус хоёр янзаар бичсэн байна.

XIII-XIV зууны Монголын зоосон дээрхи бичээсийг алдаатай бичсэн байх нь олонтаа тохиолддог зүйл. Энэ нь монгол үсгийн хэв хийсэн хүн алдаж бичсэн эсвэл араб галигаар нь галиглан бичсэн байх талтай юм.

Ямартаа ч монголын хаадын зоосон дээр мөнгө гэдэг үгийг "мэнг-гу" эсвэл "мэн-гу" гэж бичиж байсан баттай баримт нотолгоо нь дээрх хоёр зоос юм.

Есүнхэ мэргэнийг алдаршуулсан "Чингисийн чулуун бичиг" (1224-1225), Ромын Пап ламд Гүюг хааны илгээсэн захидал дээрхи хааны тамганы дардас

In brief the word money on this coin is written in two different ways as "me-ng-gu" and "men-gu".

It happened in many cases that Mongol writings on coins of XIII-XIV century often contained mistakes. It might be that either craftsman had made mistakes, while preparing the mold, or the writings were inscribed according to Arabic transcriptions.

Nevertheless, the above two coins are the firm documentation and proof that words "meng-gu" or "men-gu" were inscribed on coins of Mongol Khans.

The writings on "Stone's writings of Genghis Khan" made famous by Esukhei the Wise (1224-1225), the seal of Guyuk Khagan on the letter sent to the Roman Pope (1246), the

[120] А.Н.Петров. Очерки .... таб. 12, MI/1-1

[120] Petrov P.Kh. Essays... 12, MI/1-1

(1246), Илхаан Өлзийтөөс Францын Гоо Филипп хаанд илгээсэн захидал (1305), Газан хаанаас VIII Пап Бонифицид илгээсэн захидал (1302) зэргийн бичилгэ нь үнэхээр манай монгол бичгийн эртний сонгодог хэлбэр юм. Энэхүү сонгодог хэлбэр нь дан буюу давхар зурлагатайгаар бичигдсэн түүхийн баримт цөөнгүй бий.

МЭГ-ний зоосон дээрхи монгол бичээс нь бүхэлдээ эртний сонгодог хэлбэртэй боловч бичлэгийн хувд зарим ялгаатай байдаг.

letter of Ilkhan Ulziit sent to King Phillip (1305) and on the letter from Ghazni Khan to Pope Bonifatsio VIII (1302) represent the truly ancient form of Mongol classical script. There are many documents where this classical script is written with single and double layers of writing.

Although the Mongolian writings on coins of Mongol Empire have the ancient form of classical script, there are some differences with regard to its orthography.

## 2.5 ЮАНЬ УЛС

## 2.5 YUAN DYNASTY

**ЖИ ЮАНЬ ТОНГ БАО (Дөрвөлжин бичиг)**
**Жи-Юаны**
**1264-1294** он
Хубилай (Ши Зу) хаан
1260/1279-1294

Z. 7297

**ZHI YUAN TONG BAO (Pags-pa script)**
**Zhi-yuan 1264-1294**
Emperor Shi Zu (Qubilai) 1260/1279-1294

**ЮАНЬ ЖЕН ТОНГ БАО (Дөрвөлжин бичиг)**
**Юань Жен**
**1295-1296**
Төмөр Өлзийт (Жен Жон) хаан 1295-1307

Z. 91

**YUAN ZHEN TONG BAO (Pags-pa script)**
**Yuan-zhen**
**1295-1296**
Emperor Zheng Zong (Temur Oljeitu)
1295-1307

**ДА ДЭ ТОНГ БАО (Дөрвөлжин бичиг)**
**Юань Жен**
**1295-1296**
Төмөр Өлзийт (Жен Жон) хаан 1295-1307

**DA DE TONG BAO (Pags-pa script)**
**Yuan-zhen**
**1295-1296**
Emperor Zheng Zong (Temur Oljeitu)
1295-1307

**ДА ЮАНЬ ТОНГ БАО (Дөрвөлжин бичиг)**
**ХАИСАН ХҮЛҮГ (Ву Цү) хаан**
**1308-1311 он**

N. 225

DA YUAN TONG BAO.
Emperor Wu Tsu.
10 wen
**KAISHAN QULUG**
**1308-1311**

## 3. ЧИНГИС ХААНЫ АЛТАН ЗООС

Чингис хааны алтан зоос (динар)-ны тухай мэдээллийн хэд хэдэн сурвалжуудад бичсэн байдаг боловч Германы судлаач М.В.Тюбинхаузен (M.V.Tubenhausen) 1890 онд "Восточная монета Н.Р.Линевика. Записки" номондоо (Санкт Петербург, 1890, х. 303) дурьдсаныг анхдагч сурвалжийн нэг гэж үздэг. Үүний дараа үе үеийн судлаачид энэ зоосны тухай асуудал хөндсөн байдаг хэдий ч 1996 он хүртэл энэ алдарт зоосыг хэн ч нүдээр үзэж гараар бариагүй байжээ.

1996 онд Пакистаны Газна (Ghazna) хотын орчмоос нэгэн жижиг атлаа онцгой чухал зоосны сан олдсон нь эртний зоос судлаачдын дунд шуугиан дэгдээсэн байна. Эндээс Чингис хааны алдар нэрийг бичсэн алтан динар 58 ширхэг[121], Хорезмийн шах Ал-Ад Диний нижгээд тооны алтан зоос тус тус олджээ.

Энэ цагаас хойш Чингисийн алтан зоосны тухай судлаач цуглуулагчдын дунд эрэл сурал ихсэн, зоосны үнэ нь ч ихэд өссөн байна.

Олдсон зоосны дийлэнх нь тэр даруйдаа дэлхийн эртний үнэтэй зоосны арилжаа явуулдаг Классикал Нумизматик Групп компани (Classical Numismatic Group. Inc)-иар дамжин зах зээлд гарч худалдагдсан байна. Харин АНУ-ын нэрт судлаач, эрдэмтэн Стефен Албумын "A checklist of Islamic Coins" номонд дурьдсанаар Чингисийн алтан динар 100 орчим олдсон[122] байж болзошгүй ажээ.

С.Албумын каталогоос үзвэл Чингис хааны нэр, алдрыг дурьдсан зоос гурван янз, тухайлбал алтан динар (#1964, RR), мөнгөн дирхэм (#1967, R), мөнгөлсөн зэс зоос (#1968, RRR) тус тус байдаг ажээ.

Харин Оросын Эрмитажид байдаг "Чингис хаан, Чингисийн мөнгө" гэсэн үгтэй Самаркандын зоосыг[123] С.Албум чухам ямар учраас каталогтоо оруулаагүй нь тодорхойгүй байна.

[121] Вильям Спенглер. "Чингис хааны алтан динар бүхий зоосны санг нээсэн тухай" , Newsletter, ONS.147, 1996
[122] Стефен Албум. 1998. х.97-98



## 3. THE GOLDEN COIN OF GENGHIS KHAN

Several sources have written about the golden coin (dinar) of Genghis Khan, however one of the first sources mentioned about this coin is considered to be a book "Oriental coin of N. R. Linevik. Notes" (St. Peterburg. 1890, p.303) by the German researcher M.B. Tubinhausen. Since then scientists of different generations slightly touched the subject of this coin and until 1996 nobody had an opportunity to touch and even see this coin.

However, in 1996 a small number of important coins were found near Ghazna city of Pakistan, which caused a lot of sensation among numismatists. Fifty eight pieces of golden dinars[121] with an inscription of Genghis Khan's name and a few golden coins of Shah Al-Ad Din of Khwarizm were found.

Since then the search for golden coins of Genghis Khan has increased among researchers and collectors, and the price of coins has rapidly went up.

The major part of coins was sold to the market through the Classical Numismatic Group, Inc., which trades with valuable ancient coins. The famous American scientist and researcher Stephen Album, he wrote in his book "A checklist of Islamic coins" that it is possible that around 100 pieces of Genghis Khan's golden dinars are found.[122]

Accoding to Stephen Album's catalogue there are three types of coins of Genghis Khan, the golden dinar (#1964, RR), silver dirham (#1967, R) and silver coated copper coins (#1968,RRR).

However, it is unclear why a coin from Samarqand[123] with inscription "Genghis Khan and Genghis's mungu" from Hermitage is not included in Stephen Album's catalogue.

[121] William F. Spengler. "Hoard of Genghis Khan gold dinars recalls calamitous history" , Newsletter, ONS.147, 1996
[122] Stephen Album "A checklist of Islamic coins". Second Edition. 1998. p.97-98

Дашрамд хэлэхэд Чингис хааны энэ гурван зоосыг би өөрийн цуглуулгадаа олж авч чадсан бөгөөд харийн нутагт олон зууныг үдсэн эдгээр зооснуудыг түүхэн Эх орон, Монгол нутагт нь авчрах боломжтой болсонд миний хүчин зүтгэл, цуглуулгын маань үнэ цэнэ, зорилго, утга учир оршино.

1219-1221 онд буюу хижрийн 616-618 онд Чингис хаан Хорезмийг эзлэх аян дайны явцдаа Бухар, Самарканд, Термез, Балх, Мерв, Нишапур хотуудыг эзэлж, улмаар өмнө зүгт Газна, хойт зүгт Отрар хотыг нөлөөндөө авсан нь МЭГ-ний зоосон мөнгө гаргахад чухал түлхэц болсон түүхтэй.

Дээрх хотууд нь Дундад Азийн улс хоорондын гар үйлдвэрлэл, худалдаа арилжааны томоохон төвүүд төдийгүй Торгоны замын чухал уулзварууд болж байсан тул Дундад Азийн эдийн засгийн хөгжилтөд ихээхэн үүрэгтэй хотууд байв. Хорезмийн зоосон мөнгөний зонхилох үйлдвэрүүд дээрхи хотуудад байрлаж худалдаа арилжаанд хэрэглэх зоосыг олноор үйлдвэрлэж байжээ.

Чингис хаан Хорезмийг эзэлсний дараа буюу 1221 онд Газна, Бухар хотуудад Чингис хааны нэр алдрыг бичсэн алт мөнгөн зоос гаргах болсон нь Чингис хаан нэгэнт Хорезмийн эзэн болсныг хүлээн зөвшөөрч, нотолсон хэрэг байлаа.

Taking this opportunity I would like to mention that all three coins of Genghis Khan are in my collection, and all my efforts, the meaning and purpose of having a collection, its value are directed towards making it possible to bring the coins, which spent many centuries in foreign country, to its motherland or to Mongolia.

In 1219-1221 or 616-618 of Hijri the Genghis Khan conquests of Khwarizm, Bukhara, Samarqand, Termez, Balkh, Merv and Nishapur cities as well as establishes his influence on Ghazna in south and Otrar in the north, which had a significant impact on issuing coins of Mongol Empire.

Since these cities were not only major centers of handcrafting and trade in Central Asia, but also they were a crucial crossroads of the Silk Road. The cities played an important role in the economic development of Central Asia. The major mint centers of Khwarizm coins were located in those cities and they produced a significant number of coins for trade and commerce purposes.

After Genghis Khan conquered Khwarizm in 1221, golden and silver coins, with an inscription of the fame of Genghis Khan, were issued in Ghazni and Bukhara, which were a recognition as well as proof that Genghis Khan has become a Lord of Khwarizm.

Чингис хаан Хорезмийг эзлэв. 1219-1221




Genghis Khan conquested the Khvarazmian Empire . 1219-1221

[123] Е.А.Давыдович. стр. 16, таб. 1/4

[123] Davidovich E.A. Monetary economy... p. 16, Table 1/4

Их хааны алтан зоос (алтан динар)-ын байдлыг дэлгэрэнгүй үзүүлбэл.

The following is the golden coin (golden dinar) of the Great Khan:

## A. Газна хотод дэлдүүлсэн Чингисийн алтан зоос

## A. The Genghis's golden coin struck in Ghazni

N. 1



Нүүрэн тал: Гол дунд байгаа бичээс

Obverce: Central Legend

| | | |
|---|---|---|
| Хаадын хаан | Al-Khagan | The Khan of Khans |
| Аугаа | Al-a'dil | The Great |
| Их | Al-a'zam | Lord |
| Чингис хаан | Chingiz Khan | Genghis Khan |

الخاقان
العادل
الاعظم
جنكزخان

Хүрээгээр байгаа бичээс:

Marginal Legend:

ضرب هذا الدينار بلده غزنه فى شهور سنه ثمان عشره و ستمائه

| | | |
|---|---|---|
| Энэ зоосыг Газна хотод зургаан зуун арван найман онд дэлдүүлэв. | Duriba hadha al-dinar bi-balada Ghazna fi shahur sana thaman 'ashar wa sittamia | This coin is struck in Ghazni in six hundred eighteen |

**Ар тал: Гол дунд буй бичээс:**

La Ilaha illa Allah
Muhammad Rasul Allah
al Nasir Li-Din Allah
Amir al-Mu'minin

لاالهالاالله
محمد رسول الله
الناصرلدين الله
امير المومنين

**Reverse: Central Legend:**

There is no God but Allah
Muhammad is the Prophet of Allah
The Helper of the faith of Allah (Name of Abbasside Caliph at Baghdad)
Commander of the faithful

Энэ бичээсийн эхний хоёр мөрөнд исламын шашны үндсэн маани болох Калима, сүүлийн хоёр мөрөнд Багдадын Халиф Насирын нэр, цолыг бичжээ. Насир нь исламын шашны ихээхэн нэр хүндтэй халифуудын нэг байсан бөгөөд тэр үеийн Хорезмийн зооснууд дээр ихэвчлэн Насирын нэр алдрыг магтсан байдаг уламжлалыг дагаж түүний нэрийг бичсэн болохоос уг зоос Халиф Насиртай ямар ч холбоогүй юм.

The Kalima, fundamental mantra of Islamic religion, was written in the first two lines of the inscription, and the name and title of the Calif Nasir of Baghdad were written in last two lines. Nasir was one of the most respected halifs of Islamic religion and therefore, Nazir's name was engraved on coins of Baghdad of that time, according to the tradition that inscriptions carried Nasir's name proclaiming his fame. However, this coin didn't have any relationship with Nasir.

**Хүрээгээр байгаа бичээс:**

هو الذى ارسل رسوله بالهدى و دين الحق ليظهره على الدين كله

(Коран судрын IX-33 дугаар бүлгээс)

**Marginal Legend:**

(Quranic Surah IX-33)

Б. Бухарт дэлдүүлсэн "Чингис хаан" алтан динар

B. The golden dinar of Genghis Khan struck in Bukhara

z. 5001

| | | | |
|---|---|---|---|
| Чингис хаан | Chingiz Khan | جنكزخان | Chingis Khan |
| Аугаа их | Al a'dil | العادل | The Great |
| | Al a'zam | الاعظم | The Just |

Бухарт дэлдүүлсэн Чингис хааны алтан зоос нь Газнад гарсан зоосноос нилээд ялгаатай байна.

1. Газнагийн динар дээр Их хааны нэрийг бичээсийн сүүлчийн мөрөнд бичсэн байхад Бухарын зоосны эхний мөрөнд бичжээ.
2. Газнагийн динар "Al Khagan" буюу хаадын хаан, аугаа их эзэн хаан гэсэн цолоор эхэлж байгаа бол Бухарын динар дээр энэхүү хаадын хаан гэдэг үг байдаггүй онцлогтой.
3. Зоосны нүүрэн талд исламын шашны маани Калима байна. Газнагийн зоосон дээр үүний оронд Халиф Насирын нэр цолыг дурдсан байдаг билээ.

Чухам яагаад Чингис хааны зоосон дээр Насирын нэрийг тавих болов гэдэг асуулт уншигчдад төрж болзошгүй юм. Иймд үүнийг хамгийн энгийнээр тайлбарлая.

Багдадын Халиф гэдэг нь ислам шашинтнуудын нэг ёсны номын багш, Багдадын Халифатын хаан бөгөөд дүйцүүлбэл Далай лам, Ромын Пап лугаа зэрэг зиндааны хүн бүлгээ. Эртний язгууртан гарлын Аббасын (abbasides) угсааны тэрээр Ал Насир Ли-Дин Аллах гэдэг цолтой байв. Тэрээр 1180-1222 оны хооронд Халифын сэнтийд заларч байжээ. Энэ нь Чингис хааны үетэй давхцана. Халифын нэр цолыг зоосон мөнгөн дээр бичдэг байсан уламжлалаар Чингис хааны алтан динар дээр энэхүү Халиф Ал Насирын нэрийг бичсэн хэрэг юм. Энэ зоосны утга учрыг бүхэлд нь энгийн үгээр илэрхийлбэл: "Халиф Ал Насир Ли-Дин Аллахын үедэх Хаадын хаан, аугаа их хаан бол Чингис хаан мөн болой" гэсэн утгатай болно.

Ал Насирын дараа түүний хүү Захир халиф суугаад удалгүй нас барж, түүний дараагийн халиф нь Ал Мустаншир Биллак болов.[124] Түүний үе нь Өгэдэйн хаан суусан үетэй үндсэндээ таарна (623-640AH/1226-1242AD). Тэр үед Ал-Мустаншир-ийн алдар цолыг дурдсан мөнгөн зоос гарч байсан ба зоосны нөгөө талд "Бурхан тэнгэрийн хүчээр" гэсэн үгтэй байв. Энэ зоосыг Өгэдэйн зоос гэж тооцдог.[125]

[124] Рашид Ад Дин. Судрын чуулган. II дэвтэр, х. 26, 45
[125] N. 9



The golden coin of the Genghis Khan struck in Bukhara greatly differs from the one of Ghazni.

1. On the dinar made in Ghanzi the name of the Great Khan was engraved on the last line of the inscription, whereas it is engraved one the first line of the dinar made in Bukhara.
2. If the inscription of the dinar made in Ghanzi starts with "Al Khagan" or with the title "the Khan of Khans, the Great Lord", it is specific that on the inscription of dinar made in Bukhara there are no words "the Khan of Khans".
3. On obverse there is an inscription of Kalima, the Islamic mantra. Instead on coins made in Ghazni, there is an inscription of Kalif Nasir's name and title.

The reader might ask so why there is a name of Nasir on the coin of Genghis Khan. Therefore, I will try to explain it in a simplest way.

The Calif of Baghdad is a kind of a priest to Islamic religions, is a king to Baghdad Califat, and according to his rank and title he is equivalent to Dalai Lama and the Roman Pope. Having the ancient Abbasides ancestry, he was titled as Al Nasir Li Din Allah. He reigned on the throne of Kalif from 1180 to 1222, which coincides with reigning of Genghis Khan. According to tradition that the name and title of the Calif used to be engraved on the coins, the name of Calif Al Nasir was also engraved on the golden dinar of Genghis Khan. In simple words, the full inscription of the coin means "The Khan of Khans, the Great Khan is Genghis Khan during period of Calif Al Nasir Li-Din Allah".

After Al Nasir, his son Zahir reigned as a Calif, however he died very soon after whom Al Mustanshir had become a Calif[124] which coincides with reigning of Ugedei (623-640AH/1226-1242AD). During that period, silver coins had inscription proclaiming Al-Mustanshir and the reverse of the coin carried an inscription "Under the power of God and Heaven". The coin is considered as a coin of Ugedei.[125]

[124] Rashi ad Din. Second Book, p. 26, 45
[125] N. 9

Ал Мустаншираас хойшхи МЭГ-ний зоосон дээр халифуудын нэрний оронд Коран судрын Калимаг бичдэг болсон.

Дүгнэж үзэхүл, Газнад хийсэн Чингис хааны зоос 1221 оны үед гарсан бол Бухарт хийсэн зоос нь түүнээс хойш, Өгэдэй, Гүюг, Мөнх хаадын үед гарсан байх магадлалтай нь харагдаж байна.

Чингис хааны аугаа нэр алдрыг мөнхжүүлж, түүний суу билэг, алдар гавьяат түүхийг өгүүлж буй 800 жилийн өмнө гарсан энэхүү алтан зоосыг Монголын түүхэнд анх удаа Их хааны өлгий нутагт нь авчирч, Монгол түмэндээ толилуулж байгаадаа миний бие баяртай байна.

Энэ зоос манай улсын түүхэнд чухлаар үнэлэгдэх ёстой ховор нандин баримт болохын учир манай эрдэмтэн мэргэд онцгойлон анхаарч Монгол улсын түүхнээ зохих байрыг нь эзлүүлэн тавих буйзаа хэмээн гүнээ итгэж байна.



After Al-Mustashir, the Kalima of the Koran sutra were engraved on the coins of Mongol Empire instead of names of Caliphs.

In conclusion, if the golden coin of Genghis Khan was made in Ghazni in around 1221, it can be possible that coins made in Bukhara were issued later during the reigning of Ugedei Khagan, Guyuk Khagan and Munghe khagan.

I am glad to present this golden coin, which immortalizes the fame of Genghis Khan and states about his ingenious mind and the history of his merits, for the first time in Mongolian history by returning it to the homeland of the Great Khan and to the people of Mongolia.

As this coin should be valued as an important, rare and exclusive sample in Mongolian history, I strongly hope our scientists will take into account this fact and place it in a proper location of Mongolian history.

*1206 онд Монголын Тулгар төр байгуулагдав. Бурхан Халдун уул.*

*Burkhan Khaldun mountain where was established the Mongol Statehood in 1206 years*

## 4. "ИХ ОРДОД ДЭЛДҮҮЛСЭН" ЗООС

Хижрийн 662 он буюу 1264 онд Цагаадайн улсын Куча (одоогийн Хятадын Шинжаан муж) хотод нэгэн сонирхолтой зоос гарсан байдаг.

Zarb
Al-Ordu
Al-'a'zam

Их Ордод
Дэлдүүлэв

N. 36

Zarb
Al-Ordu
Al-'a'zam

In Great
Horde
was Struck

Эндээс "Их Ордод дэлдүүлэв" гэсэн нь чухам ямар утгатай болохыг тодруулах нь зоос судлалын хувьд чухал асуудал юм.

Монголчууд Их хааны ордон, өргөөг Их Орд гэнэ. Монгодын Эзэнт гүрний нутаг асар өргөн бөгөөд уудам, хаан, хан, хатад, ноёдын тоо тоймгүй олон, хаан харц хэн боловч нүүдэлчин уламжлалтай, XIII-XIV зууны үед хаад ноён зун өвлийн орд, өргөө олонтой, бас аян дайны явцад хааны орд буусан газрыг бас орд хэмээн нэрлэж байв. Иймд хааны орд чухам хаана, хэд байсныг тогтоох амаргүй. Алтан орд, Хөх орд, шар орд, ногоон орд, өвлийн орд, зуны орд гээд бүгд л орд. Эртний сурвалж бичгүүдэд, түүхийн ном зохиолуудад хааны өргөө ордны тухай их зүйл бий.

Гэвч Их Орд гэж юу болох, тэр нь хаана хаана байсан, ямар түүхтэй вэ гэдгийг судлах зорилго надад байхгүй тул цаашид дэлгэрэнгүй бичсэнгүй орхилоо.

Харин Монголын хааны зоосон дээр "Их Ордод дэлдүүлэв" гэж бичих болсны учрыг олох нь зорилго юм. Үүнийг миний өөрийн болон бусад цуглуулагчдын цуглуулгад байгаа зоос, ном хэвлэл, интернетээс олж харсан зооснууд дээр тулгуурлан жагсааж судлахыг оролдлоо.



## 4. THE COINS "STRUCK IN GREAT HORDE"

In 622 of Hijri or in 1264 a very interesting coin was issued in the city of Kucha of Chaghatayids (a city located in current Xinjiang province of China).

Hereto, it is an important question for numismatics to clarify what does the inscription "In Great Horde was Struck" mean. The Mongols used to call the palace and residence of Great Khan as the Great Horde. The Mongol Empire covered vast territory, the number of khans, queens and aristocrats were countless, khans as well as their servants were nomads, and during the XIII-XIV century khans had many summer as well as winter palaces and residences. During the wartime the place where the khan settled was also called horde. Therefore, it is almost impossible to find out where the hordes were located and how many there were. The Golden Horde, blue horde, yellow horde, green horde winter horde, summer horde are all hordes. There are many things that can be found with respect to khan's residency and palaces from ancient source materials and from historical books.

Since my purpose is not to study about what the hordes were, where they were located, what kind of history they had, I will stop here without writing more details.

However, my purpose is to find out why it was engraved "In Great Horde was Struck" on the coin of Mongol Khan. Therefore, I tried to list and study inscriptions based on my own collection and collections of other numismatists, books and internet sites.

**1.**

**Zarb**
**Al-ordu**
**Al-azam**

**Их Ордод**
**дэлдүүлэв**

**1.**

**Zarb**
**Al-ordu**
**Al-azam**

**In Great**
**Horde**
**was Struck**

Энэ зоос 1261-1266 онуудад Цагаадайн улсын эзэн байсан Алуг хааны үед гарчээ. Нүүрэн талд буй нудтэй онгин тамгыг Алуг хааны тамга байж магад гэж таамагладаг бөгөөд Чингис хааны наран тамганаас үүсгэмэл юм. Тамганы доод талд Аллах гэж бичээд эргэн тойронд нь Малик буюу хаан, эзэн гэсэн үгийг дөрвөн удаа бичжээ.

Зоосны ар талд "Их Ордод дэлдүүлэв" гэж арабаар бичсэн байна. Үүний эргэн тойронд "Kucha. 622" гэсэн байгаа нь их чухал мэдээлэл юм. Энэ хоёр бичээсийг нэгтгэн уншвал "622 онд Хааны Орд Кучад бууж байхад дэлдүүлэв" гэсэн утгатай болно.

This coin was issued during the reign of Alugh Khan of Chaghatayids in 1261-1266. The "nudtei ongin" tamgha on obverse is presumed that it could be a tamgha of Alugh Khan, which was originated from the "naran" tamgha of Genghis Khan. On the base of the tamgha it is engraved Allah, which is surrounded by the writing Malik meaning khan or lord and engraved four times.

On reverse it is engraved "In Great Horde was Struck" in Arabic script, surrounded with an inscription "Kucha. 622", which contains an important information. If weintegrate these to writings, it means "Struck in 622 when Khan's Horde settled in Kucha".

**2.**

Muhammed ibn Timur
Zarb
Ordu Bazar

Орд Базаарт дэлдүүлэв
Мухаммад Төмөр хан

**2.**

Muhammed ibn Timur
Zarb
ordu Bazar

Struck at Horde Bazar

**3.**

Zarb
Ordu Mu azzam
Abd Allah

Эрхэм дээд
Ордод дэлдүүлэв
Абд Аллах хан

**3.**

Zarb
Ordu Mu azzam
Abd Allah
Struck at Esteemed Horde

"Ordu Mu azzam" бичээс нь утгын хувьд "Ordu al-azzam" зоосны бичээсээс онц ялгарахгүй боловч утгын бага зэргийн ялгаа бий. Энэ нь уг хааны ордыг хүндэтгэн өгсөн чимэг бөгөөд харин өвөл зуны гэх мэт ялгааны учир ийнхүү өөр чимэг өгсөн байж болно.

Although the writings "Ordu Mu Azzam" and "Ordu al-azzam" do not differentiate in meaning, there is a slight discrepancy. It is an epithet given for the admiration to the khan's horde and it might be that the epithets were added to differ the winter or summer hordes .

**4.**

Ordu al-jadida

Эрхэм дээд Султан
Төмөр Хүтлүг
Шинэ Орд

z. 10011

**4.**

Ordu al-jadida
Esteemed Sultan
Tumur Khutlug

Энэ нь "Шинэ орд" гэсэн үг болох бөгөөд хааны орд хаа нэгтээ шинээр буух үеийг хэлсэн байж болзошгүй юм.

Дээрхээс гадна зүгээр "Ordu" гэсэн үгтэй зоос бас бий. Энэ ямар нэгэн онцлог утгагүйгээр, энгийнээр "Ордод" дэлдүүлэв гэсэн утгатай болно. Ийм зоос нилээд элбэг тохиолдоно.

This writing means "New Horde" and could be related to new settlement of khan's horde somewhere.

Besides above coins, there are several coins with an inscription "Ordu". Without any specific meaning, it simply implies that was struck "In Horde". These coins can be seen quite often.

**5.**

Sultan Adl
Ghyas Khan

Эрхэм дээд Гияс хан
(Ghyas ad Din
Muhhamed)
**Ордод** дэлдүүлэв 722

z. 10012

**5.**

Sultan Adl
Ghyas Khan

Энэ зоосны хийц нь Крымийн хийц болох нь илэрхий байгаагаас үзвэл Крымын хаа нэгтээ хааны орд бууж байх үед дэлдүүлсэн бололтой.

From the design of the coin it can be clearly seen that the coin could have been made in Qrim, probably it was struck when khan's horde settled somewhere in Qrim.

**6.**

Энэ зоос нь дээр үзүүлсэн бусад зооснооос ялгагдах онцлогтой юм.

**Нүүрэн талд:** Allah гэдэг үгийг томоор бичиж төв дунд нь тамга сийлжээ. Энэ тамга Гүюг хааны тамга болно.

**Ар талд:** Ordu-Al-'a'zam буюу Их орд. Зоосны ар, өвөр хоёр талын аль алины доод хэсэгт монгол үсгээр "Орд" гэж бичжээ.

N. 38

**6.**

This coin is different than coins displayed earlier.

**On obverse:** The word Allah is inscribed with capital letters and the tamgha is carved in the middle of the coin. This is a coin of Guyuk Khagan.

**On reverse:** It is inscribed Ordu-Al-'a'zam or Great Horde. On both sides of the coin on the base there is a word inscribed in Mongol script. By comparing the writing with several writings of other coins, it can be recognized that the word "Horde" is inscribed in Mongol script.

Зоосон дээр ямар нэгэн он цаг заагаагүй боловч уг зоос Цагаадайн хийцтэй, мөн Гүюг хааны тамга байгаа зэргээс үндэслэн үүнийг Гүюг хааны үед Цагаадайн улсад дэлдүүлсэн болохыг тогтоожээ.

## 5. ДА ЧАО ТОН БАО ЗООС

1257-1271 оны хооронд гарсан Да Чао Тон Бао (Da Chao Tong Bao) зоос их түүхтэй содон зоосны нэг юм.

Монголын Их хаан Мөнх 1259 онд өмнөд Сун улсыг эзлэхээр дайтаж яваад буцах замдаа тэнгэрт хальсаны дараа[126] Хубилай Их хаан суув. Хубилай улсын нийслэлийг аажмаар шилжүүлэн нүүлгэсээр 1271 онд "Их Монгол улс"-ын нэрийг "Их Юан Улс" болгон өөрчилөв[127].

1261-1271 он хүртлэх энэхүү 11 жилийн дотор Хубилай Хятадын нутагт Кайпин[128] (Шаньду-дээд нийслэл), Янь-жин (Бээжин)-д нийслэллэн сууж Хар Хорумыг бүр мөсөн орхисон[129]тул Хубилайн улс төр, эдийн засгийн бодлогын төв нь хэрэг дээрээ Хятадад шилжсэн байлаа.

Дурьдсан 11 жилийн дотор Хубилай Дао Чао Тон Бао зоосыг Хятадад гаргаж гүйлгээнд хэрэглэж байсан бололтой.

From private collection of A.Puntsag

Энэ зоосон дээрхи "Da Chao Tong Bao" гэсэн хятад бичээсийг дэлхийн болон хятадын нумизматикийн каталог, ном хэвлэлүүдэд "Great Dynasty Circulating Treasure" гэж орчуулсан байдгийг манай зарим судлаачид "Их төрийн гүйлгээний эрдэнэ" хэмээн хөрвүүлсэн байна.[130] Дао Чао Тон Бао зоосны бичээсийг англи хэлнээ өөр маягаар орчуулж болох хувилбарыг 2000 онд Нидерландын судлаач д-р T.D.Yih[131] гаргасан байдаг. Тэрээр "Da Chao" гэдэг Үгийг "Great Court" гэж орчуулж

[126] Монгол улсын түүх. Дэд боть, х. 182
[127] Монгол улсын түүх. Дэд боть, х. 197
[128] Ч.Далай. Монголын түүх. 12260-1388. Гутгаар дэвтэр. УБ, 1993, х.40
[129] Мөн тэнд, х. 41
[130] Ч.Энхбат, Б.Нямаа, Ц.Батсайхан. "Монгол Улсын зоос, мөнгөн тэмдэгт", УБ, 2002, х.
[131] www.zeno.ru/china/dazhao-silver



Although the coin doesn't contain any date, based on the design of Chaghatayids and tamgha of Guyuk Khagan, the coin is identified as the one struck in Chaghatayids during the Guyuk Khagan's reign.

## 5. DA CHAO TONG BAO COIN

The Da Chao Tong Bao coin issued in 1257-1271 has a rich history and is one of specific coins.

On the way back after his conquests to Southern Sun state in 1259, the Great Munghe Khagan passed away[126], after whom the Khubilai khagan took over the reign. Khubilai Khagan, by gradually moving the capital city, has renamed the "Great Mongol Empire" into "Great Yuan Dynasty" in 1271.[127]

Within these 11 years from 1261 to 1271, since Khubilai Khagan operated its capital in Kaipin[128] on the territory of China (Xiandu the upper capital) and in Yang-jin (current Beijing), and he completely abandoned Kara Khorum[129], thus the center of his political and economic policy, in reality, has shifted to China.

Within these 11 years Khubilai Khagan had issued Dao Chao Tong Bao coin and used them in circulation.

The Chinese writing on this coin is translated as the "Great Dynasty Circulating Treasure" in catalogues as well as in books of the world and Chinese numismatics. Some of our scientists translated it into Mongolian as "Ikh toriin guilgeenii erdene"[130]. In 2000 the Dutch scientist Dr.T.D.Yih[131] came up with another English version of translation of the writing on Dao Chao Tong Bao coin. He propounded that the word "Da Chao" can be interpreted as "Great Court". The English

[126] History of Mongolia, Second Book. p.182
[127] History of Mongolia, Second Book. p. 197
[128] Dalai Ch. History of Mongol (1260-1388) Volume III. Ulaanbaatar.1933
[129] same page, p. 41
[130] Enkhbat Ch, Batsaikhan Ts, Nyamaa B. "The Mongolian coins and banknotes", UB, 2002,
[131] www.zeno.ru/china/dazhao-silver

болно. Англи хэлний "court" гэдэг үг нь "Эзэн хааны ордон" гэсэн утгыг агуулах тул "Da Chao" гэдэг нь "Их Орд" гэсэн утгатай байна.

Тэгвэл энэ нь Шинжаанаас олдсон Цагаадайн улсын араб бичээстэй зооснууд дээрхи Al-Ordu al-'a'zam (араб, монголчилбол "Их Орд") гэдэг араб үгтэй утга нэг, тэр бичээсийн хятад хувилбар байж болох юм" гэж дүгнэжээ.

Англи хэлний тайлбар толь сөхөж харвал "court" гэдэг англи үгийг "residence of a sovereign; his familiy and officials"[132] гэж тайлбарласан байна. Үүнээс үзвэл "court" гэдэг нь хааны ордон, түүний гэр бүл, албатуудыг хэлэх юм.

Д.Алтангэрэлийн толь бичгээс үзвэл[133] "court" гэдэг үг "хааны ордон" гэдэг утгыг бас агуулдаг аж. Хятад хэлний "чао" гэдэг үгийг мөн "хааны орд, ордон" гэж орчуулж болохыг Хятад хэлний тайлбар тольд тэмдэглэжээ.[134].

Иймээс "Da Chao Tong Bao" гэдэг нь "Их Ордын гүйлгээний эрдэнэ (зоос)" гэсэн утгатай байж болох нь тодорхой байна..

Юан улс байгуулагдахаас өмнө, Хубилай хааны ордон Их Монгол Улсын нийслэл гэгдэж байсан Кайпинд байсныг бодолцвол "Да Чао" зоосыг Кайпинд гаргасан байх магадлалтай.

Иймд "Да Чао" зоос нь Монголын их хааны орд Кайпинд бууж байх үед гарсан гэж үзүүштэй санагдаж байна.

Зоосон дээрхи хааны тамгатай холбогдуулан судлахад энэхүү "Да Чао" зоосонд өөр нэгэн гайхамшигтай тал бий. Энэ нь уг зоосон дээр Монголын Их хаадын овгийн тамга байдаг явдал юм. Би Да Чао зоосны олон зураг харьцуулан ийм зүйл ажигласнаа дор сийрүүлье.

word "Court" has a meaning "residence of a sovereign", and hence "Da Chao" means "Great Horde".

Therefore, it can be concluded that the writing could have the same meaning with the Arabic word and could be the Chinese version of the Arabic inscription "Al-Ordu al-'a'zam" (in Arabic, means "Great Hordu" in English) on coins of Chaghatayids found in Xinjiang.

The word "court' in English Dictionary is defined as "the residence of a sovereign; his family and officials".[132] Therefore, the word "court" means the residence of a khan, his family and officials.

According to D.Altangerel's English-Mongolian Dictionary[133], the word "court" is also interpreted as "sovereigns residence".

In the Chinese Dictionary the Chinese word "chao" character can be interpreted as "residence or palace of a sovereign".[134]

According to this interpretation the writing "Da Chao Tong Bao" could clearly mean "Great Horde Circulating Treasure".

Before the establishment of Yuan Dynasty, if we take into consideration that the residence of Khubilai Khagan was in Kaipin of so called capital of Great Mongol Empire, it could be possible that "Da Chao" coin was issued in Kaipin.

Thus, the "Da Chao" coin should be considered as the coin issued during the settlement of Great Horde of Mongols in Kaipin.

With respect to the research concerning khan's tamgha on this coin, there is an extraordinary detail on "Da Chao" coin. There is a clan tamgha of Great Khans of Mongols on this coin.

After comparing many photographs of "Da Chao" coin, I observed the following details:

1. Зоосны ар талд Өгэдэй хааны буруу эргэлттэй дэгрээ тамга байна.




1. On reverse there is a counter clockwise rotating "degree" tamgha of Ugedei Khagan.

[132] Oxford Advanced Learner's Dictionary of Current English. Vol 1, Oxford, 1982, p.197

[133] Д.Алтангэрэл. Англи-Монгол хэлний толь

[134] 学生古汉语字典 上海辞书出版社 1995年 1064页 Хятад хэлний тайлбар толь,

[132] Oxford Advanced Learner's Dictionary of Current English. Vol 1, Oxford, 1982, p.197

[133] Altangerel D. English-Mongolian Dictionary

[134] 学生古汉语字典 上海辞书出版社 1995年 1064页 Chinese dictionary

2. Өгэдэй хааны зөв эргэлттэй дэгрээ тамгатай.

2. Ugedei Khagan's clockwise rotating "degree" tamgha.

3. Гүюг хааны тамгатай




3. Has the tamgha of Guyuk Khagan.

4. Мөнх хааны сэрээ тамгатай




4. Has the "seree" (trident) tamgha of Munghe Khagan.

5. Мөнх хааны сэрээ тамга, Өгэдэй хааны тамга хамт байна.




5. Both Munghe Khagan's "seree" tamgha as well as Ugedei Khan's tamgha are depicted on the coin.

Аригбөх Хубилай нар хаан ширээний төлөө цус урсган тэмцэлдэж байсныг бодохул Хубилай ийнхүү Өгэдэй, Гүюг, Мөнх хаадын овгийн тамгыг зоосон дээрээ тавьсан нь "Мөнхийн дараахь их хаан бол Аригбөх бус, харин Хубилай би мөн" гэсэн санаа агуулсан болов уу гэлтэй. Тийм ч учраас Хубилайн үед гарсан Да Чао зоосон дээр Аригбөхийн овгийн тамга байдаггүй бололтой.

Considering that there was a violent rivalry for the throne between Ariq Buga and Khubilai Khagan, the reason why Khubilai Khagan has depicted the clan tamgha of Ugedei Khagan, Guyuk Khagan and Munghe Khagan on his coin could imply the message that "the Great Khan after Munghe Khagan is not Ariq Buga, but myself the Khubilai". Therefore, there are no tamgha's of Ariq Buga's clan on Da Chao coins during the period of Khubilai Khagan's reign.

Харин Чингис хааны наран тамгыг орхигдуулах учиргүй баймаар санагдана. Үүнд хоёр тал байж болно.

1. Наран тамгатай зоос одоогоор олдоогүй байж болно.
2. Утга учир нь сайн тогтоогдоогүй байгаа Да Чао зоос хэд хэд байгаа бөгөөд эдгээр зооснуудын учир тайлагдахаас наашэнэ тухай асуудал тодорхойгүй байсаар байх болно.

Жишээлбэл, Да Чао зооснууд дотор:

ар тал нь цулгуй

Plain reverse

үл мэдэгдэх үсэг, тамгатай

Z. 8806

Unknown tamgha or word

дээрхи хувилбарууд бас байгаа бөгөөд цаашид өөр онцлогтой зоос илэрч гарч болзошгүй . Иймд энэ бол судлаачаа хүлээж байгаа асуудал юм.

"Да Чао Тон Бао" зоос нь Хятадад гарсан Монгол хаадын зоосон дээр овог овгийн тамга тавьсан цорын ганц тохиолдол бөгөөд Хубилай хаанаас хойшхи түүний удмын хаадын бүх зоос овгийн тамгагүй, харин дөрвөлжин ба хятад үсэгтэй гарч байсан билээ.

МЭГ-ний хаадын зоосны тамганы тухай асуудал үүгээр дуусахгүй юм. Мэдээллийн өргөн боломж бүрдсэн өнөө үед дэлхийн эртний зоос судлал, түүний дотор Монголын эртний зоосны судлал шинэ түвшинд гарах боломж бүрдэж байна. Иймд Монгол хаадын зоосны тамганы тухай шинэ шинэ мэдээ баримт цаашид илэрч гарах байх гэж найдаж байна.



The Genghis Khan's "naran" (sun) tamgha, in my opinion, can not be left without mentioning and there are two reasons for it.

1. The coin with "naran" tamgha could be that it is not found at the present.
2. There are a few Da Chao coins, which meaning and substance is not being explained, thus until the mystery will be untwined, this issue will still be obscure.

For example, among Da Chao coins there are different samples of coins, which have a: blank reverse field, unidentified lettering and tamghas as well as those with different details that can appear later on. Therefore, these coins are waiting for scientists to be studied.

The "Da Chao Tong Bao" coin is the only coin issued in China and where several clan tamghas are depicted. After the Khubilai Khagan, the coins of his following generations didn't carry the clan's tamgha, however had an inscription in Mongol square script and Chinese characters.

The issue of coins and tamghas of khans of Mongol Empire does not end here. Thanks to the availability of information in present days, the ancient numismatics of the world including the ancient numismatics of Mongolia can be brought to a new stage of development. Hence, I hope that new information and facts concerning the coins and tamghas of Mongol Khans will appear in the future.

## 6. ХАР ХОРУМЫН ЗООС

Би энд бүлгийг зүгээр нэг ийнхүү нэрлэсэнгүй. Ерөөс археологийн судлалд эртний зоосыг малтлага болон тохиолдлоор олдсон газрынх нь нэрээр тоймлон нэрлэж заншжээ. Тухайлбал, Отрар, Мерв, Керман, Бухар хавиас олдсон зоосыг тухайн газрынх нь нэрээр нэрлэж шинжлэх ухааны судалгаанд оруулсан байдаг. Үүнтэй уялдан Хар Хорумын гэж нэрлэгдэх зоос бий юу гэдэг асуулт гарч болно. Тэгвэл тийм зоос байгаа учраас энэ бүлгийг ийнхүү нэрлэсэн хэрэг юм.

МЭГ-нд багтаж байсан бүх улс орон, газар нутагт зоос гаргаж байсан түүхтэй. Алтан Орд, Цагаадай, Өгэдэйн Улс, Илхаадын Улс, Юан Улсад Монголын хаадууд их хэмжээгээр зоос гаргаж байж. Эзэнт улс бутарсанаас хойш ч Төмөрийн хаант Улс, Зүүнгарын хаант улсад, тэр ч байтугай Монголын эзэнт гүрэнд дагаар орсон жижиг ханлигуудад бас зоос дэлдүүлж байв.

Харин энэхүү асар том гүрний эзэд болсон Монголын Их хаадын нийслэл, тэдний орд өргөөгөө буулгаж, Их төрийг захирах бодлогоо боловсруулан явуулж байсан газар болох Хар Хорум (Khara Khorum) хотод Их хаадууд зоос дэлдүүлж байв уу гэдэг нь судлаачдын сонирхол татах судлууштай асуудал юм.

Хар Хорум хот Монголын Эзэнт Гүрний нийслэл, улс төр, эдийн засгийн томоохон тйв, үйлдвэр, худалдаа арилжааны чухал түшиц газар байсныг гадаад, дотоодын олон эрдэмтэд, түүхчид, археологчид нэгэнт судлан тогтоожээ.

Төр төвлөрч байгаа газар мөнгөгүй байх ёсон үгүй. Иймд Хар Хорум тухайн үеийнхээ мөнгө зоосны гүйлгээний томоохон төв байсан төдийгүй тэнд зоос үйлдвэрлэж байсан гэдэгт эргэлзэх аргагүй юм. МЭГ-ний харъяанд байсан том жижиг бүх улсад хийсэн зоос олдсон, судлагдсан байхад гагцхүү Хар Хорумд дэлдсэн зоосны тухай баримт одоогоор илрээгүй байгаа нь энэ сэдвийг улам бүр сонирхолтой болгож байна.

Хар Хорумын зоос байж болно гэдэгт эргэлзэх хүмүүс тааралддаг. Тэд үүнийгээ МЭГ-ний худалдаа, эдийн засгийн гол амьдрал урагш (Юан Улс) ба баруун тийш



## 6. THE COIN OF KARA KHORUM

I called this part the "Coin of Kara Khorum" for special reason. In archeology the ancient coins are named after the place where it was excavated or found accidentally. For example, the coins found in surrounding of Otrar, Merv, Kerman, Bukhara are named after the place where it was found and enlisted in scientific research. In this respect the question whether there is a coin named after Kara Khorum could be raised. The answer is, there is such coin and therefore this part of my book is named after this coin.

The coins were issued in all states and territories encompassed within the Mongol Empire. The Mongol Khans issued a numerous amount of coins in Golden Horde, Chaghatayids, Ugedei ulus, Ilkhanids and Yuan Dynasty. After the collapse of Mongol Empire, the coins were also struck in the Timurids, Jungar and, moreover, small surrendered khaganats.

However, it is an interesting question that should be studied and that would attract the interest of researchers, whether Great Khans struck coins in Kara Khorum, the city which was a capital of Great Mongol Khans, who ruled the Great Empire, and was a place where policies were formulated to administer the Great Statehood.

International as well as Mongolian scientists, historians and archeologists recognized that the city of Kara Khorum was a capital of Mongol Empire and was one of major political and economic centers as well as an important industrial and commercial basis.

If the state exists the money shall exist as well. Thus, undoubtedly, Kara Khorum was not only one of major money circulating centers of that time, but also the coins were made there. Although coins, struck in small and large khaganats subject to Mongol Empire, are found and studied as well, facts concerning the coins struck in Kara Khorum were not found, which makes this issue even more interesting.

There are people who hesitate that coins of Kara Khorum do exist. They try to explain it with a hypothesis that trade and economic life of Mongol Empire was directed towards

(Төв, Дундад Ази, Европ) чиглэж, Монголын төв нутаг, тэр тусмаа Хар Хорум хөгжлөөр хоцрогдсон, эзгүй хоосон шахуу байсан гэдгээр тайлбарлахыг оролддог. Хар Хорум эзгүй хоосон шахуу нутаг болж хувирсан нь үнэний хувьтай боловч тэрээр нэгэн үе Их Гүрний нийслэл болж, түм түжигнэж бум бужигнаж, мандан бадарч байсан гайхамшигт түүхтэй газар гэдгийг мартаж болохгүй юм. Их түүх нууцаа дэлгэх гэж яардаггүй тул манай түүхчид Хар Хорумын тухай бүгдийг судалж мэдэж хараахан чадаагүй байгааг эрх биш санууштай.

Хар Хорумтой холбоотой, Хар Хорумын гэгдэж буй зоосны талаар дор дэлгэрэнгүй тайлбарлая.

the south (to Yuan Dynasty) and west (to Central Asia and Europe), whereas the center of Mongol Empire including the Kara Khorum was underdeveloped and almost empty. Even though it is partly true that Kara Khorum had become an empty space, we should not forget that the city had a great history and at certain period of time it was a capital of an Empire, where masses, hundreds and thousands of people, lived and flourished. The great history is never in a hurry to disclose its secrets, and thus we should remember that our historians did not fully study all about Kara Khorum.

The following is an explanation to coins related to Kara Khorum and which are considered as the coins of Kara Khorum.

*Орхоны хөндий. Хар Хорум*

*Valley of Orkhon River. Kara Khorum*

## ЗООС №1 "КИСЕЛЕВЫН ЗООС"

1948-1949 онд Зөвлөлтийн эрдэмтэн С.В.Киселевын удирдсан зөвлөлт-монголын археологийн хамтарсан экспедицийн[135] хийсэн Хар Хорумын туурийн малтлагаар уг хотын богинохон атлаа гайхамшигтай түүхийн талаар шинжлэх ухааны үнэлж баршгүй нээлт хийжээ.[136]

Энэ малтлагын үеэр Хятадын Тан, Сун улсын голдуу 230 ширхэг зоос олдсоны дотор МЭГ-нд хамааралтай дөрвөн ширхэг зоос гарсан байна.[137]

Олдсон дөрвөн зоосны хоёр нь Юан Улсын Жи Да Тон Бао (Zhi Da Tong Bao), Да Юан Тон Бао (Da Yuan Tong Bao) зоос байсныг экспедицид оролцогчид зөв тогтоон тэмдэглэжээ. Үлдсэн хоёр зоосыг малтлагын 6 ба 11-р давхрагаас олсон бөгөөд "XIII-XIV зуунд хамаараах монголын зоос[138] боловч... ихэд үжирч муудсан тул чухам хэзээ гарсан, хэний зоос болохыг нарийн тодорхойлох боломжгүй" гэдэг дүгнэлтийг мөн гаргасан байна.[139]

Үүнээс хойш өнгөрсөн 60 шахам жилийн хугацаанд энэ хоёр зоосны бичээсийг тайлах оролдлого хийгдээгүй бололтой.

Энэхүү хоёр зоосны фото зургийг С.В.Киселевын номны 14-р таблицад №7, №8 гэж тэмдэглэн үзүүлжээ.

Номын дээрхи зургаас харахад хоёр зоос ихэд муудсан байдалтайн дээр зургийн хэмжээ жижиг, чанар төдийлөн сайнгүй-гээс нүдээр хараад зоосон дээрхийг ялгахад төвэгтэй байна.

Харин энэ хоёр зоосны зургийг томруулан сайтар тодруулж ажиглавал ерөнхий байдлыг нь товч төсөөлж болохуйц байна.

[135] Энэ экспедицид манай нэрт ахмад эрдэмтэд Х.Пэрлээ, Доржсүрэн, Навааан нар оролцжээ.
[136] С.В.Киселев. "Древнемонгольские города". Москва. 1965
[137] Мөн тэнд, 183-р х
[138] Мөн тэнд, 187-р х
[139] Мөн тэнд



## THE COIN NO.1 "THE KISELYOV'S COIN"

The Russian-Mongolian joint expedition[135] led by Russian scientist S.V.Kiselyov has discovered valuable scientific discoveries concerning the short, but extraordinary history of Kara Khorum, while excavating its remains.[136]

During excavations 230 pieces of coins, mainly of Tan and Sun States of China, were found, of which four pieces of coins were related to Mongol Empire.[137]

Two of four coins rightfully identified by researchers of expedition were Zhi Da Tong Bao and Da Yuan Tong Bao coins. The remaining two coins were found from the sixth and eleventh layers of excavations and it was concluded that "although the findings relate to Mongol coins[138] of XIII-XIV century, due to decayed and deteriorated state of coins it was not possible to definitely identify when the coins were made and whose coins are they".[139]

For about last 60 years since the conclusion was made, no attempts were tried to read the writings of two coins.

The following is the photograph of two coins from S.V.Kiselyov's book recorded under No.7 and No.8 in the Table 14.

From above photograph of the book, it is seen that besides the poor state of two coins and the small size as well as deficient quality of the photograph, it is difficult to distinguish the writings on coins.

However, if we magnify the photograph and make it clear, it is possible to outline the general state of coins.

[135] Энэ экспедицид манай нэрт ахмад эрдэмтэд Х.Пэрлээ, Доржсүрэн, Навааан нар оролцжээ.
[136] Kiselyov S.V. Ancient Mongol cities. Moskow. 1965
[137] same, p.183
[138] same, p.187
[139] same

## №7 зоосны байдал



Зоосны нүүрэн талд Мөнх хааны сэрээ тамга байна. Сэрээний хэмжээ нилээд том болох нь харагдаж байгаа бөгөөд ерөөс Мөнх хааны тамгатай зооснууд дотор ийм том тамга байх нь бараг үзэгдээгүй бололтой. Энэ бол уг зоосны нэгэн онцлог юм. Сэрээ тамганы зүүн талд араб үсгээр бичсэн Khan (хаан) гэдэг үг бүдэг харагдана. Харин сэрээ тамганы баруун талд талд байгаа үг ихэд балархай тул унших боломжгүй болжээ.

Сэрээ тамга болон Khan гэдэг үгээр баримжаалан үзвэл тамганы дээд талд Мөнх хааны нэр байх магадлалтай юм.

Иймд энэ зоосыг Мөнх хааны зоос гэж үзэж болно.

Зоосны ар талд буй араб хэл дээрх бичээс ихэд балархай юм. Зоосны бичээсийн тавь орчим хувийг баримжаагаар уншиж болохоор байгаа ч таамаглал төдий хуудуутай дүгнэлт хийхээс болгоомжлох үүднээс энэ тухай бичихээс одоохондоо түдгэлзэв.

## The condition of coin No.7

On obverse the coin bears "seree" tamgha of Munghe Khagan. It is seen that the size of "seree" is comparatively large and the tamgha of such large size among the coins of Munghe Khagan with tamghas are almost never seen. This is one of the special characteristics of the coin. On the base of tamgha the word Khan is inscribed in Arabic, which is seen obscurely. However, the lettering at the top of "seree" tamgha is too blurred, thus impossible to read.

Taking into consideration the "seree" tamgha and the word Khan, there is a possibility that the name of Munghe Khagan was inscribed on the top of the tamgha.

Thus this coin can be considered as the coin of Munghe khagan.

The inscription in Arabic on reverse of the coin is too blurred. Although fifty percent of the writing on the coin still can be approximately read, but to to avoid making unreasonable assumptions, I will refrain myself from writing about it.

## №8 Зоосны байдал

С.В.Киселевын экспедицийн малтлагаар олдсон хоёр дахь зоосны зураг №7 зоосны адилаар чанар муутай тул зураг дээрээс тайлбар хийхэд бэрхшээлтэй байна.



Нүүрэн талд толгойн хэсэг нь балархай тамганы дүрс байна. Тамганы доод хэсэгт тод харагдаж буй "хөл"-ийг харвал Аригбөхийн юм уу, Батын тамга байж болох юм. Гэвч балархай байгаа хэсгийг сайтар ажиглавал дугуй хэлбэрийн зураасны ором үзэгдэж байгаа нь энэ тамга Батынх гэдэг таамаглалд хүргэж байна.

## The condition of the coin No.8

The photograph of the second coin found during S.V Kiselyov's expedition, similar the photograph of the coin No.7, is also of deficient quality and thus, it is difficult to make explanations from the photograph.

By magnifying the photograph and carefully examining it:

On obverse top part of the coin there is a blurred form of tamgha. By examining the "khol" (means "leg" in Mongolian), which is clearly seen at the lower part of tamgha, it could be the tamgha of Ariq Buga Khagan or Batu Khan. However by examining the blurred parts, the round shaped imprints can be seen, which brings us to an assumption that it could be a tamgha of Batu khan.

Үүнийг лавтай сайн тодруулахын тулд 1974 онд Отрараас олдсон нэгэн зоосны зурагтай харьцуулж үзлээ.[140]

In order to definitely identify it, the coin was compared with a photograph of another coin found from Otrar in 1974.[140]

Киселевын зоос
(Хар Хорум)



Kiselyov's coin
(Kara Khorum)

Отрараас олдсон зоос



Otrar's coin

Энэ хоёр зоосны нэг талд байгаа тамганууд хоорондоо маш төстэй, ялангуяа Отрарын зоосон дээр тамганы толгой дугуй хэлбэртэй байгаа болох нь сайн харагдаж байна.

Харин Киселевын болон Отрарын зоосны нүүрэн талд буй тамганы толгойн ойролцоо нэгэн "эвэр" маягийн зураас харагдаж байгаа нь юун зураас болохыг таахад ч бэрхтэй байна.

К.М.Байпаков, В.Н.Настич нар өгүүлэлдээ энэ зоосыг Аригбөхийн тамгатай зоос гэж дүгнэсэн[141] нь чухам энэхүү үл мэдэгдэх "эвэр"-тэй холбоотой болов уу. Гэвч тамганы дээд талд дугуй дүрс илэрхий харагдаж байхад түүнийг Аригбөхийн тамга гэж хэлж болмооргүй бөгөөд Бат хааны удмынхны зоосон дээрхи тамга олон янзын хувилбартай байдаг тул энэ нь Бат хааны удмын хэн нэгэн хааны тамга байж болох юм гэж үзэж байна.

Харамсалтай нь Киселевын зоосны нүүрэн талыг тайлбарлах ямар ч боломжгүй балархай байгаа нь харьцуулалт хийхэд нөлөөлж байгаа юм. Ер нь ямар ч зоосыг биетээр нь үзэх буюу эсхүл маш сайн зураг үзэхгүйгээр чанар муутай зураг төдийхнээр

The tamghas on one side of both coins are very similar, especially it is clearly seen that the top part of tamgha engraved on the coin found from Otrar' coin has a round shape.

Although, there is a visible line on obverse side of Kiselyov's and Otrar's coins, which is similar to "ever" (means "horn" in Mongolian) shaped line and engraved close to top of tamgha, it is even difficult to assume what could be the line.

The conclusion made by K.M.Baipakov and V.N.Nastich in their article[141] is that the coin has a tamgha of Ariq Buga, is probably related to this unknown "ever" shaped line. Although the round figure can be clearly seen at the top of the tamgha, it should not be considered as a tamgha of Ariq Buga, as the tamgha on the coins of descendents of Batu Khan's lineage had many different versions. Thus it could be considered that this tamgha could belong to one of descendents of Batu Khan's lineage.

Unfortunately the obverse of Kiselyov's coin is blurred, which makes elucidating impossible and affects on comparative research. In general, it is difficult to come up with a full explanation of a coin by examining poor quality photograph or

[140] К.М.Байпаков, В.Н.Настич, "Клад серебрянных вещей и монет (Казахстан в эпоху феодализма)" Алма-Ата, 1981стр. 45-46, рис. 12/12

[141] Мөн тэнд, стр 45, тайлбар 16

[140] Baipakov K.M., Nastich V.M. The treasure of silver objects and coins of XIII century from Otrar (Kazakhstan during the period of feudalism) Alma-Ata. 1981

[141] same, p. 45

төгс сайн тайлна гэхэд хэцүү. Отрарын зоосыг судалсан В.Н.Настич гуай бол мэргэжлийн хувьд маш өндөр чадвартай хүн бөгөөд тэрээр уг зоосыг өөрийн нүдээр үзэж тайлбар хийсэн тул түүний дүгнэлтэд эргэлзэх аргагүй юм. Гэвч В.Н.Настич гуай "энэ зоосны гарал үүсэл, он цаг тодорхойгүй"[142] гэж тэмдэглэсэнтэй би санал нэг байна.

Иймд энэ бүхнээс үүдэн Киселевын экспедицийн хийсэн Хар Хорумы малтлагаар олдсон №8 зоосыг Аригбөхийнх үү, Батынх уу гэдэг нь эргэлзээтэй, сайн тогтоогдоогүй зоос гэж үзэх нь зүйтэй санагдана.

Эцэст нь тэмдэглэхэд Хар Хорумоос олдсон дээрхи хоёр зоосыг (№7, №8) чухам хаана хэзээ дэлдүүлсэн болох нь тодорхойгүй байгаа нь анхаарал татаж байгаа юм. Ялангуяа Мөнх хааны сэрээ тамганы хэмжээ ихэд том, хийц нь өвөрмөц байгаагаараа ийм тамгатай бусад зоосноос ялгаатай юм. Алтан Орд, Илхаант улс, Цагаадайн улсад Мөнх хааны сэрээ тамгатай зоос олныг дэлдүүлсэн боловч тамга нь ийм том байгаагүй билээ.

Хар Хорумоос олдсон дээрх зоостой ижил зоос өөр газар байгаа эсэхийг тогтоож, болж өгвөл биетээр нь судлавал илүү ур дүнтэй болох юм. Ер нь Хар Хорумд зоос дэлдээгүй гэх баталгаа нэгэнт байхгүй тул хэзээ нэгэн цагт тэнд дэлдсэн зоос олдоно гэж найдаж байна.

## ХАР ХОРУМААС ОЛДСОН БУСАД ЗООСНУУД

1980 онд Монгол-Зөвлөлтийн хамтарсан экспедици Хар Хорумд малтлага хийх үед Эрдэнэ Зуу хийдийн ойролцоо "Маамуу толгой" газарт байсан булшнаас Алтан Ордны хоёр жижиг мөнгөн зоос гарчээ. Энэ тухай археологич Г.Мэнэс, Д.Баяр нар "Түүхийн судлал" сэтгүүлийн 23-рт нийтлүүлсэн байна.[143]

Уг булшинд толгойг нь урд зүг харуулж тавьсан эмэгтэй хүний шарил байсан бөгөөд шарилын эрүүний ясны ойролцоо нэг, гавлын ясан дотроос (аман дотор байсан бололтой) нэг тус тус 2 мөнгөн зоос гарчээ.[144]

without examining the coin itself or wihthout having a high quality picture. V.N.Nastich, who studied the Otrar's coin, is highly competent professional and since he examined the coin himself and made explanation, there should be no doubts about his conclusion. I agree with the note of V.N.Nastich that "the origin as well as the date of the coin are not clear".[142]

Therefore, it is doubtful whether the coin No.8 found during the excavations of Kara Khorum city by Kiselyov's expedition belongs to Ariq Buga or Batu Khan and it would be right to consider the coin unidentified.

Finally it could be noted that coins found from Kara Khorum (No.7, No.8) still attract attention as the date and the place where they were struck are not identified. Especially, the large size of Munghe khagan's "seree" tamgha, its unique design makes this coin different from others with identical tamghas. Although coins of Munghe khagan with "seree" tamgha were struck in large amounts in Golden Horde, Ilkhanids and Chaghatayids, their tamghas were never of such big size.

There would be more results if coins identical to the one found from Kara Khorum can be identified and examined. Since there is no proof that coins were not struck in Kara Khorum, I hope coins struck there will be found sometime.

## OTHER COINS FOUND FROM KARA KHORUM

In 1980 during the excavations in Kara Khorum by Mongolian Russian joint expedition, two small silver coins of Golden Horde were found from the grave in a place "Maamuu tolgoi" located near the Erdene Zuu monastery. The archeologists G.Menes and D.Bayar published an article about the findings in the "History Study" journal in issue No.23.[143]

There was a body of a woman placed in a grave head facing to the south and two pieces of silver coins were found near the chin bone and from inside of the scull (probably was placed in a mouth) of a body.[144]

[142] К.М.Байпаков, В.Н.Настич, стр. 47
[143] Г.Мэнэс, Д.Баяр. "Два погребения Монгольского времени из Кара-Корума". Studia Historica. Tomus XXIII, p.127-136
[144] Мөн тэнд, х.128

[142] Baipakov K.M., Nastich V.M. p. 47
[143] Menes G., Bayar D. Two burials of Mongol period from Kara Khorum. Historical Study. Tomus XXII, Fasc.14. p.127-136
[144] same, p.128

Үүнээс гадна гарсан 8 ширхэг хятад зоос шарилын доод хэсгээр байрласан байв.

Шарилын гавлын ясны хөндийгөөс олдсон хоёр жижиг мөнгөн зоосыг тэр үеийн ЗХУ-д аваачиж шинжлүүлэхэд 1375 он (хижрийн 743 он)-д Алтан Ордны Сарай Ал Жадида (Sarai Al-jadida) хотод цутгасан, Жанибек хааны зоос болохыг нэрт зоос судлаач эрдэмтэн Г.А.Федоров-Давыдов тогтоожээ.[145]




Нийтлэгдсэн зургаар зоосны талаар нарийвчлан мэдээлэх боломжгүй байна. Юутай ч миний цуглуулгад буй Жанибек хааны нэрийг Монгол үсгээр бичсэн зоостой дээрх хоёр зоосны нэг нь адил харагдаж байна. Энэ бол яах аргагүй Алтан Ордны зоос мөн.

Moreover, 8 pieces of Chinese coins were placed at the foot of the grave.

The two small coins found from the scull of the body were investigated in former USSR and were identified by the famous numismatist G.A.Fyodorov-Davidov that the coins were minted in Sarai Al-jadida city of Golden Horde in 1375 (743 of Hijri) and belonged to Janibek Khan.[145]

It is impossible to know more by examining the published photograph. Nevertheless, one of above coins resembles with the coin in my collection, which has an inscribed name of Janibek khan in Mongol script. It is inevitably the coin of Golden Horde.

Миний цуглуулгад байгаа Жанибэк хааны зоос.

Janibek Khan's coin (from my collection)

Алтан Ордны зоос Хар Хорум орчмоос олдсон нь Хар Хорум болон Алтан Ордны хоорондын харилцааг судлахад ач холбогдолтой материал юм.

Хар Хорумоос Их Монгол улс, Юан улс, Алтан Ордны болон Хятадын Тан, Сун улсуудын зоос олдсон нь Хар Хорум хот тухайн үеийнхээ үйлдвэр худалдаа, мөнгөний гүйлгээний томоохон төв байсан гэдэг үндэслэлийг нотолж байгаа түүхийн бас нэгэн чухал баримт мөн болно.

The finding of Golden Horde coin from Kara Khorum has an important significance for the study of relationship between Golden Horde and Kara Khorum.

Finding of coins of Mongol Empire, Yuan Dynasty, Golden Horde as well as Chinese states such as Tang and Sun from Kara Khorum city is an important historical fact, which proves that Kara Khorum was one of large industrial, trade and economic centers, where money was in circulation.

[145] Г.Мэнэс, Д.Баяр. х.130

[145] Menes G., Bayar D. p. 130

## 7. ТЭНГЭРИЙН ХҮЧҮН ДОР

Монголчууд тэнгэрийг шүтнэ. Тэнгэр бол монголчуудын хувьд бурхан юм. Тиймээс Тэнгэр, Бурхан хоёрыг адилтган үзэж "Бурхан Тэнгэр минь" гэж залбирна. Ялангуяа XIII зуунд Тэнгэрийн хүчүнд бишэрч, бүхийг Тэнгэрийн хүч, Тэнгэрийн зарлигт нийцүүлж байлаа. Улс гүрнүүдийг Тэнгэрийн хүчээр хурааж, төр улсаа Тэнгэрийн хүчээр байгуулсан Чингис хааны хувьд ч Тэнгэр бол Бурхан юм. Түүний зарлиг лүндүн "Мөнх Тэнгэрийн хүчүн дор..." гэж эхэлж байлаа.

Тэгэхээр Тэнгэрийн хүчүн дор гэдэг үг өөрөө XIII зууны монголчуудын түүх, амьдралтай салшгүй холбоотой юм. Гүюг хаанаас Ромын Пап ламд илгээсэн (1246) захидал дээрхи хааны тамганы дардасыг уншвал "Мөнх Тэнгэрийн хүчүн дор..." гэж эхэлсэн байдаг. Энэ бол Монгол төрийн албан захидал. Тэгвэл энэ үед төрөөс гаргасан зоосон мөнгөн дээр энэ үг байдаг уу гэвэл байдаг ажээ.

**1. Өгэдэй хааны зоос**
"be quvvat-e aferidegar" - by the Power of the Creator (630-640AH/1228-1238AD)
"Тэнгэрийн хүчүн дор" (Перс хэлээр)
Энэ зоос Өгэдэй хааны үед гарсан боловч хааны нэр бичээгүй онцлогтой юм.

N. 9

Зоосны нүүрэн талд буй бичээс дэхь بقوت افريد گارعالم гэсэн перс, араб үгнүүдийг судлаачид "By the Power of God" гэж англи хэл рүү орчуулсан байдаг. Стефен Албумын каталогид энэ бичээсийг "By the Power of Creator" гэж орчуулсан[146] ба "Creator" гэдэг үгийг англи хэлний тайлбар толь баримтлан үзвэл мөн л "the God" гэдэг утгатай аж.[147]

Үүнийг үгчлэн монголчилбол "Бурханы хүчээр..." гэх болно. Д.Алтангэрэлийн толь бичигт "God" гэдэг үгийг "бурхан" гэж орчуулсан боловч "(Oh) (my) God!" гэх уулга үгийг "Тэнгэр минь!" гэж орчуулж болохыг бас заажээ.[148]

[146] Стефен Албум. ...., A-1978K, x.98
[147] AS Hornby. Oxford Advanced Learner's Dictionary of Current English. Vol. I. Oxford. 1982. p.201
[148] Д.Алтангэрэл. Англи-Монгол толь. x 191



## 7. BY THE POWER OF HEAVEN

Mongols worship the heaven. The heaven is a God for Mongols. Thus, they assimilate both the heaven and God into one and pray to "God and Heaven of mine". Especially in XIII century Mongols had a strong belief in powers of Heaven, as well as acted in conformity with powers of Heaven and according to decree of Heaven. As for Genghis Khan the Heaven was a God, he conquered countries and states and established his own state with a power of Heaven. His decree starts with the words "By the eternal power of Heaven...".

Therefore, the phase "by the power of Heaven" is indivisible part of Mongolian history and livelihood. If we read the imprint of a seal of the letter sent from Guyuk Khagan to Pope (in 1246), it commences with words "By the eternal power of Heaven...". This is an official letter of Mongol State. Thus to the question if there are any coins issued by this State, the answer will be yes.

**1. The coin of Ugedei Khagan**
This coin was issued during the Ugedei Khagan's chronology and also has an inscription "Under the Power of Heaven". However, it is a special coin, because there is no name of Ugedei Khagan on it.

The Persian and arabic words بقوت افريد گارعالم on obverse of the coin are translated by researchers into English as "By the Power of God". In Stephen Album's catalogue the writing is translated as "By the Power of Creator"[146] and the word "Creator" according to the English dictionary also means "God".[147]

The Mongol interpretation would be "By the power of God". In D.Altangerel's English Mongolian Dictionary the word "Burkhan" is translated as "God", however the expression "(Oh) (my) God" was pointed out to be translated as "Tenger mini" ("My Heaven" in Mongolian).[148]

[146] Stephen Album. "A checklist ...", A-1978K, p.98
[147] AS Hornby. Oxford Advanced Learner's Dictionary of Current English. Vol. I. Oxford. 1982. p.201
[148] Altangerel D. English-Mongolian Dictionary. p.191

XIII зууны монголчуудын хувьд Бурхан нь Тэнгэр байсныг нийтээр мэдэх тул "God" гэдэг англи үгийг бид "Тэнгэр" гэж ойлгож болох буйзаа.

Since the general public is aware that for Mongols in XIII century the God was a Heaven, the English word "God" can be perceived as "Heaven".

## 2. Гүюг хааны зоос

N. 12

Тэнгэрийн хүчүн дор Гүюг хааны боол Давид. Тифлист дэлдүүлэв.

## 2.The coin of Guyuk Khagan

By the power of Heaven David the slave of Guyuk Khagan (shall administer) Struck in Tiflis

Гүюг хааны гарт байсан Их Төрийн тамга "Мөнх тэнгэрийн хүчүн дор..." гэдэг үгтэй байхад түүний зарлигаар гарсан зоосон дээр ийм үг байхгүй гэх газаргүй. Тэнгэрийн хүчээр гэх үү, Бурханы хүчээр гэх үү? гэдэг бол зөвхөн орчуулгын асуудал бөгөөд бид түүх, уламжлал, шашин шүтлэг, монгол сэтгэхүйдээ тулгуурлан энэ үгийг "Тэнгэрийн хүчүн дор" гэж тайлах нь зүйтэй юм.

Энэ зоосыг Гүржийн хаан IV Давид Нарин Монголд дагаар орсныхоо нотолгоо болгож Монголын Их Хаан Гүюгийн нэрээр 1247 онд Тифлист дэлдүүлжээ.

If the phase "By the eternal power of Heaven" was engraved on the state seal belonging to Guyuk Khagan, there is a rationale that these words were inscribed on coins issued by the decree of Guyuk Khagan. It is a matter of translation whether to phase it "By the power of Heaven" or "By the power of God", and thus based on our history, tradition, religion and Mongolian mentality it should be right to phase is as "By the power of Heaven".

This coin was struck for the Great Khagan Guyuk by the Georgian King David IV in Tiflis in 1247 as a guarantee that Georgia has surrendered to Mongol Empire.

## 3. Мөнх хааны зоос

1252 онд (Хижрийн 650 он) буюу Мөнх хааны үед Гүржид гарсан перс бичээстэй өөр нэгэн зоосыг авч үзье.[149]

## 3. The coin of Munghe Khagan

Let's examine another coin with Persian writing issued in Georgia during the reign of Munghe Khagan in 1252 (in 650 of Hijri).[149]

**Нүүрэн тал:** Тэнгэрийн хүчүн дор Ертөнцийн хаан (падишах)Мөнх хааны ивээлээр 650 он.

**Ар тал:** Багритидын Георгийн хүү Давид хаан Тифлист дэлдүүлэв.

Мөнх хааны энэ зоос Гүюг хааны зоосны адилаар "Тэнгэрийн хүчүн дор..." гэсэн үгээр эхэлсэн бичээстэй бөгөөд мөн Тифлис (Гүрж)-т гарчээ.

By the power of Heaven The King of the Universe (padishah) Under the patronage of Munghe Khagan Year 650.

King David -the son of George of Bagridit have struck in Tiflis.

Like the coin of Guyuk Khagan, the coin of Munghe Khagan starts with an inscription "By the power of Heaven" and was issued in Tiflis (Georgia).

[149] Е.А.Пахомова "Монеты Грузии", Тбилиси. 1970. стр.132-133

[149] Pakhomov E.A.Coins of Georgia. Tbilisi. 1970

### 4. Хасан хааны зоос

Илхаант улсын Хасан (Ghazan 694-703AH/1295-1304AD) хааны үед зоосон дээрх "be quvvet-i" буюу "тэнгэрийн хүчүн дор" гэдэг үг бүрэн монголчлогдсон байдаг.

**Тэнгэрийн хүчүндор Хасаны дэлтгүлүгсэн**

N. 166

(Багдад, Хижрийн 700 он) Ийнхүү XIII-XIV зууны үеийн МЭГ-ний зарим хаадын зоосон дээр "Тэнгэрийн хүчүн дор..." гэдэг үгийг перс, монгол хэлээр бичсэн байгаа нь манай түүхийн бас нэгэн сонин баримт юм.

### 1. The coin of Ghazan Khan

The phrase "bi kuvvet-i huda' or "by the power of heaven", inscribed on coins during the reign of Ghazan Khan (694-703AH/1295-1304AD) of Ilkhanids, is paraphrased as a Mongol phrase.

